

0000-21



ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЙШН (TSX: ERD)

2018-03-12

Канад улс, Нова Скотиа муж, Халифакс хот, Вайс гудамж 99, Метрополитан Плейс 1480 тоот



Басунаа



ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Компанийн тухай:

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн (цаашид "Компани" гэх) нь Канад улсын хууль тогтоомжийн дагуу 2000 оны 07 сарын 14-нд байгуулагдан, 2004 оноос эхлэн Торонтогийн Хөрөнгийн Бирж (TSX:ERD) дээр хувьцаа нь олон нийтэд арилжаалагдах болсон.

Компани нь Монгол Улсад ашигт малтмалын ордын хайгуул, төсөл хөгжүүлэлтийн үйл ажиллагааг 2002 оноос эрхэлж эхэлсэн. Голлох үйл ажиллагаа нь өндөр агууламж бүхий томоохон алт болон алт-зэсийн ордуудыг бага зардлаар нээн илрүүлэхэд төвлөрдөг.

Өргөн хүрээтэй, шинэлэг, тодорхой аргачилал бүхий геологийн хайгуулын үр дүн Компанийн анхаарлыг Монгол Улсын баруун өмнөд хэсэгт хандуулаад байна. Оюу толгой төслийн алт, зэсийн ордуудыг багтаадаг чулуулгийн бүстэй ижил геологийн бүтэц бүхий газар нутагт хийсэн хайгуулын ажил нь ихээхэн амжилттай болж, компанийн эзэмшдэг 4 хайгуулын тусгай зөвшөөрлөөс 2 тусгай зөршөөрлийн талбайд 7 алт болон зэсийн хуримтлалтыг нээн илрүүлсэн. Эдгээр нээлтүүд нь газрын гадаргад ойр, алтны өндөр агуулгатай бөгөөд Монгол Улсын баруун өмнөд бүсэд Монгол ба БНХАУ-ын хилтэй ойр төслийн талбайд оршдоггоороо онцлогтой. Үүнээс: Баян Хөндий болон Алтан Нар төслүүдэд эцсийн шатны өрөмдлөг болон судалгааны ажлууд хийгдэж, олборлолтын шатруу ойртож байна. Энэхүү Үнэт цаасны танилцуулгын (цаашид "Танилцуулга" гэх) хүрээнд Компанийн (4,000,000 хүртэлх) энгийн хувьцааг ("Энгийн хувьцаа") Монголын Хөрөнгийн Биржид давхар бүртгүүлэн олон нийтэд санал болгон арилжаална.

Зах зээлд арилжигдаж буй хувьцааны тоо:

146,400,586 Энгийн Хувьцаа

Санал болгох хувьцааны тоо, төрөл:

4,000,000 хүртэлх Энгийн Хувьцаа

Санал болгох хувьцааны үнэ:

Олон нийтэд санал болгох хувьцааны үнийг Санхүүгийн Зохицуулах Хорооны ("СЗХ") шийдвэр гарахаас өмнө Компани болон Андеррайтерууд харилцан зөвшилцсөний дүнд тогтооно. Энэхүү үнэ нь Торонтогийн Хөрөнгийн

Бүрэл



2018-03-12



Биржид арилжаалагдаж буй Компанийн хувьцааны ханшийн 10 хоногийн жигнэсэн дундаж үнээс 10%-ийн хөнгөлөлттэй байна. Нийт санал болгох хувьцааны тоо нь олон нийтэд арилжиж, босгох хөрөнгө болох 1.2 сая канад доллартай тэнцэх хэмжээний Энгийн Хувьцаа байна. Нэгж хувьцааны үнэ болон санал болгох тоо ширхэгийн мэдээллийг СЗХ-нд бүртгүүлэхээс өмнө Торонтогийн Хөрөнгийн Биржид танилцуулан, зөвшөөрлийг авсан байх шаардлагатай.

Нийт хувьцаанд эзлэх хувь: 2.7% хүртэлх Энгийн Хувьцаа

Анхдагч зах зээлд гаргах арга: Тогтоосон үнийн аргаар

Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт: Хайгуулын өрөмдлөг, нөөцийн тооцоолол ба техникийн судалгаа

Баерина



2018.03.12



ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДАД АНХААРУУЛАХ НЬ

Үнэт цаасыг Монголын Хөрөнгийн Бирж бүртгэсэн нь уг үнэт цаасны эрсдлийн талаар аливаа баталгаа гаргаагүй болохыг анхаарах нь зүйтэй. Энэхүү үнэт цаасыг худалдан авах замаар хөрөнгө оруулалт хийх нь хөрөнгө оруулагч Таны хувьд **ЯМАГТ ЭРСДЭЛТЭЙ** үйлдэл байдгийг онцгойлон анхаарч, үнэт цаасны танилцуулга, үнэт цаас гаргах ажиллагааг сайтар анхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргахыг зөвлөж байна.

УРЬДЧИЛСАН ТААМАГЛАЛ

Уг танилцуулга нь урьдчилсан таамаглалуудыг агуулсан болохыг үүгээр мэдэгдэж байна. Урьдчилсан таамаглал нь дараах үгсээр тодорхойлогдоно. Үүнд: (урьдчилан сэрэмжлүүлэх), (төлөвлөх), (зорилго), (эрэх хайх), (итгэх), (төсөвлөх), (үнэлэх), (тооцоолох), (стратеги), (ирээдүй), (боломжит байдал), (таамаглах), (байх) зэрэг ирээдүй цагт хамааралтай үгсээр илэрхийлэгдэнэ.

Уг урьдчилсан таамаглал нь урьд болж байсан болон ирээдүйд болох бодит баримт биш ба зөвхөн Компанийн ирээдүйн төлөвлөгөө, стратеги, төсөл, эдийн засгийн нөхцөл байдалд тулгуурлан гарсан одоогийн үзэл баримтлал, магадлал болон таамаглал болно. Энэхүү урьдчилсан таамаглалд тодорхой эрсдлүүд болон тодорхойгүй байдлууд орох бөгөөд эдгээр эрсдэл, тодорхойгүй байдлуудын талаар Эрсдлийн тухай хэсэгт танилцуулсан.

2018-03-12 J

Балрине



МОНГОЛЫН ЭРЭН ТӨРӨД
МОНГОЛЫН УТАСНЫ ТӨСВИЙН
БҮРТГЭВ / 01
0000-25

СЭХ
ОН СЭР . 0199
БҮРТГЭВ
№ 01

Үнэт цаасны танилцуулга бэлтгэхэд оролцсон байгууллагуудын мэдээлэл

Хуулийн зөвлөх:



Нэр: **Өмгөөллийн ИЭлСи ХХН**
Хаяг: Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 1-р
Хороо, Ардчиллын өргөө, 6 давхар
Утас: (976) 77118193
Вэбсайт: www.elclawoffice.mn

Техникийн зөвлөх :



Нэр: **КьюЭмСи ХХК**
Хаяг: Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг,
ЮНЕСКО-ийн гудамж, Реженси
Резиденс, 202 тоот
Утас: (976) 77111100
Вэбсайт: www.qmc.mn

Тэргүүлэх Андеррайтер:



Нэр: **БиДиСЕК ҮЦК ХК**
Хаяг: БиДиСЕК ҮЦК ХК-ийн байр,
Залуучуудын өргөн чөлөө
27/1, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар
хот, Монгол улс
Утас: (976) 11 313108
Вэбсайт: www.bdsec.mn

2018-03-12

Баярцал

УЛААНБААТАР ХОТ
МХБ-ийн гишүүн
Андеррайтер
Брэкер, дилерийн
"БИДИСЕК"
ХХК-УА
1115205447
2018.03.12



000026



Хамтрагч Андеррайтер:



Нэр: "Голомт Капитал ҮЦК" ХХК
Хаяг: 401 тоот, Очир төв, Олимпийн гудамж
12/1, Улаанбаатар 210644, Монгол Улс
Утас: (976) 70121530
Вэбсайт: www.golomtcapital.com

Санхүүгийн Зөвлөх:



Нэр: "Эм Ай Би Жи ҮЦК" ХХК
Хаяг: 100 тоот, Монруд ХХК-ийн байр,
Чингэлтэй дүүрэг, Нэгдсэн Үндэстний
гудамж 6/6, Улаанбаатар, Монгол улс
Утас: (976) 11 362620
Вэбсайт: www.mibg.mn

2018 03 12 J

Бсерие





Агуулга

Үнэт цаасны танилцуулга бэлтгэхэд оролцсон байгууллагуудын мэдээлэл.....	5
Товчилсон үгс, Мэргэжлийн нэр томъёо.....	13
НЭГ. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ.....	16
1.1. Үнэт цаас гаргагчийн хаяг	16
1.2. Үнэт цаас гаргагчийн бүртгэлийн мэдээлэл.....	16
1.3. Үнэт цаас гаргагчийн бүтэц.....	17
1.3.1. Үнэт цаас гаргагчийн одоогийн хувьцаа эзэмшигчид.....	18
1.3.2. Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн Удирдах Зөвлөл	19
1.3.3. Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн дэргэдэх хороод, дотоод хяналт.....	20
1.3.4. Үнэт цаас гаргагчийн гүйцэтгэх удирдлагын тухай мэдээлэл.....	22
1.3.5. Бизнесийн ёс зүйн дүрэм	23
1.3.6. Ашиг сонирхлын зөрчил	23
1.3.7. Гэрээ болон хамтын ажиллагаа.....	24
1.4. Хөрөнгийн бүтэц.....	26
1.4.1. Компанийн нийтэд арилжаалагдаж буй хувьцааны мэдээлэл	27
1.4.2. Ногдол ашигийн бодлого.....	28
1.5. Үнэт цаас гаргагчийн салбар ба зах зээлийн тухай мэдээлэл	28
1.5.1. Монгол Улсын макро эдийн засгийн орчин	28
1.5.2. Үнэт цаас гаргагчийн салбарын орчин, зах зээлийн тухай	31
1.5.3. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны түүх.....	35
1.5.4. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны өнөөгийн байдал.....	36
1.5.5. Байгууллагын нийгмийн хариуцлага.....	64
1.6. Санхүүгийн үзүүлэлтүүд.....	66
1.6.1 Санхүүгийн үзүүлэлт	66
1.6.2 Үйл ажиллагааны онцлог: Хөрвөх чадвар болон хөрөнгийн талаар.....	66
1.6.3 Санхүүгийн эрсдэлүүд.....	66
1.7. Үнэт цаасны танилцуулга бэлтгэхэд оролцсон этгээдүүд.....	67
1.7.1 Хуулийн зөвлөх компани	67

Бацрмаа





1.7.2	Аудитын дүгнэлт	69
1.7.3	Үнэлгээ	70
1.7.4	Андеррайтер	71
1.7.5	Мэргэшсэн мэргэжилтэн	74
1.7.6	Хараат бус техникийн зөвлөх компани	75
ХОЁР. ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ		78
2.1.	Үнэт цаас гаргах тухай холбогдох шийдвэр, үнэт цаас гаргагчийг төлөөлөх эрх бүхий этгээд	78
2.2.	Үнэт цаасны анхдагч бүртгэлийг хийлгэсэн гадаад улсын арилжаа эрхлэх байгууллага болон үнэт цаасны зохицуулагч байгууллагад мэдэгдэх тухай	80
2.3.	Хувьцаа эзэмшигчдийн эрх	80
2.3.1.	Анх бүртгүүлсэн улсын болон Монгол Улсын хууль тогтоомжийн зохицуулалтын зөрүүтэй байдал, үүний улмаас үнэт цаас эзэмшигчид учирч болох эрсдэл, эрхээ хэрэгжүүлэх боломжийг хангах зохицуулалт	81
2.4.	Нийтэд санал болгох үнэт цаасны тухай	87
2.4.1.	Хөрөнгө оруулалтын боломжийн талаар	87
2.4.2.	Нийтэд санал болгох хувьцааны тоо хэмжээ	89
2.4.3.	Хувьцааны үнэ тогтоох тухай	89
2.4.4.	Анхдагч зах зээлд арилжаалах аргачлал	90
2.5.	Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт	92
2.5.1.	2018 оны Техникийн хөтөлбөр болон төсөв	92
2.5.2.	Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт	96
2.6.	Санхүүгийн таамаглал	96
ГУРАВ. ЭРСДЭЛИЙН ХҮЧИН ЗҮЙЛС БА УДИРДЛАГА		97
3.1.	Эрсдэлийн хүчин зүйлс	97
3.1.1.	Эрдсийн хайгуул, ашиглалтын салбарын эрсдэл	97
3.1.2.	Хөрвөх чадвар, санхүүжилтийн эрсдэл	97
3.1.3.	Монгол Улсын хууль, эрх зүйн орчны эрсдэл	98
3.1.4.	Тусгай зөвшөөрөл, түрээс, зөвшөөрлийн эрсдэл	98
3.1.5.	Дэд бүтэцтэй холбоотой эрсдэл	99
3.1.6.	Үл даатгагдах эрсдэлүүд	99
3.1.7.	Ашиг сонирхлын зөрчил	100

Баярмее



2018-03-12



3.1.8. Валютын эрсдэл 100

3.1.9. Металлын үнийн хэлбэлзэл, түүнээс үүсэх эрсдэл..... 100

3.1.10. Байгаль орчны болон зохицуулалтын шаардлагууд..... 101

3.1.11. Боловсон хүчний эрсдэл 101

3.1.12. Улс төрийн эрсдэл..... 101

3.1.13. Уламжлалт эрсдлүүд..... 102

3.1.14. Өрсөлдөөн 102

3.1.15. Эзэмшлийн хувь буурах 102

3.2. Эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө 102

Хавсралт материал:

- Хавсралт 1 Үнэт цаас гаргагчийн улсын бүртгэлийн гэрчилгээ, компанийн дүрэм, орчуулгын хамт
- Хавсралт 2 "Эрдэнэ Монгол" ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ, компанийн дүрэм
- Хавсралт 3 "Аниан Ресорсиз" ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ, компанийн дүрэм
- Хавсралт 4 "Лидер Эксплорэйшн" ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ, компанийн дүрэм
- Хавсралт 5 "Эрдэнэ Монгол" ХХК-ийн эзэмшиж буй тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар
- Хавсралт 6 "Аниан Ресорсиз" ХХК-ийн эзэмшиж буй тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар
- Хавсралт 7 "Лидер Эксплорейшн" ХХК-ийн эзэмшиж буй тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар
- Хавсралт 8 Хуулийн зөвлөх компанийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар
- Хавсралт 9 Хуулийн зөвлөх компанийн хуульчдын тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар
- Хавсралт 10 Хуулийн дүгнэлт (Монгол Англи хэл дээрх)
- Хавсралт 11 КэйПиЭмЖи (KPMG) компанийн бүртгэл
- Хавсралт 12 Үнэт цаас гаргагчийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, орчуулгын хамтаар
- Хавсралт 13 "БиДиСЕК ҮЦК" ХК-ийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар
- Хавсралт 14 Үнэт цаас гаргагчийн андеррайтер компанитай хийсэн гэрээний хуулбар
- Хавсралт 15 Андеррайтерийн дүгнэлт
- Хавсралт 16 "Голомт Капитал ҮЦК" ХХК-ийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар
- Хавсралт 17 "Кью Эм Си" ХХК-ийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар
- Хавсралт 18 "Кью Эм Си" ХХК-ийн хөндлөнгийн дүгнэлт

2018-03-12

Баермее





Хавсралт 19 Үнэт цаас гаргах тухай эрх бүхий этгээдийн гаргасан шийдвэр, орчуулгын хамт

Давхар бүртгэлтэй холбоотойгоор дагалдах материалууд

- Материал 1 Монгол Улсад хоёрдогч бүртгэл хийлгэх гэж байгааг ТХБ-д албан ёсоор мэдэгдсэн мэдээлэл, орчуулгын хамт
- Материал 2 Анх бүртгүүлсэн 2004 оны 3 сарын 4-ний өдрийн үнэт цаасны танилцуулга, Монгол хэлээр орчуулсан товч танилцуулга
- Материал 3 Бургаст талбайд хийсэн 2016 оны хайгуулын ажлын тайлан
- Материал 4 Цэнхэр Номин талбайд хийсэн 2016 оны хайгуулын ажлын тайлан
- Материал 5 Улаан талбайд хийсэн 2016 оны хайгуулын ажлын тайлан
- Материал 6 Хөндий нэртэй талбайд хийсэн 2016 оны хайгуулын ажлын тайлан
- Материал 7 "Зуун Мод" молибден-зэсийн ордыг ил аргаар ашиглах тухай Монгол Улсын Эрдэс Баялгийн Зөвлөлөөс Техник, эдийн засгийн үндэслэлийг авч хэлэлцсэн хурлын шийдвэр


Хүснэгт

Хүснэгт 1-1 Төлөөлөн удирдах зөвлөл.....	19
Хүснэгт 1-2 Компанийн удирдлагын тухай мэдээлэл.....	22
Хүснэгт 1-3 Хөрөнгийн бүтэц.....	26
Хүснэгт 1-4 Одоогийн томоохон хувьцаа эзэмшигчид.....	26
Хүснэгт 1-5 Компанийн энгийн хувьцааны мэдээлэл.....	27
Хүснэгт 1-6 Компанийн энгийн хувьцааны үнийн өөрчлөлт.....	28
Хүснэгт 1-7 Монгол Улсын эдийн засгийн үзүүлэлтүүд.....	30
Хүснэгт 1-8 Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй геологийн судалгаа.....	32
Хүснэгт 1-9 Компанийн хайгуулын тусгай зөвшөөрлийн мэдээлэл (Эрдэнэ Монгол ХХК).....	37
Хүснэгт 1-10 Компанийн ашиглалтын тусгай зөвшөөрлийн тухай (Аниан Ресорсиз ХХК).....	37
Хүснэгт 1-11 Компанийн хайгуулын тусгай зөвшөөрлийн мэдээлэл (Лидер Эксплорэйшн ХХК).....	38
Хүснэгт 1-12 Нээлтийн бүс болон Алтан нар ордын хайгуулын үр дүн.....	50
Хүснэгт 1-13 Алтан Нар төсөл – 2017 оны өрөмдлөгийн ажлын онцлох хэсгүүд.....	53
Хүснэгт 1-14 Хойд Холбоон өрөмдлөгийн ажлын онцлох үр дүнгүүд.....	56

2018-03-12

Б. Ариун





Хүснэгт 1-15 Алтан Нар төсөл – Ашигт малтмалын нөөцийн тооцоо..... 58

Хүснэгт 1-16 Зуун Мод төсөл дэх хүдэржилт 63

Хүснэгт 1-17 Өмгөөллийн нөхөрлөлийн тусгай зөвшөөрөл..... 68

Хүснэгт 1-18 Өмгөөллийн ИЭлСи ХХН-ийн хуульчдын гэрчилгээ..... 68

Хүснэгт 2-1 Хувьцаа гаргахын өмнө болон гаргасны дараах томоохон хувьцаа эзэмшигчдийн бүтэц..... 81

Хүснэгт 2-2 Канад улс болон Монгол улсын хууль тогтоомжийн зохицуулалтын зөрүүтэй байдал..... 81

Хүснэгт 2-3 2018 оны төсөв (канад доллар) 95

Хүснэгт 2-4 2018 оны зардал (төслөөр) 95

График

График 1-1 Компани ба охин компаниудын бүтэц 17

График 1-2 Компанийн зохион байгуулалтын бүтэц..... 18

График 1-3 Одоогийн хувьцаа эзэмшигчид 26

График 1-4 Улсын төсөв ба ДНБ-нд эзлэх хувь..... 30

График 1-5 Монгол Улсын тэргүүлэх салбарууд 31

График 1-6 Монгол Улсын геологийн судалгааны түвшин 32

График 1-7 Хувийн хөрөнгө оруулалтаар хийсэн хайгуулын ажил (тэрбум ₮) 33

График 1-8 2017 онд шинээр бүртгэгдсэн нөөцийн ордууд (ашигт малтмалаар)..... 33

График 1-9 Дэлхийн алтны эрэлт, нийлүүлэлт 34

График 1-10 Алтны агуулга болон олборлолтын өртөг 36

График 1-11 Дэлхийн алтны нээлтүүд..... 34

График 1-12 Монгол улсын алтны үйлдвэрлэл..... 35

График 1-13 Дэлхийн алтны үнэ..... 35

График 1-14 Монгол улсын Баруун урд зүгт байрлах Компаний бүсүүдийн онцлох мэдээллүүд..... 36

График 2-1 Анхдагч зах зээлд байршуулах 90

График 2-2 Монгол Улсын зах зээлд байршуулах явц..... 90


Зураг

Зураг 1-1 Компанийн хувьцааны график (TSX:ERD) 28

Баярмал



2018 - 03 = 124



Зураг 1-2 Баян Хөндийн төслийн газрын зураг 39

Зураг 1-3 Баян Хөндийн төслийн Геологийн зураг ба өрмийн цооногуудын байршлын зураг..... 42

Зураг 1-4 Зарим үр дүнг онцгойлон тэмдэглэсэн Баян Хөндийн 2017 оны хөндлөн зүсэлт 44

Зураг 1-5 Нүдэнд үзэгдэх алт бүхий чөмгөн дээж БХД-231; 1 метрт 2,200 гр/т алттай 45

Зураг 1-6 Алтан Нар талбайн байршлын зураг..... 49

Зураг 1-7 Нээлтийн бүсийн план зураг ба нөөц тэлэлтийн боломжууд 54

Зураг 1-8 Нээлтийн бүсийн дагуу зүсэлт (баруун хойш харж байгаагаар) 55

Зураг 1-9 Улаан талбай: Байрлал, хөрсөн дэх зэсийн сарнилын хүрээ, цахилгаан хайгуулын ажил..... 62

2018 - 03 = 12

Баярмисе





Товчилсон үгс, Мэргэжлийн нэр томъёо


Дараах хүснэгтэд уг Танилцуулгад ашиглагдсан тодорхойлолт, товчилсон үгсийг тайлбарлав.

Товчилсон үгсийн тайлбар	Тодорхойлолт
өөрчлөлт, хувирал	Чулуулгийн эрдэс судлалын бүтцэд физикийн эсвэл химийн аргаар гаргаж ирсэн аливаа өөрчлөлт
Аниан	Компанийн охин компани Аниан Ресорсиз ХХК
хэвийн бус сорьцжилт	Бусдаас өөр мөн эдийн засгийн үнэ цэнэтэй байх магадлалтай Үнэ цэнийн төрөл, хэмжээг нь тодорхойлохын тулд хүдэр, эрдэсд хийх химийн дүн шинжилгээ
ТУЗ	Төлөөлөн Удирдах Зөвлөл
ирмэгт хөрзөн	Хэлтэрхий, их бага хэмжээний өнцгөөс бүрдсэн чулуулаг нь илүү нарийн ширхэгтэй материал эсвэл цементийн материалын матриц байдалтай байдаг
ГЗ	Гүйцэтгэх захирал
Энгийн Хувьцаа	Компанийн гаргасан энгийн хувьцаа
Эрдэнэ Монгол Компани	Компанийн охин компани Эрдэнэ Монгол ХХК
баяжмал	Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн Хүдрээс ихэнх хаягдал материалыг нь салгаж авсан үнэт метал агуулсан бүтээгдэхүүн
DSU (Deferred Stock Units) эпитермал	Ирээдүйд эзэмшүүлэх нэгж хувьцаа Дэлхийн гадаргуунаас ойролцоогоор нэг км-т, 50-200C градусын температурт бий болж, ихэвчлэн судал байдлаар олддог гидротермал эрдсийн орд
EV/EBIT	Компанийн зах зээлийн үнэлгээг хүү ба татварын өмнөх ашигт харьцуулсан харьцаа
СЗХ	Монгол Улсын Санхүүгийн Зохицуулах Хороо
ДНБ	Дотоодын Нийт Бүтээгдэхүүн
ХАББООН	Хөдөлмөр, аюулгүй байдал, байгаль орчин, олон нийт
Лидер	Эрдэнэ Монгол ХХК-ийн 51%-ийг эзэмшдэг Лидер Эксплорэйшн ХХК
метаморф	Эрдэс болон чулуу нь анхны бүрдлээсээ хойш өөрчлөлтөд орсон, ялангуяа тунамал чулуулаг дулааны болон даралтын нөлөөнд орсны дараа дахин болоржсон чулуулаг
МХБ	Монголын Хөрөнгийн Бирж
NI 43-101	Канадын Үнэт цаасны Захиргааны Байгууллагын удирдлага дор Ашигт малтмалын төслүүдийн нийтэд мэдээллэх, танилцуулах дүрэм журмуудын стандарт
Үнэт цаасыг санал болгох	Энэхүү танилцуулгад тусгаснаар үнэт цаасыг олон нийтэд санал болгох
полиметалл	Хэд хэдэн үе давхарга бүхий метал эрдэсжилтийн байрлал; эдийн засгийн хувьд гурав ба түүнээс дээш чухал эрдэс агуулсан орд.
порфирит	Өөр өөр талстууд (хээрийн жоншны хувьд) харьцангуй нарийн ширхэгтэй суурьтай байна.

2018.03.12

Бариан





порфири (орд) Порфири гэдэг нь нүдэнд үзэгдэхүйц фенокристаллаг (болор) нарийн ширхэгтэй шороо агуулсан магмын чулуулаг. Порфирийн орд нь ихэнхдээ бага зэрэгтэй, нээлттэй уурхайд бөөгнөрсөн өндөр тонны ордууд байдаг

ROA	Нийт хөрөнгийн өгөөж
ROE	Эзэмшигчийн өмчийн өгөөж
SEDAR	Цахим Баримт Бичгийн Шинжилгээ, Хайлтын Систем ("System of Electronic Document Analysis and Retrieval") буюу www.sedar.com
чулуулгын хэмжилтийн чиглэл	Гадаргын түвшин дээр хэмжигдэж буй судал буюу чулууны чиглэл, урсгал
TSX	Торонтогийн Хөрөнгийн Бирж
судал	Ан цавын бөглөрөл эсвэл агуулагч чулууг сольсноор үүсэх үе давхраа, эрдсийн бие
судлын бөөгнөрөл	Илүү чухал гэж үзсэн бүтцийн хяналтыг тусгасан кварцын судлуудын цуврал эсвэл бөөгнөрөл.
As	Хүнцэл агуулсан
Cu	Зэс
Au	Алт
Pb	Хар тугалга
Mo	Молибден
Ag	Мөнгө
Zn	Цайр

Валют ба валютын ханшийн мэдээлэл

Хэрэв өөрөөр заагаагүй бол уг Танилцуулгад дурдсан валют нь Канад доллар байна. MNT, ₮ эсвэл MN₮ нь Монгол Улсын мөнгөн тэмдэгт төгрөгийг илэрхийлнэ.

2018 оны 03 сарын 09-ны өдрийн Монгол Улсын Төв банкны ("Монголбанк") Канад долларыг Монгол төгрөг рүү хөрвүүлсэн ханш нь 1,858.00 байв.

Хөрвүүлэх хүснэгт ба мэргэжлийн товчилсон үгс

Уг Танилцуулгад багтсан тоо хэмжээ нь ихэвчлэн метрийн нэгжээр илэрхийлэгдсэн. Метрийн бус хэмжээснээс метрийн хэмжээсний хөрвүүлэг ба метрийн хэмжээснээс метрийн бус хэмжээсийн хөрвүүлгийг дараах байдлаар үзүүлэв.

Метрийн хэмжээс	Метрийн бус хэмжээс	Метрийн бус хэмжээс	Метрийн хэмжээс
0.4047 гектар ("га")	1 акр	2.47 акр	1 гектар
0.3048 метр ("м")	1 фут	3.28 фут	1 метр
1.609 километр ("км")	1 бээр	0.62 бээр	1 километр
0.0283 куб метр	1 куб фут	35.315 куб фут	1 куб метр
31.103 грамм ("г")	1 унц (трой)	0.032 унц	1 грамм
0.907 тон ("т")	1 тон (шорт)	1.102 тон	1 тон
34.28 г/тон ("г/т")	1 унц (трой/тон)	0.029 унц	1 грамм/тон
0.454 килограмм ("кг")	1 фунт	2.2 фунт	1 килограмм

2018 03 12 J

Баурмаа





Баримт бичгүүдийн эх сурвалж ба линкүүд

Танилцуулгад тусгасан баримт бичгүүдийг доорх эх сурвалж болон линкээс үзэж болно. Компанийн вэбсайт www.erdene.com болон SEDAR (System for Electronic Document Analysis and Retrieval) www.sedar.com-оос танилцах боломжтой.

2018 03 12

Баармаа





НЭГ. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ

1.1. Үнэт цаас гаргагчийн хаяг

Байгууллагын нэр: Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн
("Erdene Resource Development Corp.")

Хаяг: Метрополитан Плейс, Канад улс, В3А А55, Нова Скошиа,
Вайс Роуд Халифакс 99, 1480 тоот
(Metropolitan Place, Suite 1480, 99 Wyse Halifax, Nova Scotia,
Canada, В3А А55)

Утас: 1-902-423-6419

Төлбөргүй утас: 1-800-261-1422

Факс: 1-902-423-6432

Вэбсайт: www.erdene.com

И-мэйл: info@erdene.com

Монгол Улс дахь хаяг: Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн
Эрдэнэ Монгол ХХК

Хаяг: Монруд ХХК-ийн байр, Монгол Улс, Чингэлтэй дүүрэг, Нэгдсэн
үндэстний гудамж 6/6

Утас: 976-11-319758

Факс: 976-11-315988

И-мэйл: info@erdene.com

1.2. Үнэт цаас гаргагчийн бүртгэлийн мэдээлэл

"Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн" ("Erdene Resource Development Corp.") нь 2000 оны 07 сарын 14-нд Канадын Бизнесийн Байгууллагын хуулийн дагуу "3779751 Canada Inc" нэрээр үүсгэн байгуулагдсан. 2003 оны 02 сарын 18-нд нэмэлт өөрчлөлтийг оруулан "Эрдэнэ Гоулд Инк" ("Erdene Gold Inc") болгож нэрээ өөрчлөн, 2008 оны 05 сарын 29-нд "Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн" болгон өөрчилсөн.

Компанийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, компанийн дүрмийг Хаасралт 1-ээс үзнэ үү.

Бүртгэл



2018 03 12 J



Компанийн бүрэн эзэмшдэг “Эрдэнэ Монгол” ХХК (“**Erdene Mongol LLC**”) хэмээх охин компани 2005 оны 12 сарын 08-нд Монгол Улсад холбогдох хууль тогтоомжийн дагуу бүртгэгдсэн. Охин компанийн бүртгэлтэй хаяг нь Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Нэгдсэн үндэстний гудамж 6/6, Монруд ХХК-ийн байранд байрладаг.

Компанийн бүрэн эзэмшдэг “Аниан Ресорсиз” ХХК (“**Anian Resources LLC**”) 2005 оны 12 сарын 07-нд Монгол Улсад холбогдох хууль тогтоомжийн дагуу бүртгэгдсэн. Охин компанийн бүртгэлтэй хаяг нь Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Нэгдсэн үндэстний гудамж 6/6, Монруд ХХК-ийн Байранд байрладаг.

Компани 2017 оны 05 сарын 08-нд Монгол Улсад хуулийн дагуу бүртгэгдсэн “Лидер Эксплорэйшн” ХХК-ийн (“**Leader Exploration LLC**”) 51%-ийг эзэмшдэг. Компанийн бүртгэлтэй хаяг нь Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, Махатма Гандигийн гудамж 28/2, Оргил Стадионд байрладаг.

Компанийн охин компаниудын улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, компанийн дүрмийг Хавсралт 2, 3, 4-өөс үзнэ үү.

1.3. Үнэт цаас гаргагчийн бүтэц

2018 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар Компанийн бүтэц болон охин компаниуд дахь Компанийн хувь эзэмшлийн мэдээллийг харуулбал:

График 1-1 Компани ба охин компаниудын бүтэц




Баеринсе



2018-03-12



График 1-2 Компанийн зохион байгуулалтын бүтэц



1.3.1. Үнэт цаас гаргагчийн одоогийн хувьцаа эзэмшигчид

Компани хязгааргүй тооны энгийн хувьцаа гаргах эрхтэй ба уг Танилцуулгыг олон нийтэд танилцуулах үед **146,400,586** ширхэг энгийн хувьцааг гаргаад байна.

Бүх гаргасан болон зах зээлд арилжаалагдаж буй энгийн хувьцааны төлбөрүүд бүрэн төлөгдсөн ба ирээдүйд эргэн дуудагдах эсвэл дахин үнэлгээнд орохгүй болно. Энгийн хувьцаа эзэмшигчид нь Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын талаар мэдээлэл авах, түүнд оролцох, санал өгөх эрхтэй. Энгийн хувьцаа гар өргөн санал тоолохоос бусад үед нэг саналын эрхтэй. Компанийн ТУЗ нь ногдол ашиг тараах эсэхийг шийдвэрлэх бөгөөд компани дампуурах, татан буулгах буюу үйл ажиллагаагаа зогсоовол ТУЗ зарласны дагуу энгийн хувьцаа эзэмшигчид Компанийн үлдсэн бүх хөрөнгийг эзэмшиж буй хувьцааны тоотой хувь тэнцүүлэн хүлээн авах эрхтэй. Энгийн хувьцаа нь тэргүүн ээлжид хувьцаа худалдан авах эрх, аливаа үнэт цаасанд хөрвөх болон шаардах эрх олгодоггүйгээс гадна өр дарах эсвэл худалдан авах сангийн зориулалтыг агуулаагүй болно.

Хувьцаа эзэмшигчид нь “Бүртгэлтэй хувьцаа эзэмшигч” эсвэл “Бүртгэлгүй хувьцаа эзэмшигч” байж болно. Хэрэв Компанийн энгийн хувьцаа нь хувьцаа эзэмшигчийн нэр дээр бус, зуучлагчийн нэр дээр бүртгэгдсэн бол “Бүртгэлгүй хувьцаа эзэмшигч” гэнэ. Зуучлагч нь ихэвчлэн зуучлалын ажиллагааг явуулдаг банк, итгэмжит компани, үнэт цаасны дилер эсвэл брокер, төлбөр тооцооны байгууллага байна.

Бацмаа



2018 03 12



Саналыг хаалттай хураахаас бусад тохиолдолд хувьцаа эзэмшигч нь аль нэг иргэн эсвэл хуулийн этгээдийг (хувьцаа эзэмшигч байх албагүй) өөрийг нь төлөөлөн хуралд оролцох, санал өгөхөөр томилж болно.

Бүртгэлтэй хувьцаа эзэмшигчид нь хувьцаа эзэмшигчдийн хуралд хоёр хэлбэрээр оролцох ба үүнд биеэрээ эсвэл итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан хуралдаа оролцож саналаа өгч болно. Бүртгэлгүй хувьцаа эзэмшигчид нь өөрийн зуучлагчаар дамжуулан түүнд зааварчилгаа өгсний үндсэн дээр санал өгөх боломжтой. Зуучлагч нь бүртгэлгүй хувьцаа эзэмшигчийг төлөөлж санал өгөхийн тулд өргөдөлд зааснаар итгэмжлэлийг хавсарган хүргүүлэх шаардлагатай.

1.3.2. Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн Удирдах Зөвлөл

Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь найман гишүүнээс бүрдэх ба дийлэнх нь Канадын Үнэт Цаасны холбогдох хууль эрх зүйн шалгуурт нийцсэн “хараат бус” гишүүд байдаг.

Хараат бус гишүүд нь: Др Анна Г. Биолик (Dr. Anna G. Biolik), Виллиам Б. Бартон (William B. Burton), Жон П. Бюрн (John P. Byrne), Т.Лэйтон Крофт (Layton Croft), Дэвид В. Мошер (David V. Mosher) ба Филипп Л.Вэбстер (Philip L. Webster).

Компанийн Гүйцэтгэх захирал Петер С. Акерли (Peter C. Akerley) болон 2015 оны 07 сарын 01 хүртэл Ази тив хариуцсан Дэд захирал байсан Ж.К. Кован (J.C. Cowan) нарыг хараат бус гишүүд хэмээн үзэхгүй.

Хүснэгт 1-1 Төлөөлөн удирдах зөвлөл

Гишүүдийн нэрс	Энгийн хувьцаа (эзэмшдэг, хяналттай)	Бусад тайлагнагч компаниуд буюу бусад компанийн ТУЗ-д байдаг эсэх	ТУЗ-ийн гишүүнд томилогдсон	Компани дахь албан тушаал
1 Петер С.Акерли	1,117,849	Мориен Ресурс Корп (TSX-V)	2003.2	Ерөнхийлөгч, ГЗ, ТУЗ-ийн гишүүн
2 Др. Анна Г.Биолик	10,000	-	2016.6	ТУЗ-ийн гишүүн
3 Виллиам Б.Бартон	833,800	Адекс майнинг Инк (TSX-V)	2003.2	ТУЗ-ийн гишүүн
4 Ж. К (Крис) Кован	1,225,375	-	2003.2	ТУЗ-ийн Дарга
5 Жон П. Бюрн	5,363,429	Мориен Ресурс Корп (TSX-V)	2004.8	ТУЗ-ийн гишүүн
6 Т.Лэйтон Крофт	975,000	Панконтинентал Гоул Корп (TSX-V) Харвест Гоулд Корп (TSX-V)	2015.7	ТУЗ-ийн гишүүн
7 Дэвид В.Мошер	359,000	Панконтинентал Гоул Корп (TSX-V) Пеланжио Эксплорейшн Инк (TSX-V)	2016.6	ТУЗ-ийн гишүүн

Б. Акерли



2018-03-12



Роскан Минералс Корп(NEX)

8	Филипп Л.Вэбстер	2,825,000	-	2006.6	ТУЗ-ийн гишүүн
---	------------------	-----------	---	--------	----------------

1.3.3. Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн дэргэдэх хороод, дотоод хяналт

ТУЗ нь Компанийн бизнесийн үйл ажиллагаа болон удирдлагын гүйцэтгэлд хяналт тавих үүрэгтэй. Канадын Үнэт Цаасны Тухай Хуулийн дагуу Компани нь засаглалын тухай мэдээллийг жил бүр тайлагнах үүрэгтэй. Компани нь өөрчлөгдөн хөгжихийн хэрээр сайн засаглал болон үндсэн үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах, засаглалтай холбоотой бүтэц, шаардлагатай үйл ажиллагаа, арга хэмжээг тухай бүрд нь хэрэгжүүлэн ажилладаг. Энэхүү үүргийг ТУЗ нь шууд болон дараах таван хороогоор дамжуулан гүйцэтгэдэг:

- **Аудитын хороо**

Аудитын хороо нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явц болон дотоод хяналтын системийг бие даасан, бодит байр сууринаас хянаж, хувьцаа эзэмшигчид болон хөрөнгө оруулагчдын өмнө хүлээсэн үүрэг хариуцлагаа биелүүлэхэд нь ТУЗ-д дэмжлэг үзүүлэн ажилладаг. Мөн Компанийн санхүүгийн хэлтэс, удирдлага болон хөндлөнгийн аудиторуудыг холбох, ил тод байдлыг хангах болон хөндлөнгийн аудиторын ажил үүрэгт дотоод хяналт тавих үүрэгтэй.

Аудитын хороо нь жилдээ багадаа дөрвөн удаа хуралддаг ба хараат бус гурван гишүүнээс бүрддэг. Үүнд:

- Виллиам Б. Бартон (William B. Burton)
- Жон П. Бюрн (Дарга) (John P. Byrne (Chair))
- Филипп Л. Вэбстер (Phillip L. Webster)

- **Цалин урамшууллын хороо**

Цалин урамшууллын хорооны эрх, үүрэг нь Компанийн гүйцэтгэх албан тушаалтнууд, мэргэжилтнүүдийн ажлын гүйцэтгэл, цалин урамшууллыг хянан шалгах, төлөвлөгөөний дагуу зохистой удирдлагыг хэрэгжүүлэхэд чиглэдэг. Цалин урамшууллын хороо нь Гүйцэтгэх захиралтай хамтран харьцуулсан судалгаа, шинжилгээ хийсний үндсэн дээр ТУЗ-ийн гишүүдэд өгөх цалин урамшууллын түвшинг ТУЗ-д санал болгодог. Мөн Гүйцэтгэх удирдлагын урамшууллыг хянаж, ТУЗ-д санал болгодог.

Вэбстер



2018-03-12



1.3.4. Үнэт цаас гаргагчийн гүйцэтгэх удирдлагын тухай мэдээлэл

Компанийн гүйцэтгэх удирдлага нь 2 захирал болон 8 удирдах албан тушаалтнаас бүрддэг.

Хүснэгт 1-2 Компанийн удирдлагын тухай мэдээлэл

Нэр	Албан тушаал	Ажлын туршлага
1 Петер С. Акерли* (Peter C. Akerley)	Ерөнхийлөгч, Гүйцэтгэх захирал, Захирал	Ашигт малтмалын хайгуул, компанийн санхүүжилт, төслийн хөгжил ба удирдлагын чиглэлээр 25 жил ажиллаж байгаа туршлагатай
2 Кеннет В. МакДоналд* (Kenneth W. MacDonald)	Дэд ерөнхийлөгч ба Санхүү эрхэлсэн захирал	Ашигт малтмалын хайгуул, нягтлан бодох бүртгэл болон санхүүгийн салбарт 40 гаруй жил ажилласан туршлагатай
3 Майкл МакДоналд (Michael MacDonald)	Хайгуул хариуцсан дэд ерөнхийлөгч	Ашигт малтмалын хайгуул, ашигт малтмалын нөөцийн бодлого зохицуулалт, хөгжлийн талаар 40 гаруй жилийн туршлагатай, Монгол Улсад 25 жил ажиллаж байгаа туршлагатай
4 Майкл Гиллис (Michael X. Gillis)	Үйл ажиллагаа хариуцсан дэд ерөнхийлөгч	Ашигт малтмалын хайгуулын салбарт 30 жил ажиллаж байгаа туршлагатай
5 Гэндэнжамцийн Бат-Эрдэнэ**	Ахлах Геологич	Монгол Улсын хайгуулын салбарт 25 жил ажиллаж байгаа туршлагатай
6 Багабандийн Баярмаа**	Захиргаа хариуцсан ерөнхий захирал	Монгол Улсын хайгуулын салбарт захиргааны чиглэлээр 15 жил ажилласан туршлагатай
7 Анхбаярын Билгүүн	Бизнес хөгжил хариуцсан дэд ерөнхийлөгч	Уул уурхайн санхүүжилт ба хөрөнгийн зах зээлийн чиглэлээр 15 жилийн туршлагатай
8 Жон М.Л. Лионс (Jon M.L. Lyons)	Стратеги, захиргаа хариуцсан дэд ерөнхийлөгч	Засгийн газраас зөвшөөрөл авах, түүнтэй холбоотой үйл ажиллагааг хариуцан ажилладаг. Мөн эрүүл мэнд, аюулгүй байдал, хүрээлэн буй орчин болон олон нийтийн асуудлыг хариуцдаг
9 Даррин Бродерик (Darryn Broderick)	Санхүүгийн газрын дарга	Төрийн болон хувийн хэвшлийн компаниудад санхүүгийн ахлах албан тушаалд ажиллаж байсан туршлагатай
10 Даусон Бриско (Dawson Brisco)	Компанийн хөгжил хариуцсан дэд ерөнхийлөгч	Ашигт малтмалын хайгуулын чиглэлээр 10 жилийн турш ажиллаж буй туршлагатай

*Захиралууд

** Компанийн охин компани Эрдэнэ Монгол ХХК-д ажилладаг.

Компанийн удирдлага ба техникийн баг нь Компанийн үйл ажиллагаа эрхэлж буй бүс нутгийн ашигт малтмалын хайгуул болон хөгжүүлэлтийн асуудлаар олон жил ажиллаж байгаа туршлагатай хамт олон. Одоогийн байдлаар Компанийн Канад дахь албан байранд

Баермис



2018-03-12



7 үндсэн ажилтан, Улаанбаатар хот дахь албан байранд (Компанийн охин компаниуд багтсан) 19 ажилтантай. Улаанбаатар хотод байрлах 19 ажилтнаас геологи хайгуулын мэргэжилтнүүд нь 4-12 сар хооронд Компанийн Баян Хөндийн хээрийн ангид байрлаж ажилладаг.

Түүнчлэн орон нутгийн хамтын ажиллагаа, үр өгөөжтэй харилцааг бий болгох зорилгоор орон нутгаас туслах ажилтнууд болон хангамжийн компаниудын үйлчилгээ авч ажилладаг. Үйлчилгээний компаниудад:

- Өрөмдлөгийн үйлчилгээ,
- Судалгаа ба дээжийн шинжилгээ,
- Хоол хүнсний үйлчилгээ ба хээрийн ангийн удирдлага,
- Геофизикийн үйлчилгээ,
- Харуул, хамгаалалтын үйлчилгээ багтана.

1.3.5. Бизнесийн ёс зүйн дүрэм

2006 оны 3 сард компанийн ТУЗ нь Бизнесийн болон ёс зүйн дүрмийг баталж захирал, албан тушаалтан, ажилтан тус бүрт уг дүрэмд тусгасан стандартуудыг дагаж мөрдөх шаардлага тавьж эхэлсэн. Уг дүрмээр доорх агуулга, үзэл санааг баримтлахыг чухалчилдаг. Үүнд:

- Шударга, ёс зүйт арга барилаар ажиллах,
- Компанийн нууцыг хадгалах,
- Ашиг сонирхлын зөрчлөөс зайлсхийх,
- Компанийн хөрөнгийг зөв зохистой хэрэглэх, хамгаалах,
- Холбогдох хууль, журам, дүрэм болон зохицуулалтыг дагаж мөрдөх,
- Дүрэм зөрчсөн талаар зохих ажилтан, мэргэжилтэнд нэн даруй мэдэгдэх,
- Дүрмийг дагаж мөрдөх тухай хариуцлага хүлээх,
- Үнэнч шударга байдал ба хариуцлагын соёл багтана.

Энэхүү дүрэмд ашиг сонирхлын зөрчил, мэдээллийн нууцлал, хууль тогтоомж дагаж мөрдөж буй байдал, ёс бус зан авир, доголдлын талаар мэдэгдэх асуудлыг тусгайлан хөндсөн.

1.3.6. Ашиг сонирхлын зөрчил

Канад улсын хуулийн хэм хэмжээний хүрээнд Компанийн захирлууд нь Компанийн эрх ашгийн төлөө үнэнч шударгаар ажиллахыг шаарддаг бөгөөд Компанийн аливаа төсөл

Бүрэн



2018-03-12



эсвэл хамтын ажиллагаа нь ашиг сонирхлын зөрчилтэй байвал нээлттэй мэдэгдэхийг шаарддаг. Хэрэв ашиг сонирхлын зөрчил ТУЗ-ийн хүрээнд үүссэн тохиолдолд уг гишүүн нь өөрийн ашиг сонирхлоо нээлттэй мэдэгдэж, тухайн асуудалд санал өгөхөөс татгалзах үүрэгтэй.

Компанийн захирлууд болон ажилтнууд Компанийн эрх ашгийн төлөө үнэнч шударга ажиллах ба хэрэв ашиг сонирхлын зөрчил үүсвэл энэ талаар Компанид мэдэгдэх ёстой. Уг Танилцуулгын хүрээнд энгийн хувьцааг худалдан авах талаар төлөвлөж буй хөрөнгө оруулагч нь үүсч болзошгүй ямар нэгэн ашиг сонирхлын зөрчлийг шийдвэрлэхэд оролцож буй хүмүүсийн үнэнч шударга байдал, шийдвэрт итгэлтэй байх нөхцөлийг компани бүрдүүлэх үүрэгтэй.

1.3.7. Гэрээ болон хамтын ажиллагаа

- *Сандсторм Гоулд Лтд (Sandstorm Gold Ltd), Хувьцаа захиалгын гэрээ*
2016 оны 04 сарын 21-нд Компани нь Сандсторм Гоулд Лтд. ("**Sandstorm Gold Ltd**") (цаашид "Сандсторм" гэх) компанитай нийт 2,500,000 долларын хоёр үргэлжилсэн хэлцлийг хийсэн.

1. Эхний хэлцлээр, Сандстормын нэгж хувьцаа нь \$4.66 бүхий нийт \$1,500,000-ын үнэлгээтэй 321,888 ширхэг хувьцааны хариуд Компанийн Цэнхэр Номин болон Хөндийн тусгай зөвшөөрлүүдэд 2%-ийн борлуулалтын цэвэр ашгийн төлбөрийг ("**NSR**" эсвэл "Net Smelter Royalty") ("БЦА-ийн Төлбөр") Сандстормд ирээдүйн олборлох үйл ажиллагаанаас хуваарилахаар тохирсон ба хувьцааны үнийг тогтоохдоо 2016 оны 04 сарын 14-ний ТХБ дэх Сандстормын 10 өдрийн жигнэсэн дундаж ханш дээр үндэслэсэн.

2. Хоёр дах хэлцлээр, Сэндстормын бэлнээр төлсөн \$1,000,000-ын хариуд нэгж хувьцааг \$0.20-аар үнэлэн, Компанийн 5 сая ширхэг хувьцааг нэмж гарган Сандстормд олгосон. Сандсторм нь хэлцлийн дагуу нэмж гаргасан хувьцааг царцаах үүрэг хүлээсэн бөгөөд энэ нь 2017 оны 10 сарын 14-ний өдөр дуусгавар болсон.

Компани нь БЦА-ийн Төлбөрийг 1.0% хүртэл бууруулах опцион эрхтэй, ингэхийн тулд хэлцэл хийгдсэнээс хойш 3 жилийн хугацаанд буюу 2019 оны 04 сарын 15-аас өмнө 1.2 сая долларыг Сэндстормд төлсөнөөр БЦА-ийн төлбөрийг 50% бууруулах боломжтой. Сандсторм нь Хөндий болон Цэнхэр Номингийн тусгай зөвшөөрлүүдтэй холбоотой ирээдүйн төлбөрийн санхүүжилтанд хориг тавих эрхтэй.

Компани 2016 онд Сандстормд эзэмшиж байсан бүх хувьцаагаа худалдсанаар \$1.98 саяыг олсон бөгөөд үүнээс \$481,064-ын ашигтай ажилласан.

Баерине



2018.03.12

0000 25 ТГЭВ 01



- *Тек Ресорсиз Лимитэд (Teck Resources Limited) компанитай байгуулсан түншлэл*

Түншлэлийг 2013 оны 04 сард Монгол Улсын баруун өмнөд зүгт Транс Алтай бүсэд байрладаг Компанийн ашигт малтмалын тусгай зөвшөөрлүүдийн геологи хайгуулын ажлыг санхүүжүүлэх, хайгуулын ажил хийх хүрээнд Тек Ресорсиз Лимитэд компанитай ("Teck Resources Limited") ("Тек") опцион болон хаалттай хүрээнд хөрөнгө татан төвлөрүүлэх гэрээний (хамтад нь "Тек гэрээ") дагуу байгуулсан. Энэхүү түншлэлд Компанийн Алтан Нар, Баян Хөндий алтны төслүүд болон Зуун Мод молибдени-зэсийн төсөл багтаагүй. Гэрээний нөхцөлд заасны дагуу Тек нь Компанид 3 сая долларын хөрөнгө оруулах хүртлээ эсвэл Компанийн зарласан хувьцааны 19.9%-ийг эзэмших (аль нэг нь түрүүлж хийгдэх хүртэл) хүртэл хаалттай хүрээнд Компанийн хувьцааг тухайн үеийн 10 өдрийн жигнэсэн дундаж ханш дээр 10%-ийг нэмж тооцсон үнээр худалдан авна. Хаалттай хүрээнд татан төвлөрүүлсэн хөрөнгө оруулалтын 85% нь Компанийн хайгуулын ажилд зарцуулагдахаар төлөвлөгдсөн бөгөөд Тек нь дахин санхүүжилтын аргаар шинэ төслүүдэд 75% хүртэл эзэмших боломжтой 2 үе шаттай опцион эрхтэй.

2013 оны 04 сараас 2017 оны 03 сарын хооронд гэрээний дагуу Тек нь Компанийн 14,647,904 Энгийн Хувьцааг авч, 3 сая долларын хөрөнгө оруулалт хийсэн. Эхний хөтөлбөр дуусахад Тек эзэмших төслийг нэрлээгүй ба Компанийн шинээр тогтоосон нээлтүүдэд түншлэлийн гэрээ хийх эрх нь 2020 оны 1 дүгээр улирлыг дуустал хүчинтэй.

- *Улаан төслийн Опционы гэрээ*

2017 оны 04 дүгээр сарын 30-нд Компани нь өөрийн 100% эзэмшлийн Баян Хөндий алтны төсөлтэй зэргэлдээ орших Улаан хайгуулын тусгай зөвшөөрлийн 51%-ийг эзэмших гэрээ хийсэн. Улаан хайгуулын тусгай зөвшөөрөл нь нийтдээ 1,780 га талбайг хамардаг.

Компани нь тусгай зөвшөөрлийг эзэмшгч Лидер Эксплорэйшн ХХК-ийн 51%-ийг \$750,000 ам.доллараар үнэлж худалдан авсан. Цаашид 3 жилийн турш \$600,000 ам.долларын хайгуулын ажлыг энэхүү талбайд хийснээр үлдсэн 49%-ийг тухайн үеийн үнэлгээгээр худалдан авах эрх үүснэ. Компани нь энэхүү 3 жилийн опционы хугацааг жилд \$100,000 ам.долларыг хайгуулын ажилд зарцуулснаар сунгах боломжтой.

- *Галлант Минералс Лимитэд (Gallant Minerals Limited), Роялти гэрээ*

Компани нь Монгол Улсын баруун урд зүгт орших Зуун Мод молибденийн төслийг 100% эзэмшдэг. Энэхүү төсөл нь 6041 га талбайг хамарсан ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй. Төслийг 2005 онд Галлант Минералс Лимитэд ("Gallant Minerals Limited")-ээс авсан

Баермисе



2018-03-12



бөгөөд Галлант нь Зуун Мод тусгай зөвшөөрлийн борлуулалтын цэвэр ашгаас 1.5%-ийн төлбөрийг (БЦА-ийн төлбөр) хүртэх эрхтэй. Зуун Мод хайгуулын тусгай зөвшөөрлийн хүрээнд хайгуулын ажлын төлөвлөгөө хийгдээгүй.

Компани нь Канадын үнэт цаасны зохицуулах байгууллага ("Canadian Securities Administrators") болон Канадын үнэт цаасны хадгаламжийн байгууллагын ("Canadian Depository for Securities") удирддаг Цахим Баримт Бичгийн Шинжилгээ, Хайлтын Систем ("System of Electronic Document Analysis and Retrieval") буюу www.sedar.com -д компанийн олон нийтэд мэдээлэх бүхий л мэдээллийг нийтэлдэг бөгөөд томоохон гэрээ, хэлэлцээрийн мэдээллүүдтэй www.sedar.com дээр Англи хэл дээр танилцах боломжтой.

1.4. Хөрөнгийн бүтэц

Компанийн хөрөнгө нь дараах бүтэцтэй байна.

Хүснэгт 1-3 Хөрөнгийн бүтэц


Хөрөнгийн Бүтэц	Энгийн хувьцаа 2018 оны 2 сарын 29-ны байдлаар Компани нь нийт 146,400,586 ширхэг энгийн хувьцаа гарган, олон нийтэд арилжаалж байна.
	Хувьцаа эзэмшигчийн эрх Компанийн ТУЗ нь 2008 оны 3 сарын 14-нд Хувьцаа эзэмшигчийн эрхийн бичиг баримтыг боловсруулж, Хувьцаа эзэмшигчдийн хурлаар 2017 оны 6 сарын 11, 2017 оны 6 сарын 14-нд тус тус нэмэлт өөрчлөлт сруулсан
	Опцион 2018 оны 2 сарын 28-ны өдрөөр Компани \$0.39 долларын жигнэсэн дундаж үнэ бүхий 9,316,250 опционтой
	DSU 2018 оны 2 сарын 29-ны байдлаар Компани нь \$0.86 долларын жигнэсэн дундаж үнэ бүхий 3,410,186 DSU-тэй байна.
	Нөхөн төлөх опцион 2018 оны 2 сарын 28-ны байдлаар 2019 оны 2 сарын 22 хүртэл хэрэгжүүлэх боломжтой, нэгж бүрийг \$1.20 доллараар үнэлсэн 1,075,324 нөхөн төлөх опцион гаргасан.

- Өнөөгийн томоохон хувьцаа эзэмшигчид

Хүснэгт 1-4 Одоогийн томоохон хувьцаа эзэмшигчид¹

Хувьцаа эзэмшигчид	Одоогийн байдлаар	
	Хувьцааны тоо хэмжээ	Хувь
Teck Resources Ltd	13,222,904	9.03%
ТУЗ-ийн гишүүд, захирлууд	13,644,752	9.32%
Нийтэд арилжаалагдаж буй	119,532,930	81.65%
Нийт	146,400,586	100%

График 1-3 Одоогийн хувьцаа эзэмшигчид



2018 03 12 1

¹ Эх сурвалж: Bloomberg Terminal: Erdene Resource Development Corp

Баарица





1.4.1. Компанийн нийтэд арилжаалагдаж буй хувьцааны мэдээлэл

Хаалтын ханш (2018.02.28-ны байдлаар Канад доллараар):	\$0.425
52 долоо хоногийн хэлбэлзэл:	\$0.424-1.40
Дундаж арилжааны хэмжээ:	341,244
Зах зээлийн үнэлгээ (2018.02.28-ны байдлаар):	\$62,220,249
Нийт арилжигдаж буй хувьцааны тоо ширхэг:	146,400,586
Бета:	2.136
P/B харьцаа	4.22
Ногдол ашиг:	-

Компани 2004 оны 03 сарын 16-аас эхлэн энгийн хувьцаагаа Торонтогийн Хөрөнгийн Биржийн Венчур (гарааны бизнесийн) самбар дээр ("TSX-V") "ERD" кодтойгоор арилжаалж эхэлсэн. 2005 оны 12 сарын 14-өөс эхлэн Компанийн хувьцаа Торонтогийн Хөрөнгийн Бирж рүү шилжин арилжаалагдаж эхэлсэн. Компанийн хувьцааны арилжааг Канадын Хөрөнгө Оруулалтын Салбарын Зохицуулах Байгууллага ("IIROC") ("KXOC3B") зохицуулдаг бөгөөд энэхүү байгууллага нь Канад улс дахь өр болон хувьцааны зах зээл дээрх хөрөнгө оруулалтын дилер, арилжааны үйл ажиллагааг хянадаг өөрийгөө зохицуулагч байгууллага бөгөөд Үнэт Цаасны Хороодын Олон Улсын Байгууллагын² ("International Organization of Securities Commission") гишүүн юм.

Компани нь хязгааргүй тооны энгийн хувьцаа гаргах эрхтэй бөгөөд хувьцааг олон нийтэд анх удаа санал болгох хүртэл 13,058,910 ширхэг энгийн хувьцааг гаргаж зарласан. 2004 оны 03 сарын 16-ны өдөр Компани нийт 12,500,000 ширхэг энгийн хувьцааг нэг бүр нь \$0.85-ын нэрлэсэн үнээр гаргасан. Үүний дараагаар доорх байдлаар нэмэлт хувьцааг гаргасан.

Хүснэгт 1-5 Компанийн энгийн хувьцааны мэдээлэл

Он, сар, өдөр	Энгийн хувьцааны тоо ширхэг
2004.3.16 хүртэл	13,058,910
2004.3.16 (IPO)	25,558,910
2004.12.31-ний байдлаар	25,798,910
2005.12.31-ний байдлаар	27,269,635
2006.12.31-ний байдлаар	53,051,127
2007.12.31-ний байдлаар	70,200,939
2008.12.31-ний байдлаар	89,230,877
2009.12.31-ний байдлаар	89,230,877
2010.12.31-ний байдлаар	89,688,377
2011.12.31-ний байдлаар	95,802,901

² <https://www.iosco.org/about/?subsection=membership&memid=3>

Баермисе



2018 03 12




2012.12.31 ³ -ний байдлаар	53,785,299
2013.12.31-ний байдлаар	68,641,503
2014.12.31-ний байдлаар	82,636,233
2015.12.31-ний байдлаар	109,876,030
2016.12.31-ний байдлаар	145,390,586
2017.12.31-ний байдлаар	145,963,086
2018.2.9-ний байдлаар	146,400,586
2018.2.9 байдлаар	146,400,586

TSX дээр арилжаалагдаж буй энгийн хувьцааны сүүлийн 5 жилийн үнийн хэлбэлзлийг доор харуулав.

Хүснэгт 1-6 Компанийн энгийн хувьцааны үнийн өөрчлөлт

	Дээд	Доод
2013	0.23	0.07
2014	0.205	0.085
2015	0.16	0.105
2016	0.59	0.14
2017	1.37	0.485

Зураг 1-1 Компанийн хувьцааны график (TSX:ERD)



1.4.2. Ногдол ашигийн бодлого

Компани өнөөг хүртэл энгийн хувьцаандаа ногдол ашиг хуваарилаагүй. Компанийн хөрөнгө нь үйл ажиллагааг дэмжих, ордын нөөцийг илрүүлж түүнийг өсгөн нэмэгдүүлэхэд зарцуулагдах төсөөлөлтэй байгаа тул ойрын ирээдүйд ногдол ашиг хуваарилах төлөвлөгөөгүй байна. Энгийн хувьцаанд ногдол ашиг хуваарилах тухай аливаа шийдвэрийг орлого, санхүүгийн тайлан болон тухайн цаг үеийн бусад нөхцөл байдалд тулгуурлан Компанийн ТУЗ гаргана.

1.5. Үнэт цаас гаргагчийн салбар ба зах зээлийн тухай мэдээлэл

1.5.1. Монгол Улсын макро эдийн засгийн орчин

Монгол Улс нь 1990 онд төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас чөлөөт зах зээлд тулгуурласан эдийн засагт шилжсэнээр огцом өсөлт бий болж, шинэчлэл хийгдэж эхэлсэн.

³2012 оны 11 сарын 9-нд "хоёрт нэг" зарчмаар шинэчилсэн

Басууца



2018 03 12 1



Өнгөрсөн 30 хүрэхгүй жилийн хугацаанд хувийн хэвшил нь ДНБ-ийн 80%-ийг, нийт хөдөлмөр эрхлэлтийн 70%-ийг бүрдүүлэх болов. Монгол Улсын эдийн засгийн өсөлт нь зэс, нүүрс, алт зэрэг томоохон ашигт малтмалын ордуудыг нээснээс үүдэн, голлон уул уурхайн салбарт тулгуурлаж байна.

1997-2010 оны хооронд Монгол Улсын уул уурхайн салбар дахь гадаадын хөрөнгө оруулалт жилдээ 112 сая ам.доллараас 819 сая ам.доллар хүртэл өссөн ба жилийн дундаж өсөлт 16.5% байв. Дэлхийн уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын орчин энэхүү хурдтай өсөлтөд нөлөөлж, 2010-2012 онд уул уурхайн салбарт оруулсан хөрөнгө оруулалт 4 тэрбум ам.доллар хүртэл өссөн тохиолдол бүртгэгдсэн нь Оюу Толгой төслийн бүтээн байгуулалтын үе шаттай давхцадаг.

2013-2014 онуудад дэлхийн зах зээл дээрх эрдэсийн түүхий эдийн үнэ огцом унаж, уул уурхайн салбарын хөрөнгө оруулалт олон улсын хэмжээнд буурсан нь Монгол Улсын эдийн засаг, уул уурхайн салбарт сөрөг нөлөө үзүүлж эхэлсэн. Монгол Улсын эдийн засгийн өсөлт уул уурхайгаас шууд хамааралтай байгаа нь эдийн засгийг түүхий эдийн үнийн өөрчлөлт, уул уурхайн мөчлөг болон импортлогч орнуудын эрэлт, нийлүүлэлтийн бууралтад мэдрэмтгий болгох эрсдэлтэй. Дээрх үйл явдлаас үүдэн Монгол Улсын Засгийн газар гадаадын шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхийн тулд төсвийн тэлэх бодлого хэрэгжүүлсэн. Мөн дотоодын хөрөнгө оруулалтыг өсгөхийн тулд төсвийн зарцуулалтыг нэмэгдүүлсэн нь улсын гадаад өрийг нэмэгдүүлэхэд хүргэв. Төсвийн зарцуулалтыг санхүүжүүлэх зорилгоор Засгийн газар олон улсын зах дээр бонд гаргасан нь барилгын салбарт болон бэлэн мөнгөний тэтгэмж хэлбэрээр зарцуулагдсан.

Түүнчлэн, хууль тогтоомж, бодлого зохицуулалтын тогтворгүй орчин нь улс төрийн томоохон эрсдэл болоод байна. Хууль эрх зүйн орчны зөрчилдөөнтэй байдал, төрийн худалдан авах ажиллагаа болон тусгай зөвшөөрлийн салбар дахь авлигын асуудал нь хувийн хэвшлийн хөгжилд сөргөөр нөлөөлж буйг Frazer Institute болон Нээлттэй Нийгэмлэгийн холбогдох судалгаануудад дурдажээ.

2018 03 12 J


Багшир



Б. Д. А.

МОНГОЛ УЛСЫН ӨРГӨТГӨСӨН
САНХҮҮЖИЛТИЙН ХӨТӨЛБӨРИЙГ
БҮРТГЭЭЖ
№ 01

График 1-4 Улсын төсөв ба ДНБ-нд эзлэх хувь



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

2018 онд олон улс дахь нүүрсний үнэ өсч, экспорт нэмэгдсэн нь Монгол Улсын эдийн засаг сэргэх гол хүчин зүйл болсон. Түүнчлэн Олон Улсын Валютын Сан ("ОУВС") нийт 3 тэрбум ам.долларын Өргөтгөсөн Санхүүжилтийн Хөтөлбөрийг ("ӨСХ") Монгол Улсад гурван жилийн хугацаатай хэрэгжүүлэхээр баталсан нь богино болон дунд хугацаанд эдийн засгийг тогтворжуулж, хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээх, дотоодын санхүүгийн зах зээлийн дарамтыг бууруулж, өрийн тогтвортой байдлыг сэргээх ач холбогдолтой.

Хүснэгт 1-7 Монгол Улсын эдийн засгийн үзүүлэлтүүд

		2014	2015	2016	2017	2018Т
ДНБ өсөлтийн хэмжээ	%	7.9	2.4	1.2	5.1	3
Ажилгүйдлийн түвшин	%	7.9	7.5	10	9.1	9.4
Инфляцийн түвшин	%	10.4	1.9	1.1	6.4	4.0
Урсгал тэнцэл	ДНБ-ий %	-3.9	-5.0	-15.3	-6.4	-8.5
Экспорт	Тэрбум ам.доллар	5.8	4.7	4.9	6.2	-
Импорт	Тэрбум ам.доллар	5.2	3.8	3.3	4.3	-

Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо, Азийн Хөгжлийн Банкны тайлан, 2017

Өнгөрсөн 15 жилийн хугацаанд уул уурхайн салбар нь ДНБ-д эзлэх хэмжээ, хөдөлмөр эрхлэлтэд оруулж буй хувь нэмэр, экспортын түвшинд эзлэх хэмжээгээр Монгол улсын тэргүүлэгч салбар болов. Эрдэс баялаг, уул уурхайн томоохон зах зээлтэй БНХАУ-тай шууд хиллэн оршдогийн хувьд Монгол Улсын уул уурхай нь бусад салбартай

Баармаа


МОНГОЛ УЛСЫН ӨРГӨТГӨСӨН
САНХҮҮЖИЛТИЙН ХӨТӨЛБӨРИЙГ
БҮРТГЭЭЖ
№ 01
30
1115205447

2018.03.12.1



харьцуулахад өсөх боломж харьцангуй өндөр. Энэхүү өндөр өсөлтийг бий болгоход хууль эрх зүй, дэд бүтцийн тогтвортой хөгжил, бизнесийн орчин болон хөрөнгө оруулалтын дэмжих шаардлагатай.

График 1-5 Монгол Улсын тэргүүлэх салбарууд



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

1.5.2. Үнэт цаас гаргагчийн салбарын орчин, зах зээлийн тухай

Монгол Улсын орчин цагийн ашигт малтмалын хайгуулын үйл ажиллагааг 1996-1998 хооронд БиЭйчПи Минералс Интернейшнл Эксплорейшн ("BHP Minerals International Exploration"), РТЗ Майнинг энд Эксплорейшн Лтд ("RTZ Mining and Exploration Ltd"), АйПиСи ("IPC"), Каскадиа Майнинг Корпораци ("Cascadia Mining Corporation"), КьюЖиИкс Лтд ("QGX Ltd") болон Галлант Минералс Лтд ("Gallant Minerals Ltd.") зэрэг компаниуд эхлүүлсэн байдаг.

Зарим хайгуулын үр дүн амжилттай байсан хэдий ч 1998 онд салбарын үйл ажиллагаа зогсонги байдалд орсноор компаниудын дийлэнх нь өөрсдийн үйл ажиллагааны цар хүрээгээ багасгаж, Монгол Улс дахь геологи хайгуулын үйл ажиллагааг зогсоосон.


2001-2003 оны хооронд Монгол Улсын хайгуулын салбарт хөрөнгө оруулалтын шинэ үе эхэлсэн нь Айвенхоу Майнз Лтд. ("Ivanhoe Mines Ltd") 2001 онд Оюу Толгойн зэс/алтны ордыг илрүүлсэн, Камеко Корпорацийн ("Cameco Corporation") алтны олборлолтын эхлэл зэрэг мэдээлэл нь хайгуулын салбар дахин сэргэх гол хүчин зүйлс болж байв.

Одоогийн байдлаар Монгол улсын нийт газар нутгийн хэмжээнд 3,000 гаруй орд болон 50 эрдэсжилтийн бүсүүдийг нээн илрүүлж, судлаад байна. Хэнтий, Хангайн уулсын өмнөд

Баармее




2018-03-12



болон хойд хэсгээр алтны ордуудыг нээн илрүүлсэн бол зэс, молибдений ордыг Орхон болон Сэлэнгийн сав газраар нээсэн. Томоохон хэмжээний нүүрсний нөөцийг Таван Толгой, Хар Тарвагатай, Бага Нуур зэрэг бүсүүдэд тогтоосон.

Хайгуулын тусгай зөвшөөрөл олгосон байдал (2017.12 сарын байдлаар) **3379**
 Ашиглалтын тусгай зөвшөөрөл **1620**
 Хайгуулын тусгай зөвшөөрөл **1759**

График 1-6 Монгол Улсын геологийн судалгааны түвшин



Эх сурвалж: АМГТГ

Геологийн мэдээллийн нэгдсэн санг баяжуулах, нийтэд түгээн ашиглах болон ашигт малтмалын нөөцийг үнэлэх, байгаль орчны болон хүрээлэн буй орчны хамгаалал, гүний баялгийг ашиглах зэрэг үйл ажиллагаанд зориулан зарим геологийн судалгааг төсвийн хөрөнгөөр эрхэлдэг.

Хүснэгт 1-8 Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй геологийн судалгаа

	2013		2014		2015		2016		2017.11	
	Сая ₮	Гүйцэтгэл	Сая ₮	Гүйцэтгэл	Сая ₮	Гүйцэтгэл	Сая ₮	Гүйцэтгэл	Сая ₮	Гүйцэтгэл
Нийт	6809.9	93.0%	9209.2	92.0%	9280.6	82.0%	9341.1	100.0%	11375.0	94.5%
NGM 1:200000	763.8	5.6%	7314.8	89.0%	330.5	63.0%	642.7	100.0%	459.2	90.1%
1:50000 GMGEWP	5809.4	96.5%	7314.8	93.0%	5556.7	78.0%	4975.8	100.0%	5243.5	98.2%
Гидрогеологийн судалгаа	155.8	34.3%	1003.5	88.0%	3167.7	92.0%	3476.1	100.0%	5549.2	80.2%
Геофизикийн цогцолбор судалгаа	80.9	168.9%	83.6	70.0%	225.6	79.0%	246.6	100.0%	123.1	100.0%

Эх сурвалж: АМГТГ, 2017

Баерине






Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэгт зааснаар тусгай зөвшөөрөл эзэмшигч жилийн тайлан, хайгуулын ажлын төлөвлөгөөг Монгол Улсын Ашигт Малтмал, Газрын Тосны Газрын Геологи, Судалгааны Албанд хүргүүлэх ёстой. 2012 оноос хойш жил бүр геологи хайгуулын ажилд зарцуулагдаж буй хөрөнгийн хэмжээ буурсаар байгааг доорх графикт үзүүлсэн. Энэ нь дэлхийн зах зээл дэх уул уурхайн бүтээгдэхүүнийн түүхий эдийн үнэ болон холбогдох хөрөнгө оруулалт буурсантай холбоотой.

График 1-7 Хувийн хөрөнгө оруулалтаар хийсэн хайгуулын ажил (тэрбум ₮)



Эх сурвалж: АМГТГ

График 1-8 2017 онд шинээр бүртгэгдсэн нөөцийн ордууд (ашигт малтмалаар)



Эх сурвалж: АМГТГ



Бүсрүүл


2018-03-12



- Алтны салбарын онцлогууд

Алтны эрэлт нь 4 гол хүчин зүйлээс хамааралтай. Үүнд: Төв банкуудын алтны нөөцийг нэмэгдүүлэх худалдан авалт, эрсдлийн удирдлагад зориулсан хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн, үнэт эдлэл, үйлдвэрлэлийн хэрэглээ багтана. Дэлхийн алтны олборлолт 2016 онд өнгөрсөн оны мөн үеэс 0.4%-ийн өссөн боловч шинэ уурхайн олборлолт харьцангуй бага байна. Биржийн арилжааны сан (Exchange Tranded Fund буюу “ETF”)-ийн худалдан авалтаас үүдэн алтан гулдмай, зоосны хөрөнгө оруулалт 52% хүртэл өссөн.

График 1-9 Дэлхийн алтны эрэлт, нийлүүлэлт



Эх сурвалж: GFMS

Сүүлийн жилүүдэд дэлхийн алтны олборлолтын 25-28%-ийг дангаар Ази тив эзэлж байна. Гэвч сүүлийн жилүүдэд дэлхий дахинд ордуудын хүдрийн олборлолтын хэмжээ, агууламж буурч, нэгжийн өртөг нэмэгдсэнээс үүдэлтэйгээр алт олборлолтын хэмжээ буурах магадлалтай байна.

График 1-10 Алтны агуулга болон олборлолтын өртөг





График 1-11 Дэлхийн алтны нээлтүүд



Багша



2018-03-12



Агууламж болон алтны хайгуул буурснаар урт хугацаанд алт олборлолтын хэмжээ буурах магадлалтай тул цаашид алтны үнэ нэмэгдэх эсвэл илүү өндөр агууламжтай хайж илрүүлэх шаардлага гарч ирж байна.

Дээр өгүүлснээр, нийт металлийн нөөц болон өндөр агууламж нь алтны ордын эдийн засгийн үнэлэмжийг тодорхойлох томоохон хүчин зүйл болдог. Томоохон хэмжээний металлын нөөц байхгүй бол уурхайн үйл ажиллагаа нь хөрөнгө оруулалтын зардлаа нөхөж чадахгүй байх эрсдэлтэй. Үүний нэгэн адилаар агууламж бага байх нь хүдрийн баяжуулалт, олборлолтын зардал өсөх, ашиг буух эрсдэлтэй.


Дэлхийн хэмжээнд буй 580 ордын дундаж агууламж⁴:

- Олборлогчид: 1.18 г/т
- Хөгжүүлэлтийн шатанд: 0.89 г/т

График 1-12 Монгол улсын алтны үйлдвэрлэл



График 1-13 Дэлхийн алтны үнэ



Эх сурвалж: goldprice.org

1.5.3. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны түүх

“Эрдэнэ Ресорс Девелопмент Корп” нь Торонтогийн Хөрөнгийн Бирж дээр бүртгэлтэй (TSX: ERD) Монгол Улсад өндөр агуулга бүхий, гадаргад ойр алт, зэсийн ашигт малтмалын хайгуул, олборлолт, худалдан авалт болон төсөл хөгжүүлэлтэд тулгуурлан үйл ажиллагаагаа эрхэлдэг.

2003 оноос эхлэн Компани нь тусгай зөвшөөрөл бүхий шинэ болон өмнө нь хайгуулын ажил хийгдэж байсан талбайнуудад геологи хайгуулын судалгаа, өрөмдлөгийн ажлуудыг хийж эхэлсэн. 2004 онд үнэт цаасаа анх удаа нийтэд санал болгох үедээ худалдан авалтын гэрээний дагуу болон хувь эзэмших эрхтэйгээр Монгол Улсад ашигт малтмалын

⁴ Эх сурвалж: NRH Судалгаа, 2013

Баермаа




2018-03-12



хайгуулын 19 тусгай зөвшөөрөл эзэмшиж байсан. Тусгай зөвшөөрөлтэй талбайнуудад хайгуулын хэтийн төлөвтэй гэж үзсэн найман талбай байсан бөгөөд эдгээр нь Монгол Улсын өмнөд-төв болон зүүн-өмнөд бүсийн нутгуудад төвлөрч байв. Эдгээр тусгай зөвшөөрөл бүхий бүх талбайг порфирын төрлийн алт болон зэсийн орд агуулах боломжтой гэж таамаглан анх сонгож авсан байдаг. Хайгуулын ажлуудын тайланг Монгол Улсын Ашигт Малтмал, Газрын Тосны Газарт жил бүр тайлагнадаг ба материаллаг өөрчлөлтийн тухайд SEDAR буюу www.sedar.com веб хуудсанд бүртгүүлж, олон нийтэд тайлагнасаар ирсэн. Одоогийн тусгай зөвшөөрлөөс бусад Компанийн анхны тусгай зөвшөөрөл бүхий талбайнуудад хийсэн геологи хайгуулын ажлаар эдгээр талбайнуудад дэлхийн хэмжээний нөөцтэй томоохон ордыг нээн илрүүлэх боломжгүй гэж үзсэн тул дийлэнх хайгуулын тусгай зөвшөөрлийг холбогдох байгууллагад буцаан өгсөн.

2009 оны хайгуулын хөтөлбөрөөр Цэнхэр Номин хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд Алтан Нар төслийг нээн илрүүлсэн ба 2015 онд Хөндий тусгай зөвшөөрөлийн талбайд Баян Хөндийн төслийг нээн илрүүлсэн. Эдгээр төслүүд дээр Компани голлон төвлөрч хайгуул, өрөмдлөгийн ажлуудыг хийж гүйцэтгэж байна. Энэхүү бүстэй холбоотой онцлох мэдээллүүд:

График 1-10 Монгол Улсын баруун урд зүгт байрлах Компанийн нээлтийн бүсүүдийн онцлох мэдээллүүд



1.5.4. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны өнөөгийн байдал

Компанийн өнөөгийн үндсэн үйл ажиллагаа нь их хэмжээний нөөцтэй, бага зардал бүхий үнэт болон суурь металын ордуудыг нээх, худалдан авах болон эзэмшихэд оршино.

Бадмаа



2018-03-12



Компани одоогийн байдлаар 17,861.20 га хайгуулын 4, ашиглалтын 1 тусгай зөвшөөрөл бүхий талбайд 7 төслийг ашигт малтмалын охин компаниудийн (Эрдэнэ Монгол ХХК, Аниан Ресорсиз ХХК болон Лидер Эксплорейшн ХХК) нэр дээр эзэмшдэг. Компанийн хуулийн зөвлөх болох Өмгөөллийн ИЭлСи ХХН нь тусгай зөвшөөрөлтэй холбоотой бүхий л хууль зүйн болон зохицуулалтын баримт бичгийг хянуулж дүгнэлт гаргуулсан бөгөөд Компанийн бүх хайгуулын тусгай зөвшөөрөл нь хүчин төгөлдөр ба Монгол Улсын Ашигт малтмалын тухай хуулийн хүрээнд тусгасан хууль ёсны шаардлагаас бусдаар ямарваа үүрэг, хариуцлага хүлээгээгүй болно.

Компани нь ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн хүрээнд доорх төслүүдийг хэрэгжүүлж байгаа ба үүнд:

- Баян Хөндийн алтны төсөл,
- Алтан Нар алт-полиметалын төсөл,
- Алтан Сум алт-мөнгөний төсөл,
- Зуун Мод молибден-зэсийн төсөл,
- Хөвийн Хар зэс-мөнгөний төсөл,
- Улаан зэс-порфирын хайгуул,
- Бусад анхан шатны хайгуулын төслүүд багтаж байна.

- Компанийн одоогийн хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн мэдээлэл
Хүснэгт 1-9 Компанийн хайгуулын тусгай зөвшөөрлийн мэдээлэл (Эрдэнэ Монгол ХХК)

#	Эзэмшлийн нэр	Тусгай зөвшөөрлийн дугаар	Аймаг	Сум	Га	Олгосон огноо	Олгосон жил	Шинэчлэх хугацаа	Дуусах хугацаа*
1	Цэнхэр Номин	XV-016956	Баянхонгор	Баян-Өндөр /Шинэжинст	4,668.64	09-12-11	7	18-11-11	21-12-11
2	Хөндий	XV-015569	Баянхонгор	Шинэжинст	4,514.33	10-04-14	9	19-03-14	22-04-14
3	Бургаст	XV-017875	Говь-Алтай	Цогт	857.00	15-06-05	3	18-05-05	27-06-05

Дуусах хугацаа* - хайгуулын тусгай зөвшөөрөл дуусах хугацаа, ашиглалтын тусгай зөвшөөрөл болгох хугацаа

/"Эрдэнэ Монгол ХХК"-ийн эзэмшиж буй тусгай зөвшөөрлийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 5-аас үзнэ үү./

Хүснэгт 1-10 Компанийн ашиглалтын тусгай зөвшөөрлийн тухай (Аниан Ресорсиз ХХК)


#	Эзэмшлийн нэр	Тусгай зөвшөөрлийн дугаар	Аймаг	Сум	Га	Олгосон огноо	Олгосон жил	Дуусах хугацаа
1	Хөвийн хар	MV-016836	Баянхонгор	Шинэжинст	6,041.03	11-05-26	30	41-04-26

Тайлбар - 7 дах жилийн төлбөрийг төлсөн

/"Аниан Ресорсиз ХХК"-ийн эзэмшиж буй тусгай зөвшөөрлийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 6-аас үзнэ үү./

Баерине





Хүснэгт 1-11 Компанийн хайгуулын тусгай зөвшөөрлийн мэдээлэл (Лидер Эксплорэйшн ХХК)

#	Эзэмшлийн нэр	Тусгай зөвшөөрлийн дугаар	Аймаг	Сум	Га	Олгосон огноо	Олгосон жил	Шинэчлэх хугацаа	Дуусах хугацаа*
1	Улаан	XV-016057	Баянхонгор	Баян-Өндөр /Шинэжинст	1,780.20	15-02-16	6	21-01-16	27-02-16

Дуусах хугацаа* - хайгуулын тусгай зөвшөөрөл дуусах хугацаа, шинэчлэх хугацаа

/"Лидер Эксплорэйшн ХХК"-ийн эзэмшиж буй тусгай зөвшөөрлийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 7-оос үзнэ үү./

Компани 2017 онд хаалттай хүрээнд 14.3 сая Канад долларын хөрөнгө татан төвлөрүүлсэн. Үнэт цаас гаргагчийн эргэлтийн хөрөнгө нь 2018 оны 2 дугаар улирал дуустал Компанийн төлөвлөсөн хайгуулын зардалд хангалттай хүрэлцэнэ гэж үзэж байна.

Компани 2017 оны турш томоохон хэмжээний хайгуулын ажлыг алтны бүсэд хийсэн ба үүнд 11.4 км урт Баян Хөндийн тусгай зөвшөөрлийн талбайд хийсэн хайгуулын боломжит бүсүүдэд үнэлэлт дүгнэлт өгөх ажил мөн багтаж байна. Алтан Сум (Баян Хөндийгөөс хойд зүгт 3.5 км) ба Хөндий Хойд (Баян Хөндийгөөс зүүн хойд зүгт 3.2 км) талбайг, мөн Улаан (Баян Хөндийгийн баруун залгаа) болон Алтан Нар (Баян Хөндийгөөс баруун хойд зүгт 16 км) тусгай зөвшөөрлийн талбайнуудыг голлон анхаарч ажилласан.

- Ашигт малтмалын төслүүд

- Баян Хөндийн алтны төсөл

Нээлт ба ордын төрөл

Баян Хөндий төсөл нь Баянхонгор аймгийн нутагт орших ба Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотоос баруун өмнө зүгт 980 км,-т аймгийн төв Баянхонгор хотоос 300 км зайд, Эрдэнийн 100% эзэмшдэг Хөндий хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд байрладаг. Энэ тусгай зөвшөөрлийн 2%-ийн борлуулалтын цэвэр ашгийн төлбөрийг Сандсторм Гоулд Лтд.-д ирээдүйд хуваарилахаар тохиролцсон ба хэрвээ Компани нь 2019 оны 04 сарын 14 эсвэл түүнээс өмнө \$1.2 сая долларыг Сандстормд төлбөл Цэнхэр Номин болон Хөндийн тусгай зөвшөөрлийн хувьд төлбөрийг 1% хүртэл бууруулах боломжтой.

2018-03-12-J


Баерисе



0000 59



Зураг 1-2 Баян Хөндийн төслийн газрын зураг



Хөндий хайгуулын тусгай зөвшөөрлийг анх 2010 оны 04 сард авсан. Хайгуулын тусгай зөвшөөрлийн 12 жилийн хугацааны 8 дахь жилдээ хайгуул хийж байна. Монгол Улсын Ашигт малтмалын тухай хуулийн дагуу 12 жилийн хугацаа дуусахаас өмнө хайгуулын тусгай зөвшөөрлийг ашиглалтын тусгай зөвшөөрөл болгох боломжтой байдаг.

Алтайн Чанадын бүсийг эпитеpmаль хүдэржилт болон зэс-порфирийн системийн хэтийн төлөвтэй бүс нутаг гэж үздэг. Компани нь Алтайн Чанадын бүсийн хүрээнд хийсэн эрэл-хайгуулын судалгааны ажлынхаа үр дүнд дээр дурдсан талбайг олж илрүүлсэн. Энэхүү удам бүс нутгийг хамарсан хайгуулын ажлаар хэд хэдэн алтны илрэл болон шинэ нээлтийг хийсэн. Үүнийг онцолбол: Баян Хөндий, түүнээс баруун хойд зүгт 16 км зайд орших Компанийн Алтан Нар алт-полиметаллын орд, Номин Тал болон Алтан Сум хайгуулын талбайнуудыг дурдаж болно. Түүнээс гадна Компанийн Зуун Мод молибден-зэсийн орд нь Баян Хөндийгөөс зүүн зүгт 40 км зайд оршдог.

Узбекстан улсын баруун хязгаараас эхлэн Тажикстан, Киргизстан, Хятадын баруун хойд хэсгээр дайран Монголын баруун өмнөд хэсэгт хүрэх Төв Азийн Ороген бүслүүрт харьяалагддаг Монголын Эдрэнгийн нуруунд Баян Хөндий оршдог. Энэ бүслүүрт дэлхийн хэмжээний томоохон ордууд багтдаг. Үүнд Монголын зүүн өмнөд хэсэгт байрлах Рио Тинтогийн ("Rio Tinto") зэс-алтны Оюу Толгой орд, Киргизстанд байх Сентерра Гоулдын ("Centerra Gold") Кумтор алтны уурхайнууд орно. Баян Хөндий нь Девоны галт уулын чулуулагт агуулагдах бага сульфидтай эпитеpmаль алтны ордын төрөлд хамаарагдана. Энэ Девоны агуулагч чулуулаг нь газрын гадарга дээр өгөршлийн 2 цонх байдлаар Цэрд болон Дөрөвдөгчийн хучаас хурдас доороос ил цухуйн гарсан байдаг.

2018.03.12.1

Басериев





Энэ ил гарсан талбайнууд (гарш) нь хайгуулын талбайн урд талд байрлах ба тэдгээрийг Страйкер болон Гоулд Хилл бүс, мөн Зүүн Хойд бүс гэж нэрлэсэн. Эдгээр бүсүүд нь дунджаар нийт төслийн талбайн 20%-тай тэнцэнэ. Энэ 2 гарш нь хоорондоо 600 метр зайтай байрладаг. Баян Хөндийд илрэх бүх туфлэг чулуулаг нь олон шаттай үүссэн цахиуржилт болон шаврын хувиралд хүчтэй орсон байдаг. Талбайд геологи, структур, петрограф, шаврын спектрийн болон ормын мөрийн судалгаануудыг хийсэн бөгөөд эдгээр судалгаанууд нь хүдэржилтийг бага сульфидтэй эпитеpmаль ордын төрөл болохыг харуулдаг. Алтны хүдэржилт нь агуулагч туфуудыг зүссэн кварц ± адулярын судлууд, кварцын брекчүүдтэй холбоотой гематит-спекуляритын судлууд, кварцын судлуудыг хүрээлэн эмжээрлэсэн хувирлын бүс, мөн ан цавыг дүүргэсэн гематит-спекуляритын эрдэсжилттэй холбоотой байх хувирсан агуулагч чулуулагт тархсан байдаг. Алтны мөхлөгийн хэмжээ янз бүр байгааг олон цооногоор тогтоогдсон. Ерөнхийдөө жижиг мөхлөгтэй байна. Цөөн цооногуудад маш жижиг мөхлөгтэй сарнисан пирит ажиглагдсан. Страйкер бүсийн баруун хойд хэсэгт байх VKD-32 гэх зэрэг цөөн цооногууд пиритээр баяжсаныг эс тооцвол, Баян Хөндий нь ерөнхийдөө сульфидын эрдэсжилтгүй байдаг. Баян Хөндий нь Хишикари (Япон), Купол (Орос) болон Раунд Маунтэйн (АНУ) зэрэг дэлхийн бага сульфидтэй ордуудтай ижил төстэй бүтэцтэй байдаг.

Бие даасан зөвлөхүүд

2017 онд Компани нь хэд хэдэн хараат бус судалгааг Баян Хөндийд хийлгэсэн. Үүнд чөмгөн дээжний болон гадаргуун чулуун дээжийн спектрийн шинжилгээ, эпитеpmаль алтны системээр мэргэшсэн мэргэжилтний үнэлгээ, геофизикийн тайлал, структурын судалгаа, гурван хэмжээст загварчлал зэрэг ажлууд багтана. Эдгээр ажлуудыг нэгтгэн боловсруулж, хайгуулын оновчтой төлөвлөлт болон нөөцийн ангиллыг тогтоох судалгааг хийж байна. Судалгааны ажлуудад:

- Оттавад төвтэй, эпитеpmаль алтны системийн дэлхийн тэргүүлэх мэргэжилтэн, хараат бус зөвлөх Др. Жэффри Хеденквист (Dr. Jeffrey Hedenquist) нь 2016 он болон 2017 оны 3-р улиралд Баян Хөндий төсөлтэй танилцан ажилласан. Дараа нь 2016 оны 3-4-р улирал болон 2017 оны 2-р улиралд хийгдсэн өрөмдлөгийн ажлын үр дүнг нягтлан, геологийн тайлал болон өрөмдлөгийн ажлын үр дүнг сайжруулахаар дахин 2017 онд Баян Хөндийд ажилласан.
- Голландад төвтэй, мэргэшсэн структур геологич, хараат бус зөвлөх Др. Армелле Клоппенбург (Dr. Armelle Kloppenburg) 2017 оны 3-р улиралд Баян Хөндий, Алтан Нар болон Алтан Сум төслүүдтэй танилцсан. Др. Армелле Клоппенбург геологи

Б. Сергеев



2018-03-12



структурын цогц судалгааг Монголын баруун өмнөд хэсэгт байрлах Компанийн алтны төслүүдэд болон илүү өргөн металлогенийн бүсэд хийсэн. Үр дүнд нь алтны хүдэржилтийн хяналтын талаарх шинэ ойлголтыг бий болгосон бөгөөд тэрээр ирээдүйд өрөмдөж болох боломжит талбайнуудыг санал болгосон.

- Эпитермаль болон порфир системийн хувирлын судалгаагаар мэргэшсэн Плас Минералс ("Plus Minerals LLC") ХХК-ийн Др. Б.Хашгэрэл болон ноён Иманц Кавалерис (Imants Kavalieris) нар 2016 оны 3-4-р улирал болон 2017 оны 2-р улирлын өрөмдлөгийн ажлын чөмгөн дээжийг судлан, гидротермаль систем дэх хувирлын бүсүүдийг тодорхойлж, ирээдүйн өрөмдлөгийн талбайг ялгахад хувь нэмэр оруулсан.
- Шинэ Зеланд улсын Хэрэглээний Петрологийн Үйлчилгээ ба Судалгааны Төвийн ноён Антони Күүт (Anthony Coote) петрографийн судалгааг 2016 болон 2017 онуудад Баян Хөндийн чөмгөн дээжинд хийсэн. Энэ ажлын үр дүнд гидротермаль системийн орчин, алтны хүдэржилтийн тархацын хяналт болон ордын ерөнхий гаралзүйн тайлалыг хийхэд тус нэмэр боллоо.
- Өрөмдлөгийн оновчтой талбайг сонгоход туслах зорилгоор хүдэржсэн бүсүүдийн гурван хэмжээст загварыг Террэйн Геосайнс ("Terrane Geoscience Inc") компани хийж байгаа. Энэ загварчлалд геологи, өрөмдлөг, структур, спектр, геохими болон геофизикийн бүх мэдээллийг оруулан хийж байгаа.
- Зонге Интернэшнэлийн ("Zonge International") ноён Чэт Лайд соронзон болон цахилгаан хайгуулын (IP) өгөгдлийн бүх санг боловсруулсан ба чанарын хяналтыг хийж гүйцэтгэсэн.
- РангеПинкокМинарко Лимитэд ("RungePincokMinarco Ltd") нь нөөц тогтоох өрөмдлөгийн ажлаас урьтаж хамгийн тохиромжтой өрөмдлөгийн торны зайг сонгох зөвлөгөөг өгч, өнөөг хүртэл хийсэн бүх ажлын үр дүн дээр бие даасан дүгнэлтийг гаргаж байгаа.
- ЭкоТрэйд ХХК нь Цэнхэр Номин болон Хөндий тусгай зөвшөөрөлт талбайд байгаль орчны болон нийгэм, эдийн засгийн суурь судалгаа хийсэн.
- Охь Ус ХХК нь Алтан Нар, Баян Хөндий ордууд дахь боловсруулалтын боломжит усны хэрэгцээг тодорхойлох гидрогеологийн хэтийн төлөв, нөөцийн тайланг боловсруулахаар томилогдсон.
- Кью Эм Си ХХК (QMC LLC) нь Цэнхэр Номин болон Хөндий тусгай зөвшөөрөлт талбайн гидрологи болон геотехникийн нөхцөлд урьдчилсан үнэлгээ хийлгэхээр томилогдсон.

Баернесс



2018.03.12


NON-FERROUS METALS
MONGOLIA
BYRT 38 01
0000-02

СЭХ
БҮРТГЭВ
01

Структурын тайлал

2017 оны 3-р улиралд Др. Армелле Клоппенбург структурын цогц судалгааг Компанийн алтны төслүүд дээр болон илүү өргөн Хөндийн металлогенийн бүсэд хийсэн. Энэ ажлын үр дүнд Баян Хөндий төслийн структурын тухай шинэ ойлголтууд бий болсон. Алтны хүдэржилтийн үйл явцыг хожуу Девон болон Карбоны эхэн үед явагдсан гэж үзэж байгаа бөгөөд хүдэржилт нь бүс маягийн параллель тэлэлтийн структурыг ашиглан түрж гарч ирсэн гэж тайлбарлагдаж байна. Баян Хөндий талбайн зүүн хойш чиглэсэн тэлэлтийн хагарлууд нь баруун хойш чиглэсэн ул суурийн структурыг огтолж байгаа бөгөөд энэ нь алт агуулсан уусмалын дамжих хоолой болсон гэж таамаглаж байна. Энэ талбайд солбицох хавтгайн структур (relay ramp structure) үүсэн хөгжсөнөөр дараа дараагийн хагарлууд, ан цавууд болон тэлэлтийн ан цавууд үүсэн, уусмалын нэвчил болон хүдэржилттэй судлууд хуримтлагдан бөөгнөрөхөд нөлөөлсөн. Баян Хөндийн алтны онцгой өндөр агуулгатай хэсгүүдтэй холбоотойгоор энэ структуруудын хамгийн хүдэржих боломжтой талбай нь гүний гол хагарлуудын огтлолцлын ойр орчим гэж үзэж байгаа. Мөн хагарал болон агуулагч структуруудын ам, хагарлын өлгөө хана /hanging wall/, тэлэлтийн ан цав зэрэг нь үүнд бас хамаарагдана. Ийм талбайнуудад 2017 оны 4-р улиралд өрөмдлөгийн ажил хийсэн ба цаашдаа эдгээр талбайд төвлөрч ажиллана. Бүсийн эрлийн ажлыг хийхдээ структурын чиглэлийн дагуу үүнтэй ижил төстэй структуруудыг олж нээхэд төвлөрөх бөгөөд бүсийн хэмжээнд алтны хүдэржилт хайхдаа тэлэлтийн ан цав хаана илүү эгц босоо болж байгаа, эсвэл өөр томоохон структуртай огтлолцож байгаа, эсвэл илүү боломжтой нэгжүүдэд голлон анхаарч ажиллана.

Зураг 1-3 Баян Хөндийн төслийн Геологийн зураг ба өрмийн цооногуудын байршлын зураг




2018 03 12 1

Баермае

УЛААНБААТАР ХОТ
МХБ-ийн гишүүн
Андеррайтер
Брокер, дилерийн
БҮНДСЭР
УИХ
1119205447-2017

Handwritten signature and initials.

Зураг 1-4 Зарим үр дүнг онцгойлон тэмдэглэсэн Баян Хөндийн 2017 оны хөндлөн зүсэлт



2017 онд Мидфийлд болон Хойд Мидфийлд бүсэд өрөмдлөгийн ажил хийснээр алтны хүдэржилтийн үргэлжлэлийг урд зүгт гүн рүү нь тэлж чадсан. Өмнө нь мэдээлж байсан Мидфийлд бүсийн төвд байх алтны өндөр агуулгын үргэлжлэлийг баталгаажууллаа. Үүнд: цооног VKD-231 нь 193 метр гүнд (босоо гүн: 140 метр) одоогоор мэдэгдэж байгаа хамгийн өндөр алтны агуулга болох 1 метрийн 2200 г/т алт болон 948 г/т мөнгө агуулсан 158 г/т алттай 14 метрийн интервал огтолсон нь багтаж байна. Ингэснээр талбайн дурдсан хэсэгт Баян Хөндийн гидротермаль үйл ажиллагаа хамгийн эрчимтэй явагдсан бөгөөд алтны хүдэржилт хамгийн ихээр агуулж байгаа гэсэн ажиглалтыг дэмжиж өглөө. Мидфийлд болон Хойд Мидфийлд бүсүүдэд хүдэржилт тасралтгүй үргэлжилж байгааг хэд хэдэн цооноогоор мөн баталгаажуулсан. Мидфийлд бүсээс зүүн хойш 165 метр зайд буюу Хойд Мидфийлд бүсэд өрөмдсөн VKD-179-р цооног нь 12.5 г/т алттай 9 метрийг агуулсан, 3.3 г/т алттай 40 метрийн интервал огтолсон. Үндсэн Мидфийлд бүсээс хойд зүгт 80 метр зайд өрөмдсөн VKD-178-р цооног нь 19 метрийн 4.6 г/т алт агуулсан, 1.6 г/т алттай 71.6 метр, Мидфийлд бүсээс хойд зүгт 200 метр зайд өрөмдсөн VKD-182-р цооног 9 метрийн 8.2 г/т алт агуулсан 2.1 г/т алттай 39 метрийг тус тус огтолсон.

2017 оны 4-р улиралд хийсэн Компанийн Мидфийлд бүсийн өрөмдлөгийн ажил нь Мидфийлд бүсийн хойд хязгаарыг Зүүн Хойд бүс рүү чиглүүлэн тэлэхэд төвлөрч байсан ч шинээр зүүн зүгт тэлж чадсан. Мидфийлд бүсийн зүүн хязгаараас зүүн тийш 80 метр-т

Баярц

Хот
Зүүн
Анхлайтер
Хүрний
Бидэсүү
ШК №
44
2018 03 12 1



орших ВКD-210-р цооногт 44.8 г/т хүртэл алтны агуулгатай 43 метрийн 1.8 г/т алт илэрсэн. Энэ нь Мидфийлд бүсийн зүүн хязгаарыг тэлж өгсөн бөгөөд дараагийн шатны өрөмдлөгийн ажил хийгдэх шаардлагатайг харуулж байна.

Баян Хөндий төслийн талбайд 1,192 тууш метр урттай 6 цооног (ВКD-229 – ВКD-234)-ийг 11-р сард өрөмдсөн. Үүний 2 цооногийг (ВКD-231 болон ВКD-232) Хойд Мидфийлд бүсэд алтны өндөр агуулгатай хэсгүүдийн гүний үргэлжлэлийг шалгахар тавьсан. ВКD-231 цооног нь 2,200 г/т алт болон 948 г/т мөнгөний агуулгатай 1 метрийг агуулсан, 158 г/т алттай 14 метрийн интервалыг 193 метрийн гүнд (босоо гүн: 140 метр) огтолсон. Алтны хүдэржилт нь жижиг мөхлөгтэй нүдэнд үзэгдэх алт байсан бөгөөд агуулагч нь олон үе шаттай үүссэн кварц-адуляр-спекуляритын судал болон гематитийн брекч байсан. Энэ хүдэржсэн 14 метр нь 118 метр гүнээс эхлэх бөгөөд 112 метр зузаанг бүхий 0.1-ээс 2.8 г/т алттай хүдэржилтийн өргөн бүсэд огтлогдсон. Энд огтлогдсон өндөр агуулга нь энэ цооногоос хойш 30 метр зайд байх ВКD-110 цооногийн 115 г/т алттай 1 метр болон 108 г/т алттай 1 метр, мөн цооногоос баруун хойш 30 метр зайд байх ВКD-111-р цооногийн 44 г/т алттай 1 метр болон 33 г/т алттай 1 метр гэх мэт өндөр агуулга гүндээ үргэлжилж байгааг баталж өгсөн. Энэхүү өндөр агуулгатай судлуудыг олж нээснээр 2018 онд талбайн энэ хэсэгт нэмэлт, нарийвчилсан өрөмдлөгийн ажил хийх шаардлагатай боллоо.

Зураг 1-5 Нүдэнд үзэгдэх алт бүхий чөмгөн дээж БХД-231; 1 метрт 2,200 гр/т алттай



2018-03-12

ВКD-232-р цооног нь ВКD-231-р цооногоос хойд зүгт ойролцоогоор 65 метр, Мидфийлд бүсээс хойд зүгт 100 метр зайд өрөмдөгдсөн. Энэ талбайг урьд нь 80 метрийн тороор өрөмдөн, харьцангуй бага агуулга илэрч байсан. Уг цооног нь 10 г/т алтнаас илүү өндөр агуулгатай хэд хэдэн хүдэржсэн хэсгүүдээс бүрдэх 8.3 г/т алттай 22 метрийн интервалыг 90.5 (босоо гүн: 74 метр) метрийн гүнд огтолсон.

2017 оны 4-р улиралд 3 цооногийг Мидфийлд бүсийн урд болон зүүн урд хязгаарын дагуу өрөмдсөн (ВКD-229, ВКD-230 ба ВКD-233). Мидфийлд бүсийн төв хэсэгт ойр өрөмдсөн

Басриаа





BKD-230 цооногт 31 метр гүнд (босоо гүн: 24 метр) дунджаар 1.8 г/т алттай тасралтгүй хүдэржсэн 127 метр интервал огтлогдсон ба үүний 25 метр нь 5.8 г/т алттай байсан. Нэмэлт 2 цооног (BKD-229 ба BKD-233) мөн алтны өндөр агуулга огтолсон. BKD-233 нь алтны агуулга багатай биет огтолсон боловч Мидфийлд бүсийн зүүн урд хилийг тэлж өгсөн ба энд алтны хүдэржилт нээлттэй хэвээр үлдэж байна. BKD-229 нь энд одоогоор мэдэгдэж байгаа хамгийн бага гүнд алтны хүдэржилтийг огтолсон цооног болоод байна.

Баруун Страйкер бүс

Компани нь, хоорондох зай нь 20-80 метр байх нийт 27 цооногийг Страйкер бүсийн баруун хэсэгт 375 x 250 метр талбайд өрөмдсөн. Цооногуудын босоо гүн нь 97-оос 340 метрийн хооронд хэлбэлзэх бөгөөд дундаж гүн нь 223 метр байна. Эдгээр 27 цооногийн 26 нь алтны хүдэржилтийн аномаль утга бүхий хэсгүүдийг огтолсон. Үүний 13 нь алтны их өндөр агуулгатай буюу 10 г/т-с илүү агуулгыг огтолсон. 2017 оны 4-р улиралд Компани нь 3 цооногийн (BKD-219 – BKD-221) үр дүнг мэдээлсэн ба үүнд Страйкер бүсээс баруун тийш 250 метр зайд байх BKD-220 цооногт огтлогдсон 1 метрийн 116 г/т алт агуулсан дунджаар 9.2 г/т алттай 15 метр гэх зэрэг үр дүнгүүд багтаж байна. Дээрх үр дүн нь энэ бүсэд огтлогдсон хамгийн өндөр агуулга юм. Мөн нэмэлт өндөр агуулгатай бүсүүд Баруун Страйкерт байх боломжтойг харууллаа.

Металлург

Металлургийн хүндийн хүч болон цианидаар уусган боловсруулах технологийн судалгааг Баян Хөндийн анхны өрөмдлөгийн ажлын (газрын гадаргаас 50 метрээс илүүгүй гүнд өрөмдсөн 15 цооног) 2 дээжинд (24.9 г/т алттай - өндөр агуулгатай, 0.7 г/т алттай - бага агуулгатай дээжүүд) Бритиш Колумбын Парксвиллийн Блү Көүст Ресөрч ХХК ("БКР") хийж гүйцэтгэсэн. Өндөр агуулгатай дээжийг хүндийн хүчний аргаар сайн боловсруулж, 71%-ийн алтны гарцтай байсан. Алтны хүндийн хүчний боловсруулалтын муруй шугамаас, алтны багавтар мөхлөгтэй хэсгүүд хүндийн хүчний аргаар боловсруулж болох их хэмжээний алттай болохыг илрүүлсэн. Өндөр агууламж бүхий дээжийн баяжмал нь дээжийн үндсэн жингийн 1.2%-тай тэнцэж байсан бөгөөд 1381 г/т алт болон 200 г/т мөнгөний агуулгатай байсан. Хүндийн хүчний боловсруултаар бага агуулгатай дээж нь бага алтны гарцтай байсан.

Хүндийн хүчний аргаас гарсан хаягдалд буюу өндөр болон бага агуулгатай дээжинд хоёуланд нь лонх эргэлтийн аргаар цианидын уусгалт хийсэн бөгөөд металл авалт аль алиных нь хувьд өндөр гарлаа (өндөр агуулгатай дээжинд 95%-тай ба бага агуулгатай

2018 03 12 17

Баярмаа





дээжинд 86%-тай). Хүндийн хүчээр баяжмал ялгах болон хүндийн хүчний хаягдлыг цианидын аргаар боловсруулах аргуудыг хослуулснаар нийт металл авалт маш өндөр гарсан ба өндөр агуулгатай дээжинд 99%, бага агуулгатай дээжинд 92% байна.


Энэ үр дүн нь Баян Хөндий нь бутлахад алтны чөлөөлөгдөх чадвар сайн, уламжлалт аргаар боловсруулт хийх бүрэн боломжтойг харуулж байна.

Компани нь металлургийн 2 дахь шатны судалгааг 2017 оны 2-р улиралд эхлүүлсэн ба үүнд өөр өөр агуулга бүхий дээжүүдийн боловсруулалт, бутлагдах шинж чанарын судалгаа болон овоолгон уусгалтын аргууд багтсан болно. Баян Хөндийн анхдагч 2 дээжийн үр дүн нь бутлуураар бутлахад чөлөөлөгдөх алттай, уламжлалт аргаар боловсруулж болохыг харуулсан. ВК-16-03 (4.3 г/т алттай): 48 цагийн уусгалтын дараа алтны гарц 96% байсан ба 96 цагийн дараа алтны гарц 97%-тай болсон. Дээжийн 80% нь 60 микрон хүртэл бутлагдсан ба 40% хатуу, 1.0 г/л найрлагатай цианидын уусмалд хийсэн. ВК-16-04 дээжийн анхдагч агуулга нь 4.47 г/т байсан ба бүрэн хэмжээний цогц туршилтыг энэ дээж дээр хийсэн. Үүнд нунтгийн хэмжээ, уусгах хугацаа болон цианидын уусмалын тун зэргийг өөр өөрөөр тохируулан туршсан бөгөөд хүндийн хүчний боловсруулалт хийсэн тохиолдолд нийт металлын гарцыг дүгнэн үнэлсэн. Нунтгийн 80% нь 60 микроноор гарсан дээжийн 48 цагийн уусгалтын дараагаар металлын гарц 91-93.4% байсан ба 96 цагийн дараагаар металлын гарц 95%-тай болсон. Бутлагдах шинж чанар нь Бонд Род Милл Уорк Индексийн 17.8 кВтц/т болон Бонд Болл Милл Уорк Индексийн 16.1 кВтц/т гэж судалгаагаар тогтоогдсон. Хоёрдугаар шатны судалгааны ажил 2018 онд үргэлжлэх ба 1.5-с 3 г/т хүртэлх агуулгатай дээжүүдэд голдуу хийгдэнэ.

Дүгнэлт

Баян Хөндийд өнөөг хүртэл хийсэн хайгуулын ажлын тайлан нь өндөр үр дүнтэй байсан ба газрын гүний болон гадаргуун алтны өндөр агуулга бүхий хүдэржилтийн тархалт болон тасралтыг тогтоох цаашдын хайгуулын ажилд үргэлжлүүлэн дэмжлэг үзүүлсээр байна. 2017 онд Баян Хөндийд хийсэн ажил нь нөөц тогтоох боломжтой талбайнуудын (Страйкер, Страйкерын баруун тал, Алтан Толгой, Мидфийлд болон Хойд Мидфийлд бүсүүд) цаашдын хэтийн төлөвийг өсгөн, мэдэгдэж буй хүдэржилттэй талбайг тэлэх хос зорилтыг ордын урьдчилсан техник эдийн засгийн үндэслэлийн тайлангаас өмнө биелүүлж чадсан. Сүүлийн үед хийгдсэн геологийн судалгаанууд, өнөөг хүртэл хийгдсэн өрөмдлөгийн ажлууд нь алтны хүдэржилтийн хяналтын тухай ойлголтыг өргөжүүлж, Баян Хөндийн өндөр агуулгатай бүсүүд болон түүний эргэн тойронд шинэ ордуудыг олж илрүүлэх боломжийг нэмэгдүүлж байна.

Баярмаа



2018-03-12J



Нэмэлт техникийн мэдээллийг www.erdene.com эсвэл www.SEDAR.com цахим хуудсаас авах эсвэл хараат бус зөвлөх КьюЭмСи (QMC) Группийн техникийн дүгнэлттэй танилцана уу.

Төсөл хөгжүүлэлтийн төлөвлөгөө:

Компани нь Баян Хөндийн төслийг газрын гадаргад ойр, өндөр агуулгатай бөгөөд цаашид ил уурхай болгон олборлох боломжтой төсөл гэж үзэж байна. Энэхүү төслийн нөөцийг тогтоох ажлын хүрээнд 2018 онд холбогдох өрөмдлөгийн ажлуудыг гүйцэтгэхээр төлөвлөсөн. Мөн цаашлаад олборлолтын шатанд чиглэн, ашиглалтын тусгай зөвшөөрлийг авахын тулд шаардлагатай техник эдийн засгийн тайлан, төлөвлөгөөг боловсруулах, ажилуудыг хийхээр төлөвлөсөн.

- **Алтан Нар алт-полиметалийн төсөл**

Төслийн нээлт ба ордын төрөл

Алтан Нар алт-полиметалийн төсөл нь Монголын баруун өмнөд хэсэгт орших Компанийн Цэнхэр Номин хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд оршдог. Энэ хайгуулын тусгай зөвшөөрөл нь хайгуулын тусгай зөвшөөрөлд олгогддог дээд хэмжээ болох 12 жилийн ес дэх жилд хайгуул нь хийгдэж байгаа. Монгол улсын Ашигт малтмалын тухай хуулийн дагуу хайгуулын тусгай зөвшөөрлийг 12 жилийн хугацаа дуусахаас өмнө хэдийд ч ашиглалтын тусгай зөвшөөрөл болгох боломжтой байдаг. 4,669 га талбай бүхий Цэнхэр Номин тусгай зөвшөөрлийг Компанийн охин компани "Эрдэнэ Монгол ХХК" 100% эзэмшдэг. Энэ тусгай зөвшөөрөл нь Сандстормд Гоулд Компанид 2%-ийн Борлуулалтын цэвэр ашгийн төлбөр төлөх үүрэг хүлээсэн ба Компани нь 2019 оны 4 сарын 14-ний өдрөөс өмнө \$1.2 сая долларыг Сандстормд төлснөөр Цэнхэр Номин болон Хөндийн тусгай зөвшөөрлийн нөөцийн төлбөрийг 1% хүртэл бууруулах боломжтой.

Компанийн сүүлийн 6 жилд явуулсан хайгуулын ажлын дүнд Алтан Нар нь томоохон хэмжээний, сульфидтэй алт-мөнгө-хар тугалга-цайрын эрдэсжилттэй, шинэ эпитеpmаль систем болохыг тогтоосон. Ялангуяа 2013 оноос 2017 онуудад хийгдсэн хайгуулын ажлаар буюу суваг малталтын ажил, гадаргуун геологийн зураглал, геохими болон геофизикийн судалгааны ажлууд болон олон шатат эрэл болон нөөц тогтоох өрөмдлөгийн ажил хийснээр хүдэржилттэй талбайг ихээр тэлж чадсан. Үүнд 5.6 x 1.5 км хүдэржилттэй корридор 18 алт-мөнгө-полиметаллын хэтийн төлөвт талбайг илрүүлсэн. Анхны нээлтүүдийн нэг болох "Нээлтийн бүс" болон Хойд Холбоос бүсүүд нь хамгийн их судлагдсан талбайнууд юм. Газрын гадаргууд дөт гүнд өндөр агуулгатай бүсүүдийг

Баермаа




[Handwritten signature]

2018 03 12

агуулдаг. 2015 оны 1-р улиралд энэ 2 бүс дээр NI 43-101-ийн нөөцийн урьдчилсан тайлангийн мэдээг гаргасан (дэлгэрэнгүй мэдээллийг доороос үзнэ үү). Үлдсэн 16 дэд талбайн заримд нь өрөмдлөг огт хийгдээгүй, заримд нь анхан шатны өрөмдлөг хийсэн. Тэдгээр талбайнуудыг Эрдэнэ өндөр агуулгатай эрдэсжилттэй нэмэлт бүсүүд нээгдэх өндөр хэтийн төлөвтэй талбай гэж үзэж байгаа.

Зураг 1-6 Алтан Нар талбайн байршлын зураг



Компани нь 2017 онд Алтан Нар төсөл дээр 5,794 тууш метр өрөмдлөг хийсэн. Компани өмнө нь NI 43-101 ашигт малтмалын нөөцийн тооцоо хийсэн тухай дээр дурдсан байгаа. Түүнээс гадна шинэ боломжит талбайнуудыг шалган илрүүлэх, "Нээлтийн бүс" болон Хойд Холбоо ордуудын ойр орчимд талбай тэлэх өрөмдлөгийн ажлуудыг өргөжүүлэн гүйцэтгэсэн нь амжилттай болсон. Тэдгээрээс Нээлтийн бүсийн төв хэсэгт 20 метрийн 10.3 г/т алттай (TND-110) өндөр агуулгатай бүс огтлогдсон нь нөөцийг цаашид өсгөх ажлыг баталгаажуулсан онцгой ач холбогдолтой боллоо.

Нээлт ба ордны төрөл

Алтан Нарыг Компанийн 2011 оны 3-р улиралд хийсэн бүс нутгийн эрэл болон зураглалын ажлаар нээн илрүүлсэн. Алтан Нар төслийг магма болон порфирын ордтой холбоотой,

2018 03 12 J



Баярмал

[Handwritten signature]



ихэвчлэн полиметаллаар баяжсан байдаг дундлаг сульфидтэй карбонат полиметалл алтны систем гэж тайлбарладаг. Энэ төрлийн алтны хүдэржилт нь зүүн өмнөд Азийн хамгийн эдийн засгийн үр ашигтай алтны хүдэржилтийн төрөлд хамаардаг бөгөөд Индонезийн Келиан уурхай (одоо хаагдсан боловч урьд нь Рио Тинто олборлолт хийж байсан) болон Папуа Шинэ Гвинейн Поргера алтны уурхай (Баррик Гоулд олборлолт хийж байгаа), мөн дэлхийн өөр бусад газруудад байх Эквадорын Фрута дэл Нортэ алтны уурхай (Лундин Гоулд Инк олборлолт хийж байгаа), Колорадын Крипэл Крик болон Виктор алтны уурхай (АнглоГоулд Ашанти Лимитэд олборлолт хийж байгаа), Руминий Росиа Монтана (Росиа Монтана Гоулд Корпораци олборлолт хийж байгаа) болон дэлхийн шилдэг 5 мөнгө олборлогч компанийн нэг Мексикийн Пенаскүйто (Гоулдкорп олборлолт байгаа) зэрэг ордууд үүнд багтана. Энэ төрлийн орд нь ихэвчлэн брекчийн хоолойнуудтай (диатерм) холбоотой байдаг ба 1 км-ээс ч илүү урт үргэлжилсэн байх боломжтой. Жишээлбэл, Келиан ил уурхайг 500 метр гүнд хүртэл олборлосон байдаг.

Өрөмдлөгийн үр дүн

Нээлтийн бүс

Нээлтийн бүсэд өнөөг хүртэл хийсэн өрөмдлөгийн ажлаар энэ бүс нь хамгийн багадаа 500 метр урт сунасан болохыг илрүүлээд байна. Өрөмдсөн ихэнх цооног нь бага гүнтэйгээр (жинхэнэ босоо гүн: <150 м) суналын дагуу хоорондоо 20-100 метрийн зайтайгаар өрөмдөгдсөн. Тэдгээр нь алт, мөнгө, хар тугалга болон цайрын хүдэржилт босоо болон хажуу тийшээ үргэлжилж байгааг харуулсан. Хүдэржилт нь хойш-зүүн хойш чиглэлтэй структурээр хянагдсан, бараг босоо эгц уналтай эпитеpmаль брекчийн бүсүүдтэй холбоотой.

Компани нь 2016 оны сүүлээр Нээлтийн бүсийн өрөмдлөг хийгдээгүй байсан төв хэсэгт алтны өндөр агуулга бүхий интервал тогтоосон билээ. Энэ хүдэржилт нь гүн рүүгээ нээлттэй хэвээр үлдсэн. Энэ шинэ нээлт нь гол структуруудын огтлолцол дээр байрлах бөгөөд Нээлтийн бүс болон 5.6 км урттай "Алтан Нар"-ын хүдэржилтийн чиглэл дээр нэмэлт өрөмдлөг хийх хэрэгцээг бий болгосон. Энэ нээлт нь Нээлтийн бүсийн төв хэсэгт илрээд байсан бага агуулгатай интервалыг хамруулсан 2015 оноос өмнөх ажил дээр үндэслэн хийгдсэн Нээлтийн бүсийн NI 43-101 нөөцийн тайлангийн дараа хийгдсэн нээлт юм. Доорх хүснэгт нь 2016 оны 4-р улирал, 2017 оны 2-р улирал болон 2017 оны 3-р улирлуудад нээгдсэн өндөр агуулгатай шинэ бүсүүдийн үр дүнг харуулж байна.

Хүснэгт 1-12 Нээлтийн бүс болон Алтан нар ордын хайгуулын үр дүн

Багш



2018.03.12



Цооногийн дугаар	Огтолсон гүн (м)	Интервал (м) ⁽¹⁾	Алт (гр/т)	Мөнгө (гр/т)	Зэс (%)	Хар тугалга (%)	Цайр (%)	Алтны дүйцэх нэгж ⁽²⁾ (г/т)
ТНД -90	92 м	5.8 м	5.4	53.1	0.03	0.51	0.97	7.0
ТНД -101 ⁽³⁾	96 м	15 м	52.3	125	0.69	2.49	2.87	56.9
ТНД -104	133 м	8 м	6.21	91.6	0.04	1.15	1.29	8.84
ТНД -105	100 м	14 м	7.92	43.7	0.23	0.67	1.16	9.52
ТНД-110	97 м	20 м	10.3	37.5	0.13	0.79	0.93	11.8

(1) Тайланд дурьдсан интервалууд нь бодит зузаан биш болно. Одоогийн байдлаар хүдрийн биетүүдийн огторгуй дахь чиглэлийг тооцоолох хангалттай мэдээлэл байхгүй байна.

(2) Алтны дүйцэх нэгжийг зөвхөн алт, мөнгө, хар тугалга-цайрын агуулгуудыг дан ганц алтны агуулга хэлбэрээр дүрслэн илэрхийлэх зорилготой ашигласан болно. Үүнд уурхайн үйл ажиллагааны явцад учрах боломжтой металл алдалтыг тооцоогүй. Тооцооллыг ам. доллараар хийсэн ба ханшийг - алт \$1200/унц, мөнгө \$18/унц, хар тугалга ба цайр \$0.90/фунт гэж тооцсон.

(3) ТНД-101 цооног нь Нээлтийн бүсийн хүдэржилтийн чигт хэвгий өнцгөөр, геофизикийн судалгаагаар ажиглагдсан хөндлөн зүссэн структурыг тэгш өнцгөөр огтлохоор өрөмдөгдсөн хайгуулын нэмэлт цооног юм.

Үндсэн Нээлтийн бүсийн гадна талд хойш-зүүн хойш чиглэлтэй унз бүрийн зузаантай (53 метр хүртлэх үзэгдэх зузаантай) хагас босоо, 1 г/т-оос дээш алттай эрдэсжсэн бүсүүдийг илрүүлсэн. Үүнд Нээлтийн бүсийн Хойд хүдрийн биетэд илэрсэн дунджаар 5.8 г/т алттай (7.8 г/т алтны дүйцэх нэгж (AuEq)) 19 метр интервал багтана. 2014 оны 4-р улиралд Нээлтийн бүсийн Хойд биетэд өрөмдсөн цооногт (TND-70) 8 метрийн 11.4 г/т алт (13.6 г/т AuEq) агуулсан 4.2 г/т алттай (5.1 г/т AuEq) 30 метр интервал илэрсэн. 2015 оны 10-р сард Нээлтийн бүсэд, цооног хооронд хийсэн нэмэлт өрөмдлөгийн ажлын үр дүнг зарласан. Нээлтийн бүсийн Өмнөд биетэд өрөмдсөн TND-92-р цооног 9 метрийн 7.3 г/т алт (9.2 г/т AuEq) агуулсан 2.0 г/т алттай (2.8 г/т AuEq) 38 метр интервалыг 43-аас 81 метрийн гүнд огтолсон. Мөн Нээлтийн бүсийн Өмнөд биетэд өрөмдсөн TND-90-р цооног 2.0 г/т AuEq (1.4 г/т алт, 20 г/т мөнгө болон 0.68% хар тугалга болон цайр) бүхий 53 метр интервалыг 78-аас 131 метрийн гүнд огтолсон. Нээлтийн бүс нь зүүн хойд зүгт суналынхаа дагуу болон гүндээ нээлттэй байгаа.

2017 оны Нээлтийн бүсийн өрөмдлөгийн ажлын хураангуй

2017 оны 05-р сарын 30-нд Компани Нээлтийн бүсийн төв хэсэгт өрөмдсөн 6 цооногийн (нийт 1,326 тууш метр) мэдээллийг танилцуулсан. Эдгээр цооногууд нь 2016 оны 04-р улиралд илрүүлсэн алт-полиметаллын өндөр агуулга бүхий бүсийн үргэлжлэлийг баталгаажуулах зорилготой байсан. Эдгээр 6 цооногийг хүдэржсэн бүсийг тэгш өнцгөөр

Багшиаа



2018 03 12



огтлохоор зүүн урагш 45 градусын өнцгөөр өрөмдсөн. Үүнд TND-105-р цооногт 100 метр гүнд 9.5 г/т AuEq (7.9 г/т алт, 43.7 г/т мөнгө ба 1.83% хар тугалга болон цайр) бүхий 14 метр, мөн TND-104-р цооногт 126 метр гүнд 3.1 г/т AuEq (2.2 г/т алт, 29.7 г/т мөнгө ба 0.76% хар тугалга болон цайр) бүхий 37 метр (доорх хүснэгтийг харна уу) гэх зэрэг үр дүнгүүд багтаж байна. Энэ үр дүн нь Нээлтийн бүс дэх алт-полиметаллын хүдэржилт болон зэсийн агуулга нь гүн рүүгээ илүү өсөх боломжтойг харуулж байна. Хүдэржилт нь гүн рүүгээ нээлттэй хэвээр байгаа.


2017 оны 10-р сарын 12-нд Компани Нээлтийн бүс дээр болон Нээлтийн бүсийн тэлэлт дээр хийсэн сүүлийн өрөмдлөгийн ажлаа тайлагнасан. TND-110-р цооног нь Нээлтийн бүс дэх өндөр агуулгын тухай Эрдэнэд буй мэдээллийг өргөжүүлсэн бөгөөд энэ нь зэс зэрэг полиметалл болон үнэт металлын агуулгатай байх карбонат полиметаллын ордын загварыг баталгаажуулж байгаа юм. Доорх хүснэгтэд байх нөөцийн тайлангийн дараа илрүүлсэн алтны өндөр агуулгатай интервалуудаас гадна, цооног TND-110-т полиметаллын нэн өндөрсөн агуулга илэрсэн, тухайлбал, 6.2% хар тугалга, 3.8% цайр, 0.85% хүртэл зэс агуулсан судлуудыг огтолсон. Нээлтийн бүсэд огтлогдсон өндөр агуулга бүхий үнэт болон полиметалл нь гүндээ нээлттэй. Энэ өндөр агуулгатай шинэ бүс нь доош гүндээ үргэлжлэх боломж өндөртэй. Үүнийг дараагийн нарийвчилсан өрөмдлөгийн ажлаар тодруулах болно.

Нийт 1,645м урт 8 цооногийг Нээлтийн бүсийн боломжит үргэлжлэлийн дагуу болон дагалдах структурууд дээр өрөмдсөн бөгөөд эдгээр бүх цооногууд нь хүдэржилтийн бүсийг амжилттайгаар тэлэн, дараагийн шатанд өрөмдөх талбайнуудыг тодорхойлж өглөө.

Нээлтийн бүсээс баруун хойш 100 метр зайд шинэ параллель структур нээгдсэн. Өрөмдсөн 2 цооногт (TND-113 болон TND-114) алт болон полиметаллын өндөр агуулга огтлогдсон. Үүнд 1 метрийн 14.6 г/т алт, 2.4% цайр болон 3.8% хар тугалга агуулсан 79 метр гүнд байх 1.1 г/т алттай 20 метр интервал (TND-113), 91 метр гүнд байх 1.0 г/т алттай 17 метр хүртлэх интервалууд багтаж байна.

Өмнө нь хийгдсэн өрөмдлөгийн ажлын үр дүнд Нээлтийн бүсийн хойд тэлэлт дээрх хүдэржилт газрын гүндээ хойд зүг рүү унаж байгаа гэж тодорхойлогдсон бол шинэ хайгуулын цооногуудын үр дүнд энэ хүдэржилт зүүн хойд зүг рүү салаалж байгааг илрүүллээ. TND-111, TND-112, TND-116 болон TND-117 цооногууд алт-полиметаллын хүдэржилт огтолсон нь Нээлтийн бүсийн суналыг 150 метрээр нэмэгдүүлж, үүнээс TND-111-р цооног нь 1 метрийн 7.6 г/т Au, 37 г/т Ag, 3.3% Pb and 8.8% хүртэлх Zn агуулга ба

Баирмаа



2018 03 12 J



TND-117 цооног нь 1 метрийн 0.6 г/т Au, 126 г/т Ag, 0.3% Cu, 3.6% Pb мөн 3.1% хүртэлх Zn агуулгыг тус тус огтолсон. Эдгээр өндөр агуулга бүхий судлууд нь цагаан мика хувиралтай өргөн бүсэд агуулагдах бөгөөд энэ бүс нь TND-111-р цооногт 0.41 г/т алтны эквивалент (0.2 г/т Au, 3 г/т Ag, 0.36% Pb-Zn) бүхий 145 метр зузаантайгаар, TND-116-р цооногт 0.53 г/т AuEq (0.4 г/т Au, 2 г/т Ag, 0.2% Pb-Zn) бүхий 145 метр зузаантайгаар илэрсэн. Эдгээр нь бүгд газрын гадаргуугаас 132 метрээс илүүгүй босоо гүнд огтлогдсон.

TND-129 буюу ганц цооногийг 450 метрийн гүнтэйгээр (босоо гүн: 390 м) Нээлтийн бүсийн гүнд өрөмдсөн. Энэ цооног нь хэд хэдэн хүдэржсэн бүсийг дайрсан ба 382 метр гүнд (босоо гүн: 331 м) 1 метрийн 2.7 г/т алт, 49 г/т мөнгө, 6.5% хар тугалга болон 2.2% хүртэлх цайртай интервал огтолсон. Өмнө нь Нээлтийн бүсэд өрөмдсөн TND-31 цооногийг 2016 оны сүүлээр 190 м-ээс 450 метр хүртэл сунгасан. Ингэснээр өмнө нь өрөмдөхөд илэрч байсан үнэт болон полиметаллын өндөр агуулга бүхий хүдэржилт илүү гүнд хүртэл үргэлжилж байгааг илрүүлэв. TND-31 нь 18.3 г/т AuEq бүхий 1 метрийг 370 метр (босоо гүн: 320) гүнд, 6.9 г/т AuEq бүхий 1 метрийг 401 метр (босоо гүн: 347 м) гүнд тус тус огтолсон.

Хүснэгт 1-13 Алтан Нар төсөл – 2017 оны өрөмдлөгийн ажлын онцлох хэсгүүд

Өрмийн цооног	Хэдээс (м)	Хүртэл (м)	Интервал (м) ⁽¹⁾	Алт (гр/т)	Мөнгө (гр/т)	Хар тугалга (%)	Цайр (%)	Алтны дүйцэх нэгж (гр/т) ⁽²⁾
TND-103	139	169	30	0.25	3.2	0.26	0.49	0.68
TND-104	126	163	37	2.22	29.7	0.31	0.45	3.05
үүнд	126	142	16	3.65	50.5	0.63	0.77	5.13
үүнд	137	140	3	10.1	155	1.32	2.12	14.2
TND-105	100	114	14	7.92	43.7	0.67	1.16	9.52
үүнд	107	113	6	14.88	65.3	0.68	0.94	16.7
үүнд	111	112	1	40.0	87	1.72	1.87	43.2
TND-106	132	151	19	1.01	11.9	0.21	0.42	1.51
TND-108	120	145	25	1.29	16.6	0.51	0.76	2.20
incl	135	138	3	5.81	55.0	1.63	1.69	8.34
TND-109	162	170	8	2.71	10.6	0.11	0.32	3.09
TND-110	62	63	1	0.16	16	6.18	3.80	5.54
ба	97	117	20	10.3	37.5	0.79	0.93	11.8
үүнд	106	111	5	29.7	44.6	0.86	1.85	31.8
үүнд	106	107	1	101.0	84	2.01	3.26	105.0

(1) Тайланд дурьдсан интервалууд нь бодит зузаан биш болно. Одоогийн байдлаар хүдрийн биетүүдийн огторгуй дахь чиглэлийг тооцоолох хангалттай мэдээлэл байхгүй байна.

(2) Алтны дүйцэх нэгжийг алт, мөнгө, хар тугалга-цайрын холимог агуулгуудыг дан ганц алтны агуулга хэлбэрээр дүрслэн илэрхийлэх зорилготой ашигласан болно. Үүнд уурхайн үйл ажиллагааны явцад ухрах боломжтой металл алдалтыг тооцоогүй. Тооцооллыг ам. доллараар хийсэн ба ханшийг - алт \$1200/унц, мөнгө \$18/унц, хар тугалга ба цайр \$0.90/фунт гэж тооцсон.

2018-03-12


Багшаа



0000 74 01
 СХ
 БҮРТГЭВ
 2018-03-19

2017 оны 4-р улиралд Алтан Нар төсөл дээр Компани нийт 450 тууш метр урттай 3 цооног ерөмдсөн. Цооногууд нь Нээлтийн бүсийн алт-полиметаллын орд болон Нээлтийн бүсээс хойш 800 метр зайд орших Магги бүсүүдийн хүдэржилтийн чиглэл дагуух хүдэржилтийн үргэлжлэлийг шалгах аар тавигдсан. Нээлтийн бүс дээр ерөмдсөн цооног нь хойш болон зүүн хойш чиглэсэн Нээлтийн бүсийн нэмэлт, дагуул хүдэржсэн структур болон зүүн хойш чиглэлтэй ижил төстэй бүсүүдийг илрүүлэхээр төлөвлөгдсөн. Эдгээр цооногууд нь Нээлтийн бүс дэх ордын төв хэсгээс ойролцоогоор 75 метр болон 250 метр зайд байх бөгөөд харьцангуй бага алтны аномаль утгатай буюу Цооног TND-131 нь 3.6 г/т хүртэл алттай 1 метрийг 73 метр гүнд огтолсон.

Зураг 1-7 Нээлтийн бүсийн план зураг ба нөөц тэлэлтийн боломжууд




2018-03-19

Бүснээ

УЛААНБААТАР ХОТ
 МХБ-ийн гишүүн
 Алдаррагч
 Бүсний дилчдийн
 "БҮГДЭС" 54
 1115205447

Зураг 1-8 Нээлтийн бүсийн дагуу зүсэлт (баруун хойш харж байгаагаар)



Өрөмдлөгийн ажлын дүгнэлт – Хойд Холбоо

Нээлтийн бүсээс гадна Алтан Нар дахь анхдагч нээлтүүдийн нэг нь Нээлтийн бүсээс хойш 1.3 км зайд орших Хойд Холбоо (ХХ) юм. Хойд Холбоод 8 суваг малтаж, хоорондох зай нь 50-200 метр байх 20 цооногуудаар зүүн хойш – баруун урагш чиглэлтэй хүчтэй хувирсан хүдэржсэн өргөн параллель бүсүүд агуулсан структурт байх структурын тэлэлтийн бүстэй холбоотой хүдэржилт байгааг илрүүлсэн. Өмнөх өрөмдлөгийн ажлаар (2012) Хойд Холбоод өрөмдсөн ганц цооногт (TND-46) 9 метрийн 5.4 г/т AuEq (4.4 г/т алт, 11.6 г/т мөнгө болон 1.7% хар тугалга цайр) агуулсан 1.3 г/т алттай 47 метр интервал огтлогдсон. 2015 оны 3-р улиралд цооног хооронд өрөмдсөн нэмэлт өрөмдлөгийн ажлаар нөөцийн төв хэсэгт газрын гадаргад ойрхон хэд хэдэн өндөр агуулга бүхий хүдэржилт илрүүлсэн. Үүнд TND-82-р цооногт илэрсэн (газрын гадаргаас 38 метр гүнд) 5 метрийн 10.9 г/т AuEq (7.2 г/т Au, 29.8 г/т Ag, 2.64% Pb, 3.62% Zn) агуулсан 5.3 г/т AuEq (3.6 г/т Au, 14.4 г/т Ag, 1.15% Pb, 1.76% Zn) бүхий 12 метр багтаж байна. 2015 оны 3-р улиралд хийсэн суваг малталтын ажил нь ордын хүдэржсэн бүсийг тодорхой хэмжээгээр тэлж өгсөн. Суваг ANT-41 нь Хойд Холбоон одоогийн нөөцийн хилээс зүүн зүгт ойролцоогоор 200 метр зайд байх ба 4.1 г/т AuEq (3.5 г/т Au, 5.0 г/т Ag, 0.70% Pb, 3.26% Zn) бүхий 8 метр агуулсан 2.5 г/т AuEq (1.9 г/т Au, 4.3 г/т Ag, 0.78% Pb, 0.35% Zn) бүхий 28.5 метр интервалыг огтолсон.

2018-03-12

Бөгөөд

УЛААНБААТАР ХОТ
 МХБ-ийн гинлүүн
 Андеррайтер
 Бүлэг, дүрсний
 БИЧГЭГ 55
 111520447 д.а 2012.02



2016 оны 4-р улирал – Хойд Холбоон өрөмдлөгийн ажлын хураангуй

2016 оны 4-р улирлын сүүлчийн өрөмдлөгийн ажил нь Хойд Холбоон хүдэржилтийн системийн боломжит хэмжээг тодорхой хэмжээгээр тэлж өгсөн. Талбай тэлэлтийн TND-97 цооног нь Компанийн 2015 оны 1-р улиралд тооцоологдсон ашигт малтмалын нөөцийн хилээс зүүн зүгт 155 метр зайд байх ба 34 метр гүнд 1.57 г/т AuEq (1.08 г/т Au, 5 г/т Ag and 0.81% Pb-Zn) бүхий 22 метрийг огтолсон. Энэ цооног нь өмнө нь 2.5 г/т AuEq (1.88 г/т Au, 4.3 г/т Ag and 1.13% нэгдсэл Pb-Zn) бүхий 28.5 метр илэрч байсан ANT-41 сувгийн доогуур өрөмдөгдсөн. Хойд Холбоон суналын нийт урт нь одоогоор 600 метр байгаа бөгөөд зүүн хойд, зүүн, өмнө зүгт болон гүндээ нээлттэй байгаа.

2017 оны 3-р улирал – Хойд Холбоон өрөмдлөгийн ажил

400 метр зайд талбайн зүүн тэлэлт дагуу 3 цооног (TND-119 – TND-121) өрөмдсөн ба 1 шинэ цооног (TND-122)-ийг Хойд Холбоо бүсээс зүүн урд зүгт 200 метр зайд тавьсан нь өндөр агуулга бүхий полиметаллын судлуудыг огтолсон (доор байх хүснэгтийг харна уу). Эдгээр зүүн тэлэлтийн цооногууд нь Хойд Холбоон хүдэржилтийн бүсийг зүүн зүгт ихээр тэлсэн ба хүдэржилт нь зүүн зүгт нээлттэй гэдгийг харуулж өгсөн.

Хүснэгт 1-14 Хойд Холбоон өрөмдлөгийн ажлын онцлох үр дүнгүүд

Өрмийн цооног	Хэдээс (м)	Хүртэл (м)	Интервал (м) ⁽¹⁾	Алт (гр/т)	Мөнгө (гр/т)	Хар тугалга (%)	Цайр (%)	Алтны дүйцэх нэгж (гр/т) ⁽²⁾
TND-119	38.4	42	3.6	0.06	5.3	0.44	0.78	0.76
TND-120	36.9	42	5.1	1.08	29.4	1.05	2.25	3.22
үүнд	39	40	1	2.43	55	1.70	3.10	5.72
TND-121	89.5	104	14.5	0.93	6.8	0.47	0.42	1.49
TND-122	105	132	27	0.14	3.0	0.19	0.53	0.56
үүнд	128	129	1	1.36	23.0	2.60	6.98	6.63

- (1) Тайланд дурьдсан интервалууд нь жинхэнэ зузаан биш болно. Одоогийн байдлаар хүдрийн биетүүдийн огторгуй дахь чиглэлийг тооцоолох хангалттай мэдээлэл байхгүй байгаа.
- (2) Алтны дүйцэх нэгжийг алт, мөнгө, хар тугалга-цайрын холимог агуулгуудыг дан ганц алтны агуулга хэлбэрээр дүрслэн илэрхийлэх зорилготой ашигласан болно. Үүнд уурхайн үйл ажиллагааны явцад учрах боломжтой металл алдалтыг тооцоогүй. Тооцооллыг ам. доллараар хийсэн ба ханшийг - алт \$1200/унц, мөнгө \$18/унц, хар тугалга ба цайр \$0.90/фунт гэж тооцсон


Өрөмдлөгийн ажлын хураангуй – Бүс нутгийн хайгуулын боломжит талбай

Нарийвчилсан гадаргуун зураглал, чулуун дээж болон хөрсний геохимийн шинжилгээг геофизикийн цахилгаан болон соронзон хайгуултай хослуулснаар 18 боломжит талбайг Алтан Нарын 5.6 км урт хүдрийн бүсэд илрүүлсэн. Нээлтийн бүс болон Хойд Холбоогоос

Баариал



2018-03-12



хүртэлх зэс)-д өндөр байгаа нь "Алтан Нар"-ын энэ хэсэг нь хүдэржилтийн өндөр температурын хэсэг байх боломжтойг харуулж байна. Энэ шинэ бүс нь компанийн ирээдүйд хийх өрөмдлөгийн ажлын зорилтуудын нэг юм.

2015 оны нөөцийн тайлан – Нээлтийн бүс болон Хойд Холбоо орд

2015 оны 1-р улирлын бие даасан NI 43-101 тайлан нь 3-р сарын 24-ний өдөр "Алтан Нар алтны төсөл, Баянхонгор аймаг, NI 43-101 Ашигт малтмалын нөөцийн тайлан" гэх нэрээр гаргасан ба үүнийг www.sedar.com (SEDAR) дах Компанийн мэдээллээс авч танилцах боломжтой.

Доор байх хүснэгт нь Нээлтийн бүс болон Хойд Холбоо талбайн ашигт малтмалын бодит болон таамаг нөөцийг 2015 оны 2-р сарын 19-ний байдлаар харуулсан. Ашигт малтмалын нөөцийг РангеПинкокМинарко ("RPM") нь NI 43-101-д заасан Канадын Уул Уурхайн Хүрээлэнгийн стандартуудын дагуу хийж гүйцэтгэсэн. Ашигт малтмалын нөөц нь алтны тэнцэх нэгж (AuEq) буюу хэд хэдэн захын агуулгын утгатайгаар хийгдсэн боловч RPM нь ашигт малтмалын нөөцийг алтны захын агуулга 1.0 г/т AuEq байхаар тайлагнахыг зөвлөсөн. 0.6 г/т AuEq болон 1.4 г/т AuEq захын агуулгууд нь зөвхөн харуулах зорилгоор энд орсон болно.

Хүснэгт 1-15 Алтан Нар төсөл – Ашигт малтмалын нөөцийн тооцоо /2015 оны 02-р сарын 19-ний байдлаар/

Алтны дүйцэх нэгж	Ангилал	Тонн	Алт	Мөнгө	Цайр	Хар тугалга	Алтны дүйцэх нэгж	Алт	Мөнгө	Цайр	Хар тугалга	Алтны дүйцэх нэгж
Захын агууламж фунт/тн		сая тн	гр/т	гр/т	%	%	гр/т	мянга н унц	мянга н унц	Сая фунт	Сая фунт	мянга н унц
0.6	Бодит нөөц	3.4	1	9.4	0.57	0.47	1.7	112	1,014	42.4	34.8	185
0.6	Таамаг нөөц	3	0.8	9.4	0.51	0.35	1.4	83	913	33.9	23.5	139
1.0	Бодит нөөц	1.8	1.7	11.1	0.61	0.54	2.5	102	657	24.7	22.1	147
1.0	Таамаг нөөц	1.5	1.5	10.4	0.54	0.39	2.1	72	498	17.7	12.8	102
1.4	Бодит нөөц	1.3	2.3	12.1	0.61	0.58	3.1	92	486	16.8	15.9	124
1.4	Таамаг нөөц	1	2	10.8	0.53	0.4	2.6	63	342	11.5	8.6	83

Тэмдэглэл:

1. Ашигт малтмалын нөөцийн тооцооны тодотгол нь Австралийн Газарзүйн Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн гишүүн, RPM-ын бүтэн цагийн ажилтан ноён Жерми Кларкийн удирлага доор хийгдсэн. Ноён Кларк нь энэ төрлийн хүдэржилт болон ордын хангалттай туршлагатай ба Канадын уул уурхайн хүрээлэнгийн стандартад заасан мэргэшсэн мэргэжилтний шаардлагыг хангасан.
2. Дээр байгаа нөөцийн тооцоо нь 2015 оны 02-р сарын 19-ний тайланд орсон тооцоогоор байгаа ба ашигт малтмалын нөөцийн тооцоо нь нарийн тооцоолол биш бөгөөд талбайн хязгаарлагдмал мэдээлэл дээр үндэслэн хийгдсэн тайлал, хэлбэр болон илэрлийн үргэлжлэл мөн түүнчлэн өрмийн дээжийн үр дүнгүүдийн бэлэн байдлаас хамаардаг. Дээрх хүснэгтэнд байх нийлбэр дүн нь харьцангуй тодорхой бүс тооцоог тоймлон харуулсан болно.

Басриев



2018 03 12



3. Ашигт малтмалын нөөцийн зэргүүдийг Канадын уул уурхайн хүрээлэнгийн стандартын дагуу тайлагнав.
4. Ашигт малтмалын нөөцийг хуурай, газар дээрх төлөвт нь үндэслэн тайлагнав.
5. Нийлбэрүүд нь тоймлосноос үүдэн багахан өөрчлөгдсөн байж болно.

Компани нь ашигт малтмалын нөөцийн тайланг дэмжих зорилгоор AuEq утгаар тайлагнахыг RPM-с хүссэн. Алтны дүйцэх нэгжийг алт, мөнгө, хар тугалга-цайрын холимог агуулгуудыг дан ганц алтны агуулга хэлбэрээр дүрслэн илэрхийлэх зорилготой ашигласан болно. Үүнд уурхайн үйл ажиллагааны явцад учрах боломжтой металл алдалтыг тооцоогүй. Тооцооллыг ам. доллараар хийсэн ба ханшийг - алт \$1200/унц, мөнгө \$18/унц, хар тугалга ба цайр \$0.90/фунт гэж тооцсон.

RPM нь ашигт малтмалын нөөцийг тооцоолохдоо энгийн кригинг болон кв зэргийн урвуу зайн хамаарлын интерполяцын аргуудыг хэрэглэсэн болно. Нөөцийн тайланд захын агуулгыг ашигласан ба энэ захын агуулгын утгыг ийм төрлийн хүдэржилт болон нөөцийн өнөөгийн төлөвт тохиромжтой гэж үзсэн болно. Энэ загварт уурхай төлөвлөлтийн ач холбогдол бүхий газар дээрх болон хил заагийн хорогдлыг тооцоолсон боловч уурхайн олборлолтын хорогдлыг тооцоолоогүй. Загварчлалын блокийн хэмжээ (25 x 5 x 5 м, 3.25 x 1.25 x 1.25 метрээр суб-блокчлогдсон) нь тооцоолж байгаа бага хэмжээний уурхайнуудтай төстэй буюу ил уурхайд тохиромжтой, энэ төрлийн ордод өргөн ашиглагддаг хэмжээ юм.


Нөөцийг өсгөх боломж


2016 оны 3-4-р улирал болон 2017 оны 2-4-р улиралд Компани нь өрөмдлөг болон суваг малталтын ажлуудыг Нээлтийн бүс-Хойд Холбоон ашигт малтмалын нөөцийн талбайд хийж гүйцэтгэсэн ба эрлийн өрөмдлөгийг одоогийн нөөцийг нэмэгдүүлэх боломжийг өсгөхөөр хийсэн. Энэ Нээлтийн бүс-Хойд Холбоон ажил нь Компанийн бага гүний хүдэржилттэй бүсүүдийн үнэмшилт магадлалыг ихэсгэх зорилтыг биелүүлсэн ба хүдэржилттэй олон биетийг огтолсон. Ингэснээр Нээлтийн бүс болон Хойд Холбоог тэлж өгсөн. Эрлийн өрөмдлөг нь Компанийн Нээлтийн бүс-Хойд Холбоон нөөцийн хилийн гаднах Алтан Нарын мэдэгдэж буй алт-полиметаллын хүдэржилтийг тодорхой хэмжээгээр нэмэгдүүлэх талбайнуудын үнэмшилт магадлалыг ихэсгэсэн.

Металлургийн сорьцлолт

Компани нь 2015 оны 3-р улирлын турш Нээлтийн бүс болон Хойд Холбоо ордуудын өрмийн дээжүүдэд металлургийн судалгааг хийсэн бөгөөд судалгааны ажлыг Бритиш Колумбын Парксвиллийн Блү Көөст Ресерч ХХК ("BCR", "Blue Coast Research") хийж гүйцэтгэсэн ба Алтан Нарын металлургийн анхан шатны үнэлгээг хийхээр төлөвлөсөн.

Балрине





Үүнд цианидад уусгах, хөвүүлэх, хүндийн хүчний болон хүнд уусмалаар салгах аргууд багтсан.

Нээлтийн бүсийн дээжинд хийсэн металлургийн судалгаагаар шууд цианидад уусгах аргын алтны гарц 88% (80% нь 75 микрон хүртэл нунтаглагдсан) байсан ба бутлуулаар чөлөөлөгдөх алттай ба сөрөг нөлөө бүхий найрлагагүй болохыг тогтоосон. Судалгаа нь стандарт 48 цагийн лонх эргүүлэх аргаар 40% хатуу, 1.0 г/л NaCN-н найрлагатай цианидын уусмалд хийгдсэн ба хүчил шүлтийн хэмжээ (pH) нь 10.5-11 хооронд тохируулагдсан. Мөн ууссан хүчилтөрөгчийн хэмжээ нь 5 мг/л-с их байхаар тохируулагдсан. Цианид (0.96 кг/т) болон шохой (1.51 кг/т) аль алины хэрэглээ дунд зэрэг байсан ба харьцангуй бага урвалын зардалтайг харуулж байна.

Хөвүүлэх аргын үр дүн нь алт-хар тугалга-мөнгөний баяжмалыг (229 г/т алт, 62% хар тугалга болон 1029 г/т мөнгө) уламжлалт хар тугалга – цайрыг ялган хөвүүлэх аргыг ашиглан боломжийн металлын гарцтайгаар (алт 75%, хар тугалга 74% болон мөнгө 64%) боловсруулж болохыг харуулсан.

Цианидад уусгах болон илүү боловсронгуйгаар хөвүүлэх аргуудыг Хойд Холбоон нэг нэг дээжинд буюу Нээлтийн бүсийн судалгаатай төстэй нөхцөлд хийн гүйцэтгэсэн. Цианадад уусгах аргын алтны гарц 68% байсан. Харин хөвүүлэх аргад Хойд Холбоон дээжин дэх алт нь сульфидын баяжмалд 24% алтны гарцтай ба хар тугалгын баяжмалд 45% алтны гарцтай байсан. Хойд Холбоон дээжинд оновчтой болгох ажил хийгдээгүй.

BCR нь урьдчилсан техник эдийн засгийн үндэслэл (“ТЭЗҮ”), техник эдийн засгийн үндэслэл хүртэлх концепт судалгааны бүдүүвчийг хөгжүүлдэг бөгөөд гарааны бизнес болон боловсруулах үйлдвэрийн оновчлолын зөвлөгөө өгдөг. Тэдний металлурагчид нь полиметалл болон үнэт металлын баяжмалын дэлхийн хэмжээний өргөн туршлагатай.

Дүгнэлт болон зөвлөмжүүд

2015 оны 1-р улирлаас хойш хийгдсэн өрөмдлөгийн ажлууд нь Компанийн Нээлтийн бүс болон Хойд Холбоо ордуудын одоогийн нөөцийг ихэсгэх үнэмшилт магадлалыг нэмсэн ба Нээлтийн бүс-Хойд Холбоон нөөцийн хилийн гаднах мэдэгдэж буй алт-полиметаллын хүдэржилтийн талбайг тэлсэн.

2017 онд хийгдсэн өрөмдлөгийн ажлууд нь томоохон тогтоцын тэлэлтийн бүсэд байрлах Нээлтийн бүсийн төв хэсгийн өндөр агуулга бүхий шинэ бүсийн судлыг цааш үргэлжлүүлэх, эсвэл металлээр баяжсан өргөн бүс байх боломж бүхий шилжилт болон гол структуруудын огтлолцол дээр байрласан болохыг баталгаажуулахаар төвлөрч

Басриае



2018.03.12



ажилласан. 2017 онд Алтан Нард хийгдсэн өндөр нарийвчлалтай соронзон хайгуулын үр дүн нь Нээлтийн бүсэд ажиглагддаг хөндлөн зүссэн структуртай ижил төстэй структурыг 5.6 км урт хүдэржсэн корридорд бусад 17 талбайд илрүүлэхэд ашиглагдаж байна. Алтан Нард 2017 оны 3-р улиралд структурын судалгааны ажил хийсэн ба түүний үр дүнг хайгуулын өрөмдлөгийн хэтийн төлөвлөлтөнд ашиглана.

Төсөл хөгжүүлэлтийн төлөвлөгөө

Алтан Нар төслийн хүдэржилт нь одоогоор тогтоогдсон ашигт малтмалын нөөцийн хойд болон өмнөд хэсэгт нээлттэй байгаа ба нөөцийн тооцоололд оруулаагүй дунд болон өндөр агуулга бүхий өрөмдлөгийн мэдээлэлд тулгуурлан 2018 онд нөөцийн тооцооллыг шинэчлэх ажил хийгдэнэ. Бие даасан дүгнэлтээр тогтоогдсон 2 ордоос гадна ирээдүйд хайгуул болон техникийн судалгаа дээр тулгуурлан нөөц тогтоох боломжтой томоохон хэмжээний талбайг нээсэн.

Мөн төслийг Баян Хөндийтэй хамт хөгжүүлэх ажил судлагдах бөгөөд ойролцоо байрлалтай олон ордыг хөгжүүлэх нь төслийн эдийн засгийн үр ашгийг сайжруулна гэж таамаглаж байна.

• Улаан зэс-алтны порфирийн төсөл

Компани 2017 оны 3 дугаар улиралд Монгол Улсын хувийн хэвшлийн компаниас Улаан тусгай зөвшөөрлийн 51%-г худалдан авч, цаашид 100% эзэмших нөхцөлтэйгөөр эзэмших болсноо зарласан. Улаан талбай нь Баян Хөндийн хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайтай залгаа буюу баруун талд нь байрлах 1,780 га хайгуулын талбай юм.

Компани 2017 оны 3 дугаар улиралд Монгол Улсын хувийн хэвшлийн компаниас Улаан тусгай зөвшөөрлийн 51%-г худалдан авч, цаашид 100% эзэмших нөхцөлтэйгөөр эзэмших болсноо зарласан. Улаан талбай нь Баян Хөндийн хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайтай залгаа буюу яг баруун талд нь байрлах 1,780 га хайгуулын талбай юм.


Улаан талбайд том хэмжээтэй буюу 3 км-ийн диаметр бүхий зэсийн порфир болон эпитеpmаль алтны системтэй холбоотой байж болохуйц хүчтэй хувирсан бүс оршдог.

Улаан талбайд урьд нь өрөмдлөг эсвэл суваг малталтын ажил хийж байгаагүй. Талбайг худалдаж авахын өмнө гадаргуун чулуун дээжлэлт болон урсгал сарнилын хүрээний дээжлэлт хийн, алт, зэс болон молибденийн хэд хэдэн бөөгнөрөл бүхий гажил байгааг тогтоосон.



Багш

2018 03 12 J



2011 оны 2-р улиралд Компани NI 43-101 кодын дагуу Зуун Модын нөөцийг тооцоолон олон нийтэд ил болгосон. Захын агуулгыг 0.04% молибден гэж тооцон, дунджаар 0.057% молибден болон 0.069% зэсийн агуулгатай 218 сая тоннын ("Мтн") тогтоогдсон болон бодит нөөцтэй гэж тооцоолсон (0.056% молибден болон 0.064% зэсийн агуулгатай 40 Мтн тогтоогдсон нөөц болон 0.057% молибден болон 0.07% зэсийн агуулгатай 178 Мтн бодит нөөц). Энэ нь металл молибден агуулсан 273.5 сая фунт болон металл зэс агуулсан 330.7 сая фунттэй тэнцэнэ. Үүнээс гадна Зуун Модод дунджаар 0.052% молибден болон 0.065% зэсийн агуулгатай 168 сая тн таамаг нөөц байгаа ба энэ нь металл молибден агуулсан 191.8 сая фунт болон металл зэс агуулсан 240.5 сая фунттэй тэнцэнэ. Тайланд орсон Зуун Модын бүх молибден-зэсийн нөөц нь ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд багтана.

Хүснэгт 1-16 Зуун Мод төсөл дэх хүдэржилт

Захын агуулга Mo%	Нөөцийн ангилал	Нөөцийн сая тн	Mo%	Mo агуулсан Металл сая фунт	Cu%	Cu агуулсан Металл сая фунт
0.03%	Тогтоогдсон	55	0.050	61.1	0.060	73
	Бодит	260	0.050	287	0.065	373.6
	Тогтоогдсон болон бодит	315	0.050	348.1	0.064	446.6
	Таамаг	335	0.043	318.8	0.061	454.6
0.04%	Тогтоогдсон	40	0.056	49.5	0.064	57
	Бодит	178	0.057	224	0.070	273.7
	Тогтоогдсон болон бодит	218	0.057	273.5	0.069	330.7
	Таамаг	168	0.052	191.8	0.065	240.5
0.05%	Тогтоогдсон	25	0.063	34.5	0.068	37.5
	Бодит	105	0.066	152.5	0.074	171
	Тогтоогдсон болон бодит	130	0.065	187	0.073	208.5
	Таамаг	78	0.060	103.4	0.067	115.5

Tn=2204.64 фунт

Молибденийн үнэ өсөх үед Зуун Модын молибден-зэсийн төслийг хөгжүүлэх боломж бүрдэнэ гэж Удирдлагын зүгээс итгэж байна. 2004 болон 2005 онуудад фунт тутам \$40 ам. доллар хүрч байсан молибденийн ислийн үнэ 2017 оны 11-р сарын 1-нд байдлаар фунт тутам нь 7.26\$ болон огцом унаж, зах зээл дээрх молибденийн эрэлт буурсан. Молибденийн зах зээлийн өсөлт нь Зуун Модын молибден-зэсийн ордыг хөдөлгөх чухал хүчин зүйл болно. Компани нь технологи болон/эсвэл хайгуултай холбоотой нэмэлт мэдээлэл гармагц төслийн эдийн засгийн оновчлолын үнэлгээг үргэлжлүүлэн хийнэ. Хөвийн Хар-д зэсийн тодорхой хэмжээний нэмэлт хүдэржилт илрүүлснээр Зуун Мод молибденийн ордыг хөдөлгөх хөшүүрэг болох боломжтой.

Балдус



2018.03.12



- **Хөвийн Хар зэсийн төсөл**

Хөвийн хар зэс-мөнгөний төсөл нь Зуун Модын талбайд байх ба Зуун Мод молибден-зэсийн порфирийн ордоос (дээр дурдсан) баруун хойд зүгт 2.2 км байрладаг. Хөвийн хард геологийн зураглал, судлын нягтаршлын зураглал, геохимийн дээжлэлт, геофизикийн судалгаа болон хоорондох зай нь хол байх өрөмдлөгийн ажлуудыг хийсэн. Өмнө нь хийсэн геофизикийн гажилтай цэг шалгах өрөмдлөгийн ажлаар 308-342 метр гүнд 34 метрийн 1.3% зэс болон 9.24 г/т мөнгөтэй интервал огтолсон (цооног ZMD-121). Хөвийн Хард хийсэн нэмэлт өрөмдлөгийн ажлаар том хэмжээний буюу 900 метр үргэлжлэх, зэсийн хэд хэдэн хүдэржсэн бүс байгааг илрүүлсэн. Өрөмдсөн гурван цооногт 0.2%-иас илүү зэсийн агуулгатай тодорхой интервалууд (12-42 метр) огтлогдсон.

Хайгуулын ажлын үр дүн нь зэс порфирийн төрлийн хүдэржилт Хөвийн хар талбайд байгааг баталгаажуулна.

Компани нь шаардлагатай ажлыг Зуун Мод молибден-зэсийн орд болон Хөвийн Хар зэс-мөнгөний төслүүдэд хийж гүйцэтгэх ба үүнд жил бүр төлөгддөг тусгай зөвшөөрлийн төлбөр, байгаль орчны дүгнэлт болон орон нутгийн хөгжлийн ажлууд багтаж байна.

Зуун Мод болон Хөвийн Хар төслүүд нь одоогоор Компанийн эн тэргүүний зорилтууд биш юм.

1.5.5. Байгууллагын нийгмийн хариуцлага

Компани нь эрдэс баялгийн эрэл хайгуул, олборлолтын үйл ажиллагаа эрхэлж буй орон нутагтаа урт хугацааны, тогтвортой, эерэг хувь нэмэр оруулахыг зорин ажилладаг. Байнгын хамтын ажиллагаа, олон нийтэд хөрөнгө оруулах болон одоогийн нөхцөл байдалд үнэлгээ хийх замаар Компани нь орон нутгийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагыг хангах ажлыг өөрийн бизнесийн үндсэн үйл ажиллагааны нэгэн хэсэг болгон уялдуулан ажилладаг.

- *Зорилго:*

Компани нь орон нутгийн эдийн засгийн хөгжилд эерэг хувь нэмэр оруулах чиглэлээр хувьцаа эзэмшигчидтэй хамтран ажиллахыг эрмэлздэг. Энэхүү зорилтын хүрээнд:

- Хувьцаа эзэмшигчид, байгаль орчин, орон нутгийн иргэдэд үнэ цэнийг бий болгох,
- Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчны (HSEC) эрсдлийг тодорхойлох,
- Нөөцийг хариуцлагатай ашиглах замаар байгаль орчноо эрхэмлэх,
- Хувьцаа эзэмшигчдэд үйл ажиллагаа нь нээлттэй, ил тод байх,
- Холбогдох хууль тогтоомж, дүрэм журам болон тогтсон хэм хэмжээг мөрдөн сахих,
- Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчны (HSEC) ажилд салбарын дэвшилтэт технологи ба туршлагыг нэвтрүүлнэ.

Бернесс



2018-03-12



- *Эрүүл ахуй, аюулгүй ажиллагаа:*

Компанийн хайгуулын талбай нь мэргэжлийн аюулгүй байдлыг дээд зэргээр хангаж, эрүүл орчныг дэмжих бодлогын дагуу ажилладаг. Компанийн бодлого, хууль зүйн шаардлагад нийцэж буй эсэхэд хяналт тавих үүднээс хайгуулын талбайд хяналт шалгалт тогтмол хийдэг. Хүн, байгаль орчинтой холбоотой ямар нэгэн эрсдэл илэрсэн тохиолдолд Компанийн зүгээс хяналт шалгалтыг нэн даруй хийж, холбогдох арга хэмжээг цаг алдалгүй авдаг. Компани нь эрүүл ахуй, аюулгүй ажиллагааг байнга хянаж, сайжруулах зорилгоор сургалт зохион байгуулж, ажилчдын мэргэшлийг дээшлүүлсээр ирсэн. Компанийн ажлын талбайд архи, согтууруулах ундаа, хууль бус эм, мансууруулах бодисын хэрэглээг хориглодог.

- *Байгаль орчин:*

Компани нь эрдэс баялгийн төслүүдийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулж, хохирлыг арилгах чиглэлд хувьцаа эзэмшигчид болон холбогдох этгээдүүдтэй хамтран ажилладаг. Тухайн эрдэс баялгийн төслийн хэрэгжилтийн туршид шинэчлэгдэн өөрчлөгдөх суурь судалгаа, нөлөөллийн үнэлгээг хийх зэргээр урьдчилан сэргийлэх болон засч залруулах арга хэмжээг авч хэрэгжүүлдэг. Энэ нь компанийн зүгээс хайгуулын үйл ажиллагааны байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг удирдан ажиллахыг чухалчилдаг оршино.

Компани газар хөндөх (суваг шуудуу татах, усны өрөмдлөг хийх, уурхайн бүтээн байгуулалт хийх, хүдэр олборлох) зэрэг геологи хайгуулын ажил дууссаны дараа тухайн талбайг нөхөн сэргээх үүднээс хөрс сайжруулалтын ажлыг хийх бодлогын дагуу үйл ажиллагааг эрхэлдэг. Аливаа төслийн хэрэгжилтийн хугацаанд хөрс сайжруулалтыг тухай бүрт хийсээр ирсэн.

- *Иргэдтэй хамтран ажиллах:*

Компанийн орон нутагтай харилцах харилцаа нь:

- Нэгдсэн зорилготой байх,
- Харилцан хариуцлагатай байх,
- Үнэнч шударга байдал, итгэлцэл, нээлттэй байдал,
- Хамтын ажиллагаа ба оролцоо,
- Ил тод, санхүүгийн хариуцлагатай байх зарчмуудад тулгуурлана.

Компани нь анхан шатны бүсчилсэн судалгаа, суурь үнэлгээ, болзошгүй нөлөөллийн үнэлгээ хийх замаар орон нутгийн нийгэм, эдийн засгийн хэрэгцээ, шаардлагыг эрх ашиг нь хөндөгдөж буй талуудтай хамтран тодорхойлдог. Тухайн эрдэс баялгийн төслийн хэрэгжилтийн хугацаанд байгаль орчны нөлөөллийн судалгаа, нийгэм, эдийн засгийн судалгааг тухай бүрт шинэчлэн боловсруулдаг.

Баарина



2018-03-12



Компани нь эрдэс баялгийн төсөл бүрт хуваарилагдсан нөөцийн тодорхой хэсгийг орон нутгийн хөгжлийн хөтөлбөрт зориулахыг эрмэлздэг. Эдгээр “Орон Нутгийн Хөгжлийн Хөтөлбөр”-ийн тусламжтайгаар Компани нийгмийн хариуцлагын үүргээ сайн дураар биелүүлж, үйл ажиллагаагаараа нийгэм, олон нийтэд танигдсан.

Компани нь хөрөнгө оруулах замаар орон нутгийн оролцогч талууд болон байгууллагуудын боловсрол, эрүүл мэнд, иргэдийн амжиргаа, байгаль орчныг хамгаалах чадавхийг бэхжүүлэхийг зорьдог. Компани нь эдгээр салбар тус бүрт оролцохдоо:

- Сургалтын нөөц, боломж, бололцоог нэмэгдүүлэх,
- Олон нийтийн эрүүл мэндийн санаачлагыг дэмжих
- Орон нутгийн иргэдийн амьдрах нөхцөл, аюулгүй байдлыг сайжруулах,
- Байгаль орчны аливаа сөрөг нөлөөллийг бууруулахыг зорьдог болно.

1.6. Санхүүгийн үзүүлэлтүүд

1.6.1 Санхүүгийн үзүүлэлт

Компанийн 2016 оны жилийн эцсээр дуусгавар болсон санхүүгийн тайлангийн мэдээллүүд болон түүний Монгол хэлрүү орчуулсан орчуулгыг Үнэт цаасны танилцуулгад хавсаргасан.

/Аудитаар баталгаажсан санхүүгийн тайлангийн дэлгэрэнгүйг, орчуулгын хамтаар Танилцуулгын Хавсралт 12-оос харна уу. /

1.6.2 Үйл ажиллагааны онцлог: Хөрвөх чадвар болон хөрөнгийн талаар

Үйл ажиллагааны онцлог буюу бусад хайгуулын компаниудын адилаар Компани нь хайгуулын төслүүдийг опцион, түншлэл, үнэт цаас, болон хөрөнгө борлуулалтын аргаар санхүүжүүлдэг. Энэхүү санхүүжилтийн хэмжээ ба хугацааг Компанийн хайгуулын хөтөлбөрийн үр дүн, зах зээлийн нөхцөл байдалд тулгуурлан тодорхойлдог.

Компани нь хайгуул болон төсөл хөгжүүлэлтийн үйл ажиллагааг дээр дурдсан аргаар санхүүжүүлдэг тул Компанийн ашиг орлогын түвшин, ирээдүйн мөнгөн гүйлгээ болон санхүүгийн хандлагыг тодорхойлоход бэрхшээлтэй.

1.6.3 Санхүүгийн эрсдэлүүд

Канад улсын үнэт цаасны эрх зүйн хүрээнд Компани нь санхүүгийн эрсдэлүүдэд дүн шинжилгээ хийх, олон нийтэд танилцуулах үүрэг хүлээсэн. Компанийн санхүүгийн эрсдэлүүдийг тодорхойлбол:


- Зээлийн эрсдэл:

Баерине



[Handwritten signature]

2018 03 12



Компанийн зээлийн эрсдэл нь нөлөө багатай, гол төлөв мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө болон авлагатай холбоотой үүсэх боломжтой. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө нь хөрөнгө оруулалтын баталгаажсан гэрчилгээ, банкинд байршуулсан хадгаламжаас бүрдэнэ. Удирдлагын зүгээс Компани мөнгөн хөрөнгөө алдах эрсдэл бага гэж үзэж байгаа бөгөөд Канадын нэр хүнд бүхий санхүүгийн байгууллагуудад мөнгө түүнтэй адилтгах хөрөнгөө байршуулах замаар зээлийн эрсдлийг удирдаж байна.

• *Хөрвөх чадварын эрсдэл:*

Компанийн хөрвөх чадварын эрсдэл нь өр төлбөрөө хугацаанд нь төлж барагдуулах чадвараар хязгаарлагдана. Компани нь энэхүү эрсдлийг бууруулахын тулд хөрвөх чадварыг хангалттай хэмжээнд байлгах бодлогыг баримталдаг.

• *Хүүгийн хувь хэмжээний эрсдэл*

Компани нь хүү тооцогдох өр төлбөргүй бөгөөд хүүгийн хувь хэмжээтэй холбоотой аливаа эрсдэлд өртөхгүй болно.

• *Гадаад валютын эрсдэл:*

Компанийн санхүүжилт канад доллараар хийгддэг боловч Монгол болон Канад улсад үйл ажиллагаа явуулдаг тул зарцуулалтын дийлэнх нь гадаад валютаар хийгддэг. Энэ нь Компанийн үйл ажиллагаа болон санхүүгийн байдалд материаллаг нөлөөлөл үзүүлэх боломжтой. Уг эрсдлийг бууруулах, хязгаарлах зорилгоор Компани мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгөө Канад улсын банкинд байршуулдаг. Компани гадаад валютын ханшийн хэлбэлзлийн эрсдлээс хамгаалан хязгаар тогтоох санхүүгийн хэлцлүүдийг ашигладаггүй бөгөөд зөвхөн хайгуулын хөтөлбөрийн хуваарьт тулгуурлан Компанийн төсвийн хэмжээнд нийцүүлэн ханш боломжийн байх үед гадаад валютыг урьдчилан худалдаж авдаг.

1.7. Үнэт цаасны танилцуулга бэлтгэхэд оролцсон этгээдүүд

1.7.1 Хуулийн зөвлөх компани

Компанийн нэр:	“Өмгөөллийн ИЭлСи” ХХН
Улсын бүртгэлийн дугаар:	9022001046
Регистрийн дугаар:	5765412
Үйл ажиллагааны чиглэл:	Хууль зүйн зөвлөгөө, туслалцаа, өмгөөллийн үйл ажиллагаа /6910 кодтой/
Хаяг:	Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Гэндэнгийн гудамж 16, Ардчиллын Өргөө, 6 давхар
Утас:	77118193, 77118194



Баермее



Өмгөөллийн ИЭлСи ХХН-ийн танилцуулга

Өмгөөллийн ИЭлСи ХХН нь 2000 онд байгуулагдсан, Монгол Улсад хэрэгжүүлж буй дэд бүтэц, ашигт малтмал, барилга угсралтын төслүүдэд бизнесийн бүтэц, санхүүжилт, зээл, татвар, зөвшөөрөл болон бусад асуудлаар зөвлөх үйлчилгээ үзүүлдэг мэргэшсэн 30 гаруй хуульч, өмгөөлөгчдөөс бүрдсэн хуулийн фирм юм.

Дан ганц бизнесийн зөвлөх үйлчилгээ төдийгүй хуулийн төсөл боловсруулах, гадны санхүүжүүлэгч байгууллагуудаас хэрэгжүүлдэг, нийгмийн хөгжилд чиглэсэн төслүүдэд зөвлөхөөр ажиллаж, дотоодын болон олон улсын шүүхийн болон арбитрын хэргүүдэд өмгөөллийн үйлчилгээ үзүүлдэг.

Тус нөхөрлөл нь Англид төвтэй, олон улсын хуулийн фирмийн рэйтинг тогтоодог Чамберс энд Партнерсийн 2015, 2017 оны "Монгол Улсын Тэргүүлэх хуулийн фирм", дэлхийн шилдэг 500 хуулийн фирмийг нэрлэдэг "Legal 500"-аас 2015 болон 2016 оны "Монгол Улсын Шилдэг хуулийн фирм", Монгол Хуульчдын Холбооны 2017 оны "Монголын Шилдэг Өмгөөллийн Нөхөрлөл"-өөр тус тус шалгарсан.

Тусгай зөвшөөрөл

Хүснэгт 1-17 Өмгөөллийн нөхөрлөлийн тусгай зөвшөөрөл

Өмгөөллийн нөхөрлөлийн тусгай зөвшөөрөл			
Овог, нэр	Гэрчилгээ олгосон огноо	Гэрчилгээний дугаар	Эрхлэх үйл ажиллагаа
Өмгөөллийн ИЭлСи ХХН	2006.02.15	1108	Өмгөөллийн үйл ажиллагаа
Өмгөөллийн ИЭлСи ХХН	2014.01.29	24	Зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх

/Өмгөөллийн ИЭлСи ХХН-ийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбарыг Хавсралт 8-аас үзнэ үү./

Хүснэгт 1-18 Өмгөөллийн ИЭлСи ХХН-ийн хуульчдийн гэрчилгээ

Холбогдох хуульчдын тусгай зөвшөөрөл			
Овог нэр	Шүүхэд төлөөлөх гэрчилгээний дугаар	Үнэт цаасны зах зээлд оролцогчид үйлчилгээ үзүүлэх гэрчилгээний дугаар	
Б. Баяр	0087		
Х. Баасанжаргал	0049	13/23	
Б. Нямцэрэн	2070	17013	
С. Баясгалан	1083		



Баярмал

2018-03-12



/Өмгөөллийн ИЭлСи ХХН-ийн хуульчдын гэрчилгээний хуулбарыг Хавсралт 9-өөс үзнэ үү./

Хуулийн дүгнэлт

Өмгөөллийн ИЭлСи ХХН нь Компанийн (Эрдэнэ)-ийн энгийн хувьцааг МХБ-д гаргаж, үнэт цаасны давхар бүртгэл хийлгэх ажиллагаанд хуулийн зөвлөхөөр ажилласан.

Тус Өмгөөллийн ИЭлСи ХХН нь дараах хууль зүйн дүгнэлтийг гаргасан байна:

1. Эрдэнэ болон түүний Монгол Улсад бүртгэлтэй компаниуд нь харьяалсан улсын хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдаж, хууль ёсоор бүртгэгдсэн байна.
2. Эрдэнэ болон түүний Монгол компаниудын төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтны бүрэн эрх нь хүчин төгөлдөр байна.
3. Эрдэнэ болон түүний Монгол дахь компаниудын сүүлийн нэг (1) жилийн дотор хийсэн томоохон хэлцлүүд нь холбогдох хууль тогтоомжийн дагуу хийгдсэн байна.
4. Эрдэнэ болон түүний Монгол компаниудын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл нь хүчин төгөлдөр бөгөөд тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээсэн зэргээр Эрдэнэ болон Монгол компаниудын үйл ажиллагаанд бодитоор нөлөөлж болохуйц нөхцөл үүсээгүй байна.
5. Эрдэнэ болон түүний Монгол компаниудын үнэт цаас, үл хөдлөх болон бусад эд хөрөнгө өмчлөх эрх нь хүчин төгөлдөр, ямар нэг үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээсэн нөхцөл үүсээгүй байна.
6. Давхар бүртгэлтэй холбоотойгоор Эрдэнээс СЗХ болон МХБ-д гаргаж буй үнэт цаасны өргөдөл, Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан мэдээлэл нь үнэн зөв, хүчин төгөлдөр байна.

/Хууль зүйн дүгнэлтийн дэлгэрэнгүйг Хавсралт 10-аас үзнэ үү./

1.7.2 Аудитын дүгнэлт

Танилцуулга

KPMG нь аудит, татвар болон мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг олон улсын сүлжээ байгууллага юм.

KPMG-ийн гишүүн байгууллагууд нь дэлхийн өнцөг булан бүрт яг ижил аудитын арга барил, горимыг хэрэгжүүлдэг ба энэхүү арга барил нь үйлчлүүлэгчдийнхээ үйл



Васильев

[Handwritten signature]

2018 03 12 J



ажиллагааны онцлог болон гүйцэтгэлд суурилж, эрсдэлд нөлөөлж буй гол хүчин зүйлсийг тодорхойлох юм.

Тусгай зөвшөөрөл

The Public Company Accounting Oversight Board (PCAOB) нь анх 2002 оны Sarbanes–Oxley хууль, актын дагуу үүсгэн байгуулагдсан ашгийн бус хувийн байгууллага юм. Уг байгууллага нь үнэн зөв, хараат бус аудитын дүгнэлтийг гаргаж хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалахын тулд олон нийтэд нээлттэй компаниудад аудит хийдэг. Кэй Пи Эм Жи (KPMG) компани нь PCAOB-д 2004 оны 05 сарын 14-ний өдөр бүртгэгдсэн.

/Кэй Пи Эм Жи (KPMG) компанийн бүртгэлийн дэлгэрэнгүйг Хавсралт 11-ээс үзнэ үү./

Дүгнэлт- Компанийн аудитлагдсан санхүүгийн тайлангаас орчуулан буулгав

Кэй Пи Эм Жи нь Компанийн 2015, 2016 оны 12 сарын 31-ны байдлаарх нэгтгэсэн санхүүгийн байр суурь, нэгдсэн дэлгэрэнгүй алдагдлын тайлан, тухайн жилд дууссан өмчийн болон мөнгөн урсгалын өөрчлөлт болон нягтлан бодох бүртгэлийн бодлого болон бусад тайлбарт мэдээллийн хураангуйгаас бүхий тайлбараас бүрдсэн санхүүгийн нэгдсэн тайланд аудит хийв.

Аудиторын үзэж буйгаар Компанийн 2015, 2016 оны 12 сарын 31-ны байдлаарх санхүүгийн байр суурийг санхүүгийн нэгдсэн тайлангуудад бүхий л баримт бичгийн хувьд болон санхүүгийн нэгдсэн гүйцэтгэл, мөнгөний урсгал нь тухайн жилийн эцэсүүдэд Олон улсын санхүүгийн тайлангийн стандартуудын дагуу үнэн зөв танилцуулсан.

/Аудитаар баталгаажсан санхүүгийн тайлангийн дэлгэрэнгүйг, орчуулгын хамтаар Танилцуулгын Хавсралт 12-оос харна уу. /

1.7.3 Үнэлгээ

Энэхүү Танилцуулгын хүрээнд Компани хувьцааг Монголын Хөрөнгийн Биржид санал болгохоос өмнө Компани нь Торонтогийн Хөрөнгийн Биржид бүртгүүлж, 2004 оноос хойш хувьцааг олон нийтэд арилжаалж байна. Энгийн хувьцааны санал болгох үнийг тодорхойлоход зах зээлийн нөхцөл байдлаас гадна Компанийн хувьцааны үнийн түүхэн гүйцэтгэл, үйл ажиллагааны хэтийн төлөвийн тооцоолол, удирдлагын үнэлгээ зэрэг хүчин зүйлсийг харгалзан үздэг. Гэвч Компани ТХБ-д бүртгэлтэй, хувьцааны үнийг зах зээлээр тогтоож, үнэлдэг зэргээс үзэхэд нийтэд санал болгох хувьцааны үнийг ТХБ-д бүртгэгдсэн хувьцааны зах зээлийн үнэлгээнд тулгуурлан үнэлэх нь зүйтэй гэж үзсэн.

Багшиг



2018 03 12



Үнэлгээний үзүүлэлтүүд:

Зах зээлийн үнэлгээ (2018 оны 02 сарын 28-ны байдлаар) 62.22 сая кан.доллар
52 долоо хоногийн хэлбэлзэл (2018 оны 02 сарын 28-ны байдлаар) 0.425-1.40 кан.доллар

Компанийн зах зээлийн үнэлгээ 2018 оны 02 сарын 28-ны байдлаар 62.22 сая Канад доллар, үүнээс Компани өөрийн нийт гаргасан хувьцааны 2.7 хүртэлх %-тай тэнцэх хэмжээний энгийн хувьцааг Монголын Хөрөнгийн Биржид санал болгон, 1.2 сая Канад доллартай тэнцэх хөрөнгийг босгох төлөвлөгөөтэй байна.

Санал болгож буй Энгийн Хувьцааны нэгж тус бүрийн үнийг СЗХ-ны шийдвэр гарахаас өмнө Компани болон Андеррайтерууд харилцан зөвшилцсөн өдрөөр ("Үнэ тогтоох өдөр") дуусгавар болгон тогтооно. Санал болгох үнийг Үнэ тогтоох өдрөөр дуусгавар болсон ТХБ-д арилжигдаж буй 10 хоногийн жигнэсэн дундаж ханшаас 10%-ийн хөнгөлөлттэй тогтооно. Энэхүү канад доллараар тогтоогдсон үнийг Үнэ тогтоох өдрийн Монгол Банкны валютын ханшид хөрвүүлэн Монгол төгрөгөөр илэрхийлнэ. Санал болгож буй үнийг танилцуулж, СЗХ-нд бүртгүүлэхээс өмнө ТХБ-ээс зөвшөөрөл авсан байх шаардлагатай.

Компани нь Монголын Хөрөнгийн биржид гадаад улсаас давхар бүртгүүлж буй анхны компани, хувьцаа нь Торонтогийн Хөрөнгийн биржид нээлттэй арилжигддаг зэрэг онцлогтой. Иймд давхар бүртгэлийн хүрээнд санал болгож буй үнэт цаасны үнийг урьдчилж тогтоох нь дараах бэрхшээл учруулж болзошгүй тул Компани нь үнэ тогтоохыг хойшлуулах санал гаргасан. Дурдсан бэрхшээлүүдэд:

- Валютын ханшийн өөрчлөлт. ТХБ дэх Компанийн хувьцаа Канад доллараар илэрхийлэгддэг, төгрөгтэй харьцах Канад долларын ханш өөрчлөгдсөнөөр тогтоосон үнэд нөлөөлөх.
- Хувьцааны ханшийн өөрчлөлт. ТХБ дэх хувьцааны ханш өөрчлөгдсөнөөр тогтоосон үнэд нөлөөлөх.

Компани нь эдгээр нөхцөл байдлыг харгалзан МХБ-д санал болгох хувьцааны үнийг дээрх байдлаар тогтоохоор шийдвэрлэв.

1.7.4 Андеррайтер

Тэргүүлэх андеррайтер:

Компанийн нэр: "Би Ди Сек ҮЦК" ХК
Улсын бүртгэлийн дугаар: 9010001030
Регистрийн дугаар: 2052482



Биегма

2018-03-12

1000 92
БҮРТГЭВ 01

Үйл ажиллагааны чиглэл: Брокер, дилер, хөрөнгө оруулалтын зөвлөх, андеррайтер

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Залуучуудын өргөн чөлөө, 27/1, "Би Ди Сек ҮЦК" ХК-ийн төв байр.

Утас: 976-11-313108, 976-11-323411

СХК
БҮРТГЭВ
01

"Би Ди Сек ҮЦК" ХК-ийн танилцуулга

БиДиСек нь 1991 оны өмч хувьчлал явагдаж Хөрөнгийн зах зээлийн харилцаа бий болсон цагаас эхлэн өнөөдрийг хүртэл тасралтгүй үйл ажиллагаагаа явуулж ирсэн 26 жилийн туршлагатай компани юм.

"БиДиСЕК ҮЦК" ХК нь 2005 онд 32 дугаартай андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хуучнаар Үнэт Цаасны Хорооноос авч, 2007 онд Хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг Санхүүгийн Зохицуулах Хорооноос авснаар Монгол улсад анхны үнэт цаасны цогц үйлчилгээг үзүүлэгч үнэт цаасны компани болсон.

2007-2017 онуудад МХБ-ийн үнэт цаасны арилжааны нийт гүйлгээний 26-91%-ийг гүйцэтгэснээс 2012 онд хамгийн өндөр буюу үнэт цаасны гүйлгээний 91%-ийг гүйцэтгэсэн.

Мөн Монголын Хөрөнгийн Биржид шинээр болон нэмж хувьцаа гарган татан төвлөрүүлсэн санхүүжилтийн 65%-д, нээлттэй компанийн бондын 36%-д нь андеррайтерийн үйлчилгээ үзүүлэн ажилласан байна.

Тусгай зөвшөөрөл


"Би Ди Сек ҮЦК" ХК-ийн 2005 онд хуучнаар Үнэт цаасны Хорооны шийдвэрээр 32 тоот андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаатай авсан ба улмаар Санхүүгийн Зохицуулах Хорооны 2008 оны 6 сарын 12 өдрийн 136 тоот тогтоолоор андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг 3 жилийн хугацаатайгаар сунгасан. Мөн Санхүүгийн Зохицуулах Хорооны 170 тоот тогтоолоор 2011 оны 6 дугаар сарын 12-ны өдрөөс 3 жилийн хугацаагаар андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг сунгасан. 2013 оны 5 дугаар сарын 24-ны өдөр "Үнэт цаасны зах зээлийн тухай хууль" –ийг шинэчлэн найруулж УИХ-аас баталсан бөгөөд үүнтэй холбоотой холбогдох журмууд шинэчлэгдэж андеррайтерийн тусгай зөвшөөрөл нь 3 жилийн хугацаагаар сунгагддаг байсан нь өөрчлөгдөн хугацаагүй болсон.

2018 03 12 J

Бсермае

Андеррайтер
Брокер, дилерийн
"БИДИСЕК"
ҮЦК ХК 72
113520544

0000-93



/Андеррайтерийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбарыг Хавсралт 13-аас үзнэ үү./



Андеррайтертай байгуулсан гэрээгээр хүлээсэн эрх үүргийн талаар

БиДиСек нь 2018 оны 01 сарын 31-ний өдөр хийсэн гэрээний (2018 оны 2 дугаар сарын 26, болон 2018 оны 3 дугаар сарын 09-нд оруулсан нэмэлт өөрчлөлт) дагуу Би Ди Сек ХК-ийг андеррайтераар томилж, андеррайтер нь Компанийн Монголын Хөрөнгийн Биржид арилжаалах 1.2 сая канад доллартай тэнцэх хувьцааг "firm commitment" нөхцөлтэйгөөр олон нийтэд санал болгох үүргийг хүлээсэн.

Лунэт цаас гаргагчийн андеррайтерийн компанитай хийсэн гэрээний хуулбарыг Танилцуулгын хавсралт 14-өөс, андеррайтерийн дүгнэлтийг хавсралт 15-аас үзнэ үү./

Хамтрагч андеррайтер:

Компанийн нэр:	"Голомт Капитал ҮЦК" ХХК
Улсын бүртгэлийн дугаар:	9011287134
Регистрийн дугаар:	5481589
Үйл ажиллагааны чиглэл:	Брокер, хөрөнгө оруулалтын зөвлөх, андеррайтер
Хаяг:	401 тоот, 4 давхар, Очир төв, Олимпийн гудамж 12/1, Улаанбаатар 210644, Монгол Улс
Утас:	70121530, 70121529
Факс:	+976-70121529
И-мэйл:	info@golomtcapital.com
Вэб хуудас:	www.golomtcapital.com

"Голомт Капитал ҮЦК" ХХК-ийн танилцуулга

"Голомт Капитал ҮЦК ХХК" нь 2012 онд "Голомт Банк" ХХК-ийн 100% хөрөнгө оруулалттайгаар түүний охин компани болон байгуулагдсан. Андеррайтер нь анх 2011 оны 11 сарын 02-ны өдөр Санхүүгийн Зохицуулах Хорооноос "Харилцагчийн нэрийн өмнөөс түүний даалгавраар гүйцэтгэх хөрөнгө оруулалтын бусад ажил, үйлчилгээ эрхлэх" тусгай зөвшөөрөл авснаар үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн.

Хөрөнгийн зах зээл дээр үйл ажиллагаагаа явуулснаас хойш дараах гол амжилтуудыг гаргасан байна:

- Анхны Real-time онлайн арилжааны системийг нэвтрүүлсэн
- Анхны даатгагдсан бонд "Эрчим бонд"-г гаргасан

Баерине



2018-03-12



- Анхны ББСБ-ын даатгагдсан бонд “ММФ бонд”-г гаргасан
- Анхны ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжааг гүйцэтгэсэн
- Засгийн газрын олон улсын зах зээлд гаргасан “Мазаалай бонд”-д дотоод зөвлөхөөр ажилласан
- 2013 онд МХБ-ийн нийт арилжааны 49%-г гүйцэтгэсэн
- Жил бүр “Mongolian Investment Summit”- ийг зохион байгуулдаг
- 2017 онд хаалттай хүрээнд “ММФ бонд II” болон “Урбан бонд I, II”-г гаргасан
- 2017 онд “Сүү” ХК-ийн 6.0 тэрбум төгрөгийн бондыг амжилттай гарган түүхэн дээд амжилт тогтоосон

Тусгай зөвшөөрөл

2011 оны 11 сарын 02-ны өдөр Санхүүгийн Зохицуулах Хорооноос “Харилцагчийн нэрийн өмнөөс түүний даалгавраар гүйцэтгэх хөрөнгө оруулалтын бусад ажил, үйлчилгээ эрхлэх” болон 2014 оны 03 сарын 26-ны өдөр Санхүүгийн Зохицуулах Хорооноос “Хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх” тусгай зөвшөөрөл, 2015 оны 3 сарын 23-ны өдөр “Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх” тусгай зөвшөөрлийг тус тус авч иргэд, ААН-үүдэд хөрөнгө оруулалтын цогц үйлчилгээг үзүүлж байна.


“Голомт Капитал ҮЦК” ХХК-ийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбарыг Хавсралт 16-аас үзнэ үү./

1.7.5 Мэргэшсэн мэргэжилтэн

Энэхүү үнэт цаасны танилцуулга нь ТХБ-ийн бүртгэлд давхар хамаарах ба, тухайн байгууллагын шаардлагаар үнэт цаас гаргагч нь энэхүү танилцуулгад техникийн мэдээллийг мэргэшсэн мэргэжилтний хянасны дагуу танилцуулах үүрэг хүлээдэг. Компанийн мэргэшсэн мэргэжилтэн болох Майкл А.МакДоналд (Michael A. MacDonald) нь газарзүйн шинжлэх ухааны салбарын мэргэжилтэн (Nova Scotia) бөгөөд NI 43-101 зааварчилгаанд заасан ажил, мэргэжлийн шаардлагуудыг хангасан болно. Ноён МакДоналд нь Компанийн Хайгуул эрхэлсэн Дэд Ерөнхийлөгчийн албан тушаалыг хашдаг ба олон нийтэд ил болгох техникийн мэдээллүүдийг хянан батлах, Компанийн чанарын хяналт, чанарын баталгаажуулалтын (QA/QC) протоколд хяналт тавих үүрэгтэй байна.

Дээжийг Монгол Улсын Улаанбаатар хотноо, эсхүл Хятадын Тяньжинд байрлах Эс Жи Эс лаборатори (SGS Laboratories), Улаанбаатар дахь Геологийн төв лаборатори, Канадын Бритиш Колумбийн муж дахь Блю Көүст Рисерч Лтд (Blue Coast Research Ltd) эсхүл Канадын Ванкувер хотод төвтэй ALS Chemex лабораторид тус тус шинжлүүлдэг. Эс Жи

Баермее



2018-03-12

0000 95
БҮРТГЭВ
... 01 ... сар ... өдөр

СЗХ
БҮРТГЭВ
№ 01

Эс лаборатори, Геологийн төв лаборатори, ALS Chemex лабораторийн дотоод хяналтаас гадна Компани нь бэлтгэсэн стандарт, хээрийн болон лабораторийн хуваалт, бэлдэцийг ашиглан дээжийн чанарын хяналт, баталгаажуулалт (QA/QC)-ын протоколыг гүйцэтгэнэ.

1.7.6 Хараат бус техникийн зөвлөх компани

Компанийн нэр:	“КьюЭмСи” ХХК
Улсын бүртгэлийн дугаар:	9011291125
Регистрийн дугаар:	5495105
Үйл ажиллагааны чиглэл:	Технологийн зураг төсөл, Орчуулгын үйл ажиллагаа /ЗТ16-596/16, 749900 кодтой/
Хаяг:	СБД, 1-р хороо, Юнескогийн гудамж, Реженси Резиденс, зүүн жигүүр 202 тоот
Утас:	+976-7711-1100

“Кью Эм Си” ХХК-ийн танилцуулга

“Кью-Эм-Си” ХХК нь уул уурхайн зөвлөгөө өгөх, зураг, төсөл боловсруулах, уурхайн нөхөн сэргээлт, хаалтын төсөл, эдийн засгийн үнэлгээ, зах зээлийн судалгаа, төлөвлөлт, зөвлөх үйлчилгээний чиглэлээр Монголын уул уурхайн салбарт үйл ажиллагаагаа явуулдаг.

“Кью-Эм-Си” ХХК нь уул уурхайн төслүүдэд эхлэлийн шатнаас эцсийн бүтээгдэхүүн гаргах хүртэлх бүхий л үе шатуудад зөвлөх, техник эдийн засгийн үнэлгээ (ТЭЗҮ) боловсруулах, төслийн менежментийг гүйцэтгэх, үйлдвэрлэлийн автоматжуулалт, байгаль орчны хамгааллын ажил, үйлчилгээ үзүүлэх чиглэлүүдэд төвлөрч ажилладаг, үндэсний хөрөнгө оруулалттай компани юм.

“Кью Эм Си” ХХК-ийн инженер техникийн ажилтнууд, геологичид, зөвлөх инженерүүд, мэргэжилтнүүд уул уурхайн төслийн урьдчилсан болон нарийвчилсан ТЭЗҮ боловсруулж, баяжуулах, боловсруулах үйлдвэр, холбогдох дэд бүтцийн төсөл, судалгааны ажлуудыг гүйцэтгэж, техникийн болон бизнесийн зөвлөгөө өгдөг. Мэргэжлийн түвшинд олон улсын хэмжээнд түгээмэл хэрэглэдэг геологи, уул уурхайн төлөвлөлтийн программ хангамжууд, зураг төслийн программууд, интернет сүлжээнд суурилсан мэдээллийн сангуудыг ашигладаг.


Тусгай зөвшөөрөл

“Кью Эм Си” ХХК нь 2011 оны 07 сарын 04-ний өдөр гадаад худалдаа, орчуулгын үйл ажиллагаа явуулах чиглэлээр 9011291125 дугаартай гэрчилгээ авсан. 2013 оны 03 сарын

Б.Серина

УЛААНБААТАР ХОТ
МОНГОЛ
Б.Серина
11152153

2018-03-12



11-ний өдөр зураг төсөл 1.5.1 заалтын дагуу Технологийн зураг төсөл /эрчим хүчний байгууламж, хөнгөн ба хүнд үйлдвэр, уул уурхайн технологи чиглэлээр үйл ажиллагаа өдөр явуулах ЗТ16-596/16 дугаартай тусгай зөвшөөрөл авсан.



“Кью Эм Си” ХХК-ийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбарыг Хавсралт 17-оос үзнэ үү./

Мэргэшсэн геологичийн хөндлөнгийн дүгнэлт

“Кью Эм Си” ХХК нь Эрдэнэ Монгол ХХК-ийн “Баянхонгор аймгийн Баян-өндөр, Шинэжинст сумдын нутагт орших Цэнхэр Номин (XV-016956X), Хөндий (XV-015569X) нэртэй хайгуулын тусгай зөвшөөрлийн тайлбайд гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүн”-д хөндлөнгийн дүгнэлт гаргажээ.

“Кью Эм Си” ХХК-ийн мэргэшсэн мэргэжилтний олон нийтэд зориулсан хураангуй дүгнэлтэнд:

Хайгуулын ажлын талаар: Кью Эм Си ХХК-ийн мэргэжилтэн нь Эрдэнэ Монгол ХХК-ийн тайлагнасан техникийн судалгаанууд, мэдээллүүдэд тулгуурлан дүгнэлтийг гаргасан. Тайлагнасан мэдээлэлд Монгол Улс болон олон улсад нэр хүнд бүхий байгууллагаар гүйцэтгүүлсэн техникийн судалгаа, мэдээллүүд орно. Түүнээс гадна, Кью Эм Си ХХК нь Г.Бат-Эрдэнээр ахлуулсан Монголын геологийн баг болон Майкл Гиллисээр ахлуулсан Канадын геологийн багийн хайгуулын өрөмдлөг, судалгааны ажлуудад дүгнэлт гаргасан. Мөн Компанийг ТХБ-д бүртгэлтэйг дурьдан, энэ нь Канадын Үнэт Цаасны Зохицуулах Байгууллагын шаардлагын дагуу техникийн тайлан дүгнэлтүүд, судалгаа мэдээллүүдэд тавигдах шаардлага нь өндөр түвшинд байгааг дүгнэлтэд тусгасан.

Ашигт малтмалын орд агуулах боломжтой талбайнуудад өрөмдлөгийн ажил хийж, Цэнхэр Номин тусгай зөвшөөрөлт талбайд Алтан Нар төслийн талбайг ялгаж Нээлтийн бүс, Хойд Холбоо гэж нэрлэсэн газруудад орд тогтоож, Номин Тал зэрэг цаашид үргэлжлүүлэн судлах шаардлагатай талбайнуудыг мөн олж илрүүлсэн байна. Хөндий нэртэй тусгай зөвшөөрөлт талбайн хэмжээнд Баян Хөндий төслийн талбайг ялгаж алтны өндөр агуулгатай Баян Хөндийн илрэлийг нээж илрүүлсэн байна. Энэхүү төслийн талбайд хийж байгаа хайгуул судалгааны үр дүнгээс харахад нөөц бодож орд болохоор алт агуулсан биетүүдийг олж илрүүлжээ. Уг талбайд цаашид үргэлжлүүлэн хайгуул судалгааны ажил явуулах Зүүн Хойд, Алтан Сум зэрэг талбайнуудыг мөн тогтоогоод байна.

Кью Эм Си компанийн геологич 2017 оны 8-9-р саруудад төслийн талбайд ажиллахдаа өрөмдөж гаргаж авсан чулуун дээжүүдтэй газар дээр нь танилцсан бөгөөд Эрдэнэ Монгол

2018-03-12



Басрияа

[Handwritten signature]



компанийн алт, зэс агуулсан хүдэр, чулуулгийн дээж, дээж боловсруулах дамжлагатай танилцсан байна. Өрөмдөж гаргаж авсан дээжүүдийг хөндлөнгийн лабораторид өгч шинжлүүлсэн, лабораторийн шинжилгээнд алдаа гарахаас сэргийлэн давхар шалгадаг байдал нь энэ төрлийн ажилд ашиглагддаг стандартад нийцэж байгаа нь холбогдох тайлантай танилцах явцад тодорхой болсон.

Энэхүү дүгнэлтийг гаргах өдрийн байдлаар Компанийн Алтан Нар, Баян Хөндий төслийн талбайнуудад явуулж буй хайгуулын ажил нь алт, алт-зэс-полиметалын хувьд нөөц тооцоолон тайлагнах түвшинд хүрч байгаа, Номин тал, Оюут Хөндийн төслийн талбай нь цаашид үргэлжлүүлэн судлах шаардлагатай болох нь тогтоогдсон үр дүнтэй байна. Баян Хөндий талбайгаас авсан дээжийг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн лабораторид илгээн доторх алтыг нь ялган авах туршилтын ажил хийлгэж, хүдэр дэх алтны 90 гаруй хувийг ялган авах боломж байгааг тогтоосон байгаа нь эдгээр талбайнууд дээр цаашид ордын нөөц тооцоолох боломж нээлттэй байгааг харуулж байна.

Эрдэнэ Монгол компанийн төслүүдийг Монголын Хөрөнгийн Биржид танилцуулах талаар: Компанийн төслүүдтэй танилцсаны үндсэн дээр Монголын Геологи, Уул Уурхайн Мэргэшсэн Институтээс боловсруулсан Хайгуулын ажлын үр дүн, эрдсийн баялаг, хүдрийн нөөцийг олон нийтэд тайлагнах Монгол Улсын Код, түүний Хүснэгт 1, Үнэлгээ хийх ба Тайлагнах Шалгуурын дагуу шалгаж үзэхэд олон нийтэд Хүдрийн нөөц тайлагнах, Эрдсийн баялаг тайлагнах, Хайгуулын ажлын үр дүн тайлагнах боломжууд байгаа ба Компанийн төслүүд нь Хайгуулын ажлын үр дүн тайлагнах түвшний шаардлагуудыг хангаж байна.

Хүснэгт 1, Үнэлгээ хийх ба Тайлагнах Шалгуурт заасан Дээж авах арга техник, өрөмдлөг хийсэн арга техник, өрөмдөж гаргаж авсан чулуун дээжийн чанарт тавигдах шаардлага, чулуун дээжүүдийг бүртгэж баримтжуулсан байдал, чулуун дээжээс лабораторид илгээх дээж бэлтгэсэн байдал, лабораторид хэмжилт хийлгэсэн байдал, лабораторийн хийсэн ажлын чанарыг шалган баталгаажуулсан байдал зэрэг Хайгуулын ажлын үр дүн тайлагнахад тавигдах шаардлагуудыг Компанийн хийсэн хайгуулын ажлаар хангасан байна.

Монгол Улсын Геологи, Уул Уурхайн Мэргэшсэн Институтээс боловсруулсан Хайгуулын ажлын үр дүн, эрдсийн баялаг, хүдрийн нөөцийг олон нийтэд тайлагнах Монгол Улсын Код-д Хайгуулын ажлын үр дүнг тайлагнахдаа олон нийтэд ойлгомжтой байхын тулд дараах тодотголыг заавал оруулахыг зөвлөсөн байдаг. Үүнд: "Энэхүү тайлан/мэдэгдэл/дүгнэлтийн доторх мэдээлэл нь MRC кодын 18-р зүйлд заасан Хайгуулын ажлын үр дүн тайлагнах түвшний мэдээлэл болно. Энэ түвшний мэдээлэлд

2018-03-12



Бсөрмээ



хүдрийн нөөцийн хэмжээ, уг нөөцийн агууламжийн тооцоололтой холбоотой тоо баримт оруулах нь тохиромжгүй байдаг” хэмээн дурджээ.

/"Кью Эм Си" ХХК-ийн хөндлөнгийн дүгнэлтийн дэлгэрэнгүйг Хавсралт 18-аас үзнэ үү./

ХОЁР. ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ

2.1. Үнэт цаас гаргах тухай холбогдох шийдвэр, үнэт цаас гаргагчийг төлөөлөх эрх бүхий этгээд

Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь МХБ дээр олон нийтэд санал болгон үнэт цаас гаргахыг зөвшөөрсөн шийдвэрийг 2018 оны 02 сарын 28-ны өдөр гаргасан.

Уг шийдвэрт компанийн үнэт цаас гаргахтай холбоотой дараах асуудлыг тусгасан:

1. Үнэт цаасны танилцуулгад заасан нөхцөлөөр, Үнэт цаас гаргах хүрээнд 4,000,000 ширхэг хүртэлх энгийн хувьцаа гаргахыг үүгээр баталж, энгийн хувьцааг дурдсан зорилгоор нөөцөлж, хуваарилсугай.
2. Корпорацийн эрх ашгийн үүднээс, Корпорацийн захирлууд нь гаргахаар Санал болгож буй хувьцаа бүрийн үнийг Компани зөвшилцсөний үндсэн дээр Үнэт цаасны танилцуулгыг СЗХ-нд бүртгүүлэх хүсэлтийг хүргүүлсэний дараа, СЗХ-ны зөвшөөрөл гарахаас өмнө өдрийг тодорхойлж, ТХБ-д арилжиж буй Энгийн хувьцааны арван өдрийн арилжааны жигнэсэн дундаж ханшаас 10%-ийг хорогдуулсан дүнгээр ("Санал болгох үнэ"), ТХБ-ээс авах зөвшөөрлийн хүрээнд үүгээр баталж, энэхүү үнийн дүнг тодорхойлж тогтоох эрхийг Корпорацийн аливаа албан тушаалтан буюу захиралд (тус бүрийг "Эрх бүхий албан тушаалтан") олгосугай.
3. Корпораци нь Үнэт цаас гаргах хүрээнд Санал болгож буй хувьцааны Санал болгох үнийг хүлээн авсны дараа ийнхүү Санал болгож буй хувьцааг үнийг нь тогтоосон бөгөөд үнэ нь бүрэн төлөгдсөн Энгийн хувьцаа болгон гаргахыг үүгээр зөвшөөрч, Энгийн хувьцааны шилжүүлгийн агент бөгөөд бүртгэгч Компьютершэйр Инвестор Сервисэс Инк. компанид ("Computershare Investor Services Inc", "Компьютершэйр") Корпорацийн зүгээс цаашид аливаа арга хэмжээ авах шаардлагагүйгээр Санал болгож буй хувьцааг илэрхийлэх баталгаа буюу бусад нотлох баримтад хоёр дахь гарын үсэг зурах, бүртгэх, олгох болон хүргүүлэх эрхийг үүгээр олгосугай.
4. Энгийн хувьцааны шилжүүлгийн агент бөгөөд бүртгэгч Компьютершэйр нь Корпораци Санал болгож буй хувьцааг гаргах, хуваарилахтай холбоотой төлбөрийг бүрэн хүлээн

Баярши



0000 99 01

СЗХ
саяр өдөр
БҮРТГЭВ
№ 01

авсан талаарх Корпорацийн албан тушаалтан гарын үсэг зурсан баталгаанд найдаж болохыг дурдсугай.

5. Аливаа Эрх бүхий албан тушаалтанд, Монгол улсын үйлчлэх хууль тогтоомжид заасны дагуу Монгол Улсын Санхүүгийн Зохицуулах Хороо, МХБ, Монгол Улсын аливаа бусад зохицуулах байгууллагад ("Монголын эрх бүхий байгууллагууд") бүхий л өргөдөл, хүсэлт гаргах, Үнэт цаасны танилцуулга болон Үнэт цаас гаргахтай холбоотой бүх баримт бичгийг гаргах өгөх зэргээр Үнэт цаас гаргахтай холбогдуулан бүхий л шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлэх эрх олгож, үүрэг болгосугай.
6. Үнэт цаас гаргах болон МХБ-ийн бүртгэлтэй холбогдуулан МХБ-д бүхий л шаардлагатай өргөдөл, хүсэлт гаргах эрхийг, үүргийг Корпорацид олгож, МХБ-д гаргаж өгөх шаардлагатай бүх баримт бичгийг гаргаж өгөх эрхийг Корпорацийн аль нэг захирал, албан тушаалтан, хуулийн зөвлөх эсхүл аливаа бусад итгэмжлэгдсэн төлөөлөгчид олгосугай.
7. Корпорацийн бүрэн өмчилдөг охин компани болох Эрдэнэ Монгол ХХК-д, Монголын эрх бүхий байгууллагуудад МХБ-ийн бүртгэлтэй холбогдуулан Корпорацийн өргөдлийг өгөх, Монголын эрх бүхий байгууллагуудаас мэдэгдэл хүлээн авах, Монголын эрх бүхий байгууллагууд болон Монгол Улсад оршин суугаа Корпорацийн хувьцаа эзэмшигчидтэй харилцахдаа аливаа Эрх бүхий албан тушаалтны зааварчилгаар Корпорацийг төлөөлөх эрх олгосугай.
8. Үнэт цаас гаргах, Санал болгож буй хувьцааг ТХБ-д бүртгүүлэх болон Энгийн хувьцааг МХБ-д давхар бүртгүүлэхтэй холбогдуулан ТХБ-д бүхий л шаардлагатай өргөдөл, хүсэлт, баримт бичиг гаргаж өгөх эрхийг, үүргийг Корпорацид олгож, ТХБ-д гаргаж өгөх шаардлагатай бүх баримт бичгийг гаргаж өгөх эрхийг Корпорацийн аль нэг захирал, албан тушаалтан эсхүл хуулийн зөвлөхөд олгож, баталгаажуулж, зөвшөөрсүгэй.

/Үнэт цаас гаргах тухай эрх бүхий этгээдийн гаргасан шийдвэрийн дэлгэрэнгүйг Хавсралт 19-өөс үзнэ үү./

2018 03 12

Баерин

УЛААНБААТАР ХОТ
МХБ-ийн гишүүн
Андеррайтер
Брокер, дилерийн
"БНДИСЭ" ХХК
111526547



2.2. Үнэт цаасны анхдагч бүртгэлийг хийлгэсэн гадаад улсын арилжаа эрхлэх байгууллага болон үнэт цаасны зохицуулагч байгууллагад мэдэгдэх тухай

СЭХ-ны давхар бүртгэлийг зохицуулах журмын⁵ гуравдугаар бүлгийн 3.1.4-т "Үнэт цаасны анхдагч бүртгэлийг хийлгэсэн гадаад улсын арилжаа эрхлэх байгууллага болон үнэт цаасны зохицуулагч байгууллагад Монгол Улсад тухайн үнэт цаасны хоёрдогч бүртгэлийг хийлгэх гэж байгаа талаар албан ёсоор мэдэгдсэн байх" тухай шаарддаг.

Энэ талаар үнэт цаас гаргагчийн Канад улс дахь хуулийн зөвлөл МакИннес Күүпер (McInnes Cooper)-ээс ирүүлсэн захидалд⁶ Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн-ийн Энгийн Хувьцааг МХБ-д гаргаж, Монгол Улсын иргэн, хуулийн этгээдэд санал болгох ажиллагаанд Монгол Улсын хуулийн зөвлөх компанитай хамтран ажиллаж байгаа тухай ТХБ-д мэдэгдсэн болохыг, мөн уг санал гаргах ажиллагаатай холбоотойгоор Канадын хууль тогтоомжид Үнэт цаасны зохицуулах эрх бүхий байгууллагад аливаа өргөдөл гаргах шаардлага тавьдаггүй болохыг дурдсан байна.

/Дэлгэрэнгүйг Давхар бүртгэлтэй холбоотойгоор дагалдах материалууд 1-с үзнэ үү./

2.3. Хувьцаа эзэмшигчдийн эрх

- Хувьцаа эзэмшигчдийн эрх, үүрэг

Компанийн дүрэм болон Канадын компанийн болон үнэт цаасны хуулийн дагуу Хувьцаа эзэмшигчдийн хуралд санал оруулах эрхтэй холбоотой эрх үүргүүд МХБ болон ТХБ-д хувьцаа эзэмшиж буй хувьцаа эзэмшигчдэд харилцан тэгш эрхтэйгээр хэрэгжүүлнэ. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хувьцаа эзэмшигчид нь тухайн хэлэлцэж буй асуудлын хүрээнд нэг хувьцаа нэг санал буюу гар өргөн санал өгөх зарчмаар явагдана.


Канадын Үнэт Цаасны Хуулийн дагуу Компанид материаллаг өөрчлөлт гарах тухайд Канадын Үнэт Цаасны Захиргаанд мэдэгдэх үүрэгтэй. Мэдээлэл нь нууцын чанартай, эсвэл хувийн гэж үзсэнээс бусад тохиолдолд нийтэд нээлттэй буюу SEDAR, www.sedar.com-ооc авч, танилцах боломжтой. Материаллаг өөрчлөлтөд орох мэдээлэлд: материаллаг гэрээ хэлцлүүд, техникийн судалгаа, тайлангууд, хувьцаа эзэмшигчдийн хурлын саналын үр дүн болон тайлангууд, санхүүгийн тайлангууд болон ТУЗ, удирдах

⁵ Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй Хуулийн этгээд монгол улсад үнэт цаас гаргах, Монгол улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд гадаад улсад гаргах үнэт цаасыг бүртгэх журам

⁶ Үнэт цаас гаргагчийн Монгол Улс дахь хуулийн зөвлөх Өмгөөллийн ИЭлСи ХХН-д хандсан захидал. Давхар бүртгэлтэй холбоотойгоор дагалдах материалууд 21

Б.Сериев





албан тушаалтнуудын цалин урамшууллын мэдээлэл болон Монгол Улсын холбогдох засаг захиргааны байгууллагад тайлагнасан тайлангууд багтана. ТХБ-ийн шаардлагын дагуу компанид материаллаг өөрчлөлт гарсан даруйд Компани олон нийтэд мэдээллэх үүрэгтэй. Энэхүү мэдээллийг Компанийн вэб хуудас болон SEDAR, www.sedar.com-ооc авч танилцах боломжтой.

Дээрх дурдсан материаллаг өөрчлөлт орох бүрт Компани нь ТХБ болон Канадын Үнэт Цаасны Захиргаанд мэдээллэхээс гадна МХБ-д Монгол хэл дээрх орчуулга эсвэл Монгол хэл дээрх товч танилцуулгын хамт зэрэг хүргэнэ. Хэрэв энэхүү мэдээлэл нь МХБ-д ажлын бус цагаар хүргэгдсэн тохиолдолд дараагийн ажлын өдөр олон нийтэд ил тод болно. Мэдээллүүдийг www.mse.mn, www.sedar.com болон Компанийн вэб хуудасаас танилцан унших боломжтой.

Хүснэгт 2-1 Хувьцаа гаргахын өмнө болон гаргасны дараах томоохон хувьцаа эзэмшигчдийн бүтэц

Хувьцаа эзэмшигчид	Хоёрдогч бүртгэлийн өмнө		Хоёрдогч бүртгэлийн дараа	
	Хувьцааны тоо	Хувь	Хувьцааны тоо	Хувь
Teck Resources Ltd	13,222,904	9.03%	13,222,904	%
ТУЗ-ийн гишүүд, захирлууд	13,644,752	9.03%	13,644,752	%
ТХБ хөрөнгө оруулагчид	119,532,930	81.65%	119,532,930	%
МХБ хөрөнгө оруулагчид	-	-	4,000,000	%
			хүртэлх	
Нийт	146,400,586	100%		100%

2.3.1. Анх бүртгүүлсэн улсын болон Монгол Улсын хууль тогтоомжийн зохицуулалтын зөрүүтэй байдал, үүний улмаас үнэт цаас эзэмшигчид учирч болох эрсдэл, эрхээ хэрэгжүүлэх боломжийг хангах зохицуулалт

Хүснэгт 2-2 Канад улс болон Монгол улсын хууль тогтоомжийн зохицуулалтын зөрүүтэй байдал

Монгол Улс	Канад Улс	Эрсдэл / Арга хэмжээ
Үнэт цаас гаргах этгээд⁷		
Засгийн газар эсвэл компаниуд үнэт цаас гаргана.	Зөрчилдөөнгүй.	<u>Зөрчилдөөнгүй:</u> Хөрөнгө оруулагчдын эрх, ашиг сонирхолд аливаа эрсдэл үүсгэхгүй байна.
Компаниуд үнэт цаас гаргахдаа Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.	Зөрчилдөөнгүй. Компаниуд үйлчилж буй компанийн тухай хууль тогтоомж, мужийн болон нутаг дэвсгэрийн үнэт цаасны тухай хууль тогтоомж болон бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм,	

⁷Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, 7 дугаар зүйл.

Басрияа



2018-03-12



	журмыг дагаж мөрдөнө.	
Үнэт цаас гаргах⁸		
Үнэт цаасыг нийтэд санал болгон гаргах, эсвэл нийтэд санал болгохгүйгээр хаалттай хүрээнд гаргаж болно.	Зөрчилдөөнгүй.	<u>Зөрчилдөөнгүй:</u> Хөрөнгө оруулагчдын эрх, ашиг сонирхолд аливаа эрсдэл үүсгэхгүй байна.
Гадаад улсын хөрөнгийн биржид бүртгэлтэй үнэт цаас гаргагчийн үнэт цаасыг Монгол Улсын нутаг дэвсгэрт СЗХ-оос тогтоосон журмын дагуу бүртгэж болно.	Аливаа үнэт цаас гаргагчийн үнэт цаасыг (гадаад улсын хөрөнгийн биржид бүртгэлтэй буюу бусад эсэхийг үл харгалзан) мужийн болон нутаг дэвсгэрийн үнэт цаасны тухай хуульд заасны дагуу Канад дахь үнэт цаасны танилцуулгадаа тодорхойлсончлон бүртгэдэг болно.	Зохицуулалтын хувьд ялгаатай боловч <u>зарчмын хувьд зөрчилдөөнгүй:</u> аль аль улсуудын хууль тогтоомжид үнэт цаасыг гаргахаас өмнө нарийвчлан шалгах зохицуулалтын систем үйлчилдэг.
Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүрэг⁹		
Үнэт цаас гаргагч нь дараах үүрэгтэй: Үнэт цаас гаргах тухай шийдвэрийг эрх бүхий байгууллагын хурлаар хэлэлцэн гаргах;	Зөрчилдөөнгүй. Компанийн тухай хуулиар захирлууд үнэт цаас гаргах тухай шийдвэр гаргахыг шаарддаг.	<u>Зөрчилдөөнгүй:</u> Хөрөнгө оруулагчдын эрх, ашиг сонирхолд аливаа эрсдэл үүсгэхгүй байна.
Үнэт цаасны арилжаатай холбоотой мэдээ, тайланг холбогдох аргачлал, маягтын дагуу үнэн зөв гаргаж, тогтоосон хугацаанд СЗХ-нд хүргэх, нийтэд мэдээлэх;	Процедурын зохицуулалт бөгөөд Канад улсын хууль тогтоомжид байхгүй.	<u>Процедурин ялгаатай байдал:</u> Хөрөнгө оруулагчдын эрх, ашиг сонирхолд аливаа эрсдэл үүсгэхгүй байна.
Компанийн тухай хуульд зааснаас доошгүй тооны хараат бус гишүүнтэй байх;	Зөрчилдөөнгүй. Үнэт цаасны тухай хууль болон хөрөнгийн биржийн журмаар хараат бус гишүүний доод хэмжээг тогтоосон байдаг.	<u>Зөрчилдөөнгүй:</u> Хөрөнгө оруулагчдын эрх, ашиг сонирхолд аливаа эрсдэл үүсгэхгүй байна.
Тохиромжтой этгээдийг ¹⁰ эрх бүхий албан тушаалтнаар ¹¹ томилох буюу сонгох;	Канад улсын хууль тогтоомжид зохицуулалт байхгүй. Захирлуудаас тухай бүр үүрэг болгосны дагуу албан тушаалтнууд, захирлууд болон	Зохицуулалтын хувьд ялгаатай боловч <u>зарчмын хувьд зөрчилдөөнгүй:</u> аль аль улсуудын хууль тогтоомжид (i) компанийг

2018 03 12 1

⁸ Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, 6 дугаар зүйл.

⁹ Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, 20 дугаар зүйл.

¹⁰ Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, 68.1.Хороо дор дурдсан шалгуурыг хангасан этгээдийг тохиромжтой этгээд гэж тооцно:

68.1.1.тухайн үйл ажиллагаа, албан тушаалыг мэргэжлийн түвшинд шударгаар эрхлэх чадвартай байх;

68.1.2.хувь хүн бол мэргэжил, мэргэшил, туршлага, эрхэлж байсан ажил, албан тушаал, түүнтэй холбоотой хариуцлага хүлээж байсан эсэх, санхүүгийн болон ёс зүйн байдал нь уг албан тушаал эрхлэхэд тохиромжтой;

68.1.3.Хорооноос тогтоосон бусад нэмэлт шалгуур.

¹¹ Компанийн тухай хууль, 84.1.Компанийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн, гүйцэтгэх захирал, санхүүгийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч, ерөнхий мэргэжилтэн, төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга зэрэг компанийн албан ёсны шийдвэрийг гаргахад болон гэрээ, хэлцэл хийхэд шууд болон шууд бусаар оролцдог этгээдийг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно.



Баермаа

000113
 БИДНИЙ
 01

	бусад этгээдүүдэд компанийн нэрийн өмнөөс түүнийг төлөөлөх эрх олгох боломжтой.	<p>төлөөлөх эрх бүхий эдгээдийн төлөөлөх хэрэгжүүлэхдээ баримтлах стандарт, үүргийг тогтоосон байдаг;</p> <p>(ii) 'тохиромжтой этгээдийг' тодорхойлсон нь зарчмын хувьд зөрчилдөөнгүй байна.</p>
Үнэт цаасны танилцуулгад заасан төслийн хэрэгжилт өөрчлөгдсөн тохиолдолд тухай бүр нийтэд болон хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх;	Зөрчилдөөнгүй. ТХБ-д бүртгэлтэй Канадын үнэт цаас гаргагчийг нууцад хамаарахаас бусад чухал мэдээллээ мэдээлэхийг шаарддаг.	<u>Зарчмын хувьд зөрчилдөөнгүй:</u> аль аль улсуудын хууль тогтоомжид төслийн хэрэгжилтэд онцгой ач холбогдол бүхий өөрчлөлт бий болсон тохиолдолд олон нийтэд мэдээлэх үүрэг болон тогтолцоог тогтоож өгсөн байна.
Хороонд бүртгэлтэй аудитын байгууллагаар баталгаажуулсан болон аудитаар баталгаажуулаагүй улирлын жилийн эцсийн санхүүгийн тайлан, тэнцлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасан хугацаанд СЗХ болох МХБ-д хүргүүлэх;	Зөрчилдөөнгүй. Канадын үнэт цаас гаргагчийг, үнэт цаасны тухай хуульд заасан хугацаанд аудитаар баталгаажуулсан жилийн эцсийн санхүүгийн тайлан болон аудитаар баталгаажуулаагүй улирлын санхүүгийн тайланг үнэт цаасны зохицуулах байгууллагуудад хүргүүлэхийг шаарддаг.	<u>Зарчмын хувьд зөрчилдөөнгүй:</u> аль аль улсын хууль тогтоомжид аудитаар баталгаажуулаагүй тогтмол хугацааны санхүүгийн тайлан, тэнцэл мөн аудитаар баталгаажуулсан жилийн эцсийн тайлан тэнцлийг тодорхойлсон хугацаанд албан ёсоор үнэт цаасны зохицуулах байгууллагад хүргүүлэх шаардлага, тогтолцоог тогтоон өгсөн байна.
Компанийн үйл ажиллагаа, санхүүгийн байдлын талаарх мэдээллийг СЗХ-оос тогтоосон журмын дагуу нийтэд мэдээлэх;	Зөрчилдөөнгүй. Санхүүгийн тайланг SEDAR (www.sedar.com) цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлэх ёстой.	<u>Зөрчилдөөнгүй:</u> Хөрөнгө оруулагчдын эрх, ашиг сонирхолд аливаа эрсдэл үүсгэхгүй байна.
Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийг нийтэд нэн даруй мэдээлж, холбогдох баримт бичиг, мэдээллийг хурал хуралдсанаас хойш ажлын гурван өдрийн дотор СЗХ болон Хөрөнгийн биржид хүргүүлэх;	Зөрчилдөөнгүй. Хувьцаа эзэмшигчдийн хурлын санал хураалтын дүнг SEDAR-аар дамжуулан нийтэд мэдээлэхийг шаарддаг. Дараагийн жилийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэлийг танилцуулдаг.	Зохицуулалтын хувьд ялгаатай боловч <u>зарчмын хувьд зөрчилдөөнгүй:</u> аль аль улсын хувьд нийтэд мэдээлэх шаардлага, тогтолцоог тогтоож өгсөн байна.

2018 03 12 J

Баарина

УЛААНБААТАР ХОТ
 МХБ-ийн гишүүн
 Андерраитер
 Брокер, "БИДНИЙ"
 83
 11152



<p>Үнэт цаасны ханш, арилжааны хэмжээнд мэдэгдэхүйц нөлөөлж болох нөхцөл байдал үүсмэгц энэ тухай нийтэд нэн даруй мэдээлэх;</p>	<p>Зөрчилдөөнгүй. ТХБ-д бүртгэлтэй Канадын үнэт цаас гаргагчийн нууцад хамаарахаас бусад чухал мэдээллийг мэдээлэхийг шаарддаг.</p>	<p>Зөрчилдөөнгүй: Хөрөнгө оруулагчдын эрх, ашиг сонирхолд аливаа эрсдэл үүсгэхгүй байна.</p>
<p>СЗХ-оос баталсан компанийн засаглалын зарчмыг үйл ажиллагаандаа дагаж мөрдөх.</p>	<p>Зөрчилдөөнгүй. Канадын үнэт цаасны зохицуулах байгууллагууд нь үнэт цаас гаргагчдыг холбогдох компанийн засаглалын журам болон компанийн засаглалын асуудлаарх нээлттэй, зөвлөх удирдамж, зааврыг дагаж мөрдөхийг шаарддаг.</p>	<p>Зөрчилдөөнгүй: Хөрөнгө оруулагчдын эрх, ашиг сонирхолд аливаа эрсдэл үүсгэхгүй байна.</p>

Мэдээллийг ил тод болгох ¹²

<p>Үнэт цаасны анхдагч зах зээлд үнэт цаас гаргагч нь дор дурдсан мэдээллийг сонирхсон этгээдэд өгөх үүрэгтэй:</p> <p>Үнэт цаасны танилцуулгад туссан мэдээлэл;</p> <p>Үнэт цаас гаргагчийн дүрэм, журамд заасан үнэт цаас гаргах, үнэт цаасыг арилжих журам;</p> <p>Санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан; мөн</p> <p>СЗХ, хөрөнгийн бирж болон бусад эрх бүхий байгууллагаас тогтоосон болон үнэт цаас гаргагчийн дүрэм, журамд нийтэд мэдээлэхээр тусгасан мэдээлэл.</p>	<p>Зөрчилдөөнгүй. Үнэт цаасны танилцуулгыг SEDAR цахим хуудсанд олон нийтэд нээлттэй байлгадаг.</p>	<p>Зөрчилдөөнгүй: Хөрөнгө оруулагчдын эрх, ашиг сонирхолд аливаа эрсдэл үүсгэхгүй байна.</p>
<p>СЗХ доорх мэдээллийг нийтэд мэдээлэх үүрэгтэй:</p> <p>Бүртгэсэн үнэт цаас болон түүний танилцуулга;</p>	<p>Зохицуулалт байхгүй. Үнэт цаас гаргагчид нь үнэт цаасны танилцуулгаа мэдээлэх асуудлыг өөрсдөө хариуцдаг.</p>	<p><u>Процедурын ялгаатай байдал:</u> Хөрөнгө оруулагчдын эрх, ашиг сонирхолд аливаа эрсдэл үүсгэхгүй байна.</p>
<p>Үнэт цаас гаргагчийн СЗХ-д ирүүлсэн тайлбар, тайлан, дүгнэлт;</p>	<p>Зохицуулалт байхгүй.</p>	<p><u>Процедурын ялгаатай байдал:</u> Хөрөнгө оруулагчдын эрх, ашиг сонирхолд аливаа эрсдэл үүсгэхгүй байна.</p>

Үнэт цаас гаргагчтай холбоотой мэдээлэл шаардах, нэхэмжлэл гаргах

<p>Дараах нөхцөл байдал үүссэн, эсвэл үүсч болзошгүй гэж</p>	<p>Зөрчилдөөнгүй. Үнэт цаасны зохицуулах байгууллагууд нь</p>	<p>Зөрчилдөөнгүй: Хөрөнгө оруулагчдын эрх, ашиг</p>
--	---	---

¹² Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, 55-р зүйл.

Бернее



0000105



<p>үзвэл СЗХ үнэт цаас гаргагч болон түүний холбогдох этгээдээс доорх мэдээллийг ирүүлэхийг шаардах эрхтэй:</p> <p>а) Бусдыг хууран мэхлэх, залилах, завших зэрэг хууль бус үйл ажиллагаа явуулсан буюу явуулж байгаа, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хохироосон;</p> <p>б) Хууран мэхлэх, залилах, завших болон бусад хууль бус зорилгоор компанийг үүсгэн байгуулсан;</p> <p>с) Компанийн үүсгэн байгуулагч, нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болон бусад эрх бүхий албан тушаалтан нь тухайн компани, түүний хөрөнгө оруулагчийг хууран мэхлэх, залилах, завших болон бусад хууль бус ажиллагаа явуулсан.</p>	<p>өөрсдийн харьяалал дахь үнэт цаас гаргагчдаас мэдээлэл шаардаж болно.</p>	<p>сонирхолд аливаа эрсдэл үүсгэхгүй байна.</p> 
--	--	---

Үнэт цаасны зах зээлд хориглох үйл ажиллагаа¹³

<p>Үнэт цаасны зах зээлд дараах үйл ажиллагааг хориглоно:</p> <p>Уг мэдээллийн улмаас ханш, арилжааны хэмжээ нь хэлбэлзэх үнэт цаас болон түүнд суурилсан санхүүгийн хэрэгслийн арилжаанд оролцох;</p>	<p>Зөрчилдөөнгүй.</p>	<p><u>Зөрчилдөөнгүй:</u> Хөрөнгө оруулагчдын эрх, ашиг сонирхолд аливаа эрсдэл үүсгэхгүй байна.</p>
<p>Уг мэдээллийг дотоод мэдээлэл гэдгийг мэдсэн эсэхээс үл хамааран ханш, арилжааны хэмжээ нь хэлбэлзэх үнэт цаас, түүнд суурилсан санхүүгийн хэрэгслийн арилжаанд оролцохыг бусдад санал болгох, ятгах;</p>	<p>Зөрчилдөөнгүй.</p>	<p><u>Зөрчилдөөнгүй:</u> Хөрөнгө оруулагчдын эрх, ашиг сонирхолд аливаа эрсдэл үүсгэхгүй байна.</p>

2018 03 12

¹³ Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, 76-81-р зүйл.

Баермее



0000146 RTTЭЭ 01



<p>Албан тушаал, ажил үүргийн хувьд мэдээллийг нээлттэй болгох үүрэг хүлээснээс бусад тохиолдолд бусдад дотоод мэдээллийг задруулах;</p>	<p>Зөрчилдөөнгүй.</p>	<p><u>Зөрчилдөөнгүй:</u> Хөрөнгө оруулагчдын эрх, ашиг сонирхолд аливаа эрсдэл үүсгэхгүй байна.</p>
<p>Үнэт цаасны зах зээлд хуурамч арилжаа хийх, үнэт цаасны үнэ ханшийг зохиомлоор тогтоох, үнэт цаасны зах зээлд оролцогч, харилцагчийг хууран мэхлэх замаар арилжаанд оролцуулах, эсхүл оролцуулахгүй байх болон бусад арга хэлбэрээр үнэт цаасны зах зээлийг урвуулан ашиглах.</p>	<p>Зөрчилдөөнгүй.</p>	<p><u>Зөрчилдөөнгүй:</u> Хөрөнгө оруулагчдын эрх, ашиг сонирхолд аливаа эрсдэл үүсгэхгүй.</p>

Хувьцаа худалдан авах үнийн санал гаргах буюу компани нэгдэх, нийлэх, худалдан авах хэлцлийг хувьцаа эзэмшигч батлах

<p>Монгол Улсын хуулиар хувьцаа эзэмшигчид өөрсдийн хувьцаагаа захиран зарцуулах буюу хувьцаа худалдан авах үнийн саналыг зөвшөөрөх эсэхээ шийдвэрлэх эрхтэй.</p> <p>Түүнчлэн Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд жижиг хувьцаа эзэмшигчдэд хувьцаагаа заавал худалдахыг ногдуулсан зохицуулалт байхгүй.</p>	<p>Зөрчилдөж байна.</p> <p>Хувьцаа худалдан авах үнийн санал гаргасан тохиолдолд хувьцаа эзэмшигчид тухайн саналыг зөвшөөрч өөрсдийн саналыг худалдах эсэхээ өөрсдөө шийддэг. Гэхдээ зарласан хувьцааны 90% буюу түүнээс дээш хувийг худалдан авах бол худалдан авч буй этгээд нь жижиг хувьцаа эзэмшигчдийг шахаж, үлдсэн хувьцааг худалдахыг албадаж болно. Компани нэгдэх, нийлэх, худалдан авах зарим томоохон хэлцлийг санал хураасан хувьцааны гуравны хоёрын баталснаар байгуулж болдог ба хэрвээ холбогдох этгээдийн хэлцэл бол жижиг хувьцаа эзэмшигчдээс зөвшөөрөл авдаг.</p>	<p><u>Анхаарвал зохих зөрчилдөөн:</u></p> <p>Канад улсын хуулиар томоохон хувьцаа эзэмшигчдэд жижиг хувьцаа эзэмшигчдийн хувьцааг албадан худалдах эрхийг олгосон байдаг бол Монгол Улсын хуулиар жижиг хувьцаа эзэмшигчдийг ийнхүү албадах боломжгүй юм.</p> <p>Хэдийгээр энэ нь эдгээр хоёр орны эрх зүйн тогтолцооны хувьд анхаарууштай ялгаа боловч Монгол Улсын давхар бүртгэлийн журамд "гадаад улсын арилжаа эрхлэх бүртгэлтэй хуулийн этгээдийн үнэт цаасаа анх бүртгүүлсэн, хуулийн этгээдийг харьяалах улс болон Монгол Улсын хууль тогтоомжийн зөрүүтэй байдал үүссэн тохиолдолд гадаад улсын үнэт цаасны зах зээлийн холбогдох..."</p>
---	---	--

2018.03.12

Баармаа

86

0000147
 СЭХ
 ОМ
 БҮГДЭМЖ
 ДҮРЭМ

		<p>хууль тогтоомж, дүрэм журмыг дагаж мөрдөнө¹⁴ хэмээн заасан байдгийг энд тэмдэглэе.</p> <p>Тиймээс, энэ тохиолдолд жижиг хувьцаа эзэмшигчдийг албадан хувьцаагаа худалдахыг дэмжсэн Канадын хууль тогтоомж болон практик үйлчилнэ.</p> <p>Хууль тогтоомжийн зохицуулалтын энэхүү зөрчилдөөнийг шийдвэрлэх хууль зүйн шийдэл байгаа хэдий ч одоогийн болон ирээдүйн хөрөнгө оруулагчид энэхүү зөрчилдөөнтэй байдал болон давуу эрхтэй үйлчлэх бүхий эрх зүйн зохицуулалтын талаар мэддэг байх нь чухал юм.</p>
--	--	--

2.4. Нийтэд санал болгох үнэт цаасны тухай

2.4.1. Хөрөнгө оруулалтын боломжийн талаар

Хөрөнгө оруулагчид энэхүү үнэт цаасанд хөрөнгө оруулснаар хувьцааны ханшийн өсөлтөөс ашиг олох нь уламжлалт арга юм. Харин компанийн геологи хайгуулын судалгааны төслийн үр дүн нь компанийн зах зээлийн ханшийг нэмэгдүүлснээр хөрөнгө оруулагчдад үнэ цэнийг бий болгох хамгийн уламжлалт арга билээ.

Ирэх 3 жилийн хугацаанд Компани эрдэсийн нөөцөө нэмэгдүүлэх замаар геологи хайгуулын эрсдэлийг багасгаж, ашиглалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авснаар хөрөнгө оруулагчдад нэмүү үнэ цэнийг бий болгохоор зорин ажиллаж байна.

Өнөөгийн байдлаар Компанийн геологи хайгуулын үр дүнгээс үзвэл Баян Хөндий болон Алтан Нар ордууд нь ил аргаар олборлож болохуйц, өндөр эрдэсийн агуулга бүхий хүдрийн нөөцтэй байх магадлал өндөр байна. 2018 болон 2019 онуудад Компани ашиглалтын үйл ажиллагаанд шаардагдах бүх тусгай зөвшөөрлүүдийг авсанаар 2020

¹⁴ Давхар бүртгэлийн журам, 1.5-р зүйл, 2018.

Басрмаа

Андеррантер
 Брокер, дилерийн
 "БНДСЕК"
 УСК ХТ
 87
 ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛӨӨДИЙГ

2018 03 12

МОНГОЛ УЛСЫН ХАЙГУУЛЫН САЛБАРТ
БҮРТГЭВ
1000108

СЭХ
БҮРТГЭВ
№01

оноос уулын үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажил эхлүүлэх боломж үүсэх юм. Ингэсэн тохиолдолд компани уурхайн ашиглалтын орлого болон ашгаас хөрөнгө оруулагчдад ногдол ашиг хүртэх боломжийг бий болгож болох ба цаашид тухайн бүс нутагт шинэ ордуудыг илрүүлэх боломжтой гэж үзэж байна.

Баян Хөндий болон Алтан Нар ордуудаас гадна компанийн Хөндий болон Цэнхэр Номин тусгай зөвшөөрлийн талбайд 12 ширхэг эрдэсийн илрэл байгаа бөгөөд эдгээр нь мөн алт болон полиметаллын орд байх магадлалтай юм. Хэрэв дээр дурдсанчлан болон түүнтэй ижил бусад илрэлүүд дээр хангалттай хэмжээний эрдэсийн нөөц тогтоосон тохиолдолд, энэ нь компанийн зах зээлийн үнэлгээг өсгөх чухал хүчин зүйл юм.

• *Хайгуулын үйл ажиллагаанаас ашиглалт руу чиглэх нь*

Компанийн үйл ажиллагаа одоогоор хайгуулын шатандаа явж буй хэдий ч цаашид ашиглалт, олборлолтын шатруу шилжих боломжтой шинэ алтны бүсийг нээн илрүүлсэн нь ирээдүйд хөрөнгө оруулагчдад үнэ цэнийг бий болгоно гэж үзэж байна. Одоогийн голлох төслүүд болох Баян Хөндий, Алтан Нар төслүүд нь эрдэс баялгийн нөөц тооцоолоход хэмжээ болон чанарын хувьд өсөн нэмэгдэх боломжтой.

Баян Хөндий хайгуулын бүс дэх өрөмдлөг, техникийн судалгааны үр дүнгээс харахад гадаргад ойр, өндөр агуулга бүхий хүдрийн биет байгаа ба уламжлалт химийн уусмалын аргаар олборлох боломжтой (металл авалтын хэмжээ 92%-99%). Мөн Алтан Нар төслийн хүрээнд боловсруулсан NI 43-101 эрдсийн нөөцийн хэмжээ дахин өсөх боломжтой хэмээн Компани үзэж байна. 2018 онд багтаан Компани нь Баян Хөндий болон Алтан Нар төслүүдийн эрдсийн нөөцийг тооцоолох төлөвлөгөөтэй ажиллана.

Компанийн удирдлага нь Монгол Улсын хайгуулын салбарт 20 гаруй жил ажилласан, Монгол Улсын хууль, эрх зүй, байгаль орчин болон бизнесийн нөхцөл байдлын талаар өргөн мэдлэгтэй хамт олон юм. Баян Хөндий болон Алтан Нар төслүүдийн 2018 оны өрөмдлөгийн үр дүн болон эрдсийн нөөцийн тооцоолол нь хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулалтын үнэ цэнэд эерэгээр нөлөөлөх боломжтой.

• *Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан шинэ алтны ордын нээлтэд хөрөнгө оруулах боломж*

МХБ-д бүртгэлтэй нийт 218 компанийн дунджаар 7% нь уул уурхайн компаниуд байна. Гэвч энэхүү уул уурхайн компаниудын дийлэнх нь төрийн эзэмшлийн нүүрс олборлолтын компаниуд байна.

Басуу

МОНГОЛ УЛСЫН ХАЙГУУЛЫН САЛБАРТ
Андрейтер
Брокер, дилерийн
"ИДИСА"
ҮЗК
88
11520504

2018 03 12 J

1000119

01

СЗХ

адг

БҮГДЭВ

№ 01

Энэхүү бүртгэл нь МХБ-д бүртгэгдэж буй анхны давхар бүртгэл бөгөөд Компанид Монгол Улсын хөрөнгийн зах зээлд олон улсын стандартын дагуу, үйл ажиллагааг эрхлэх нөхцөлийг бий болгон, хөрөнгө оруулагчдад шинэ хөрөнгө оруулалтын боломжийг олгож байна. Хэдийгээр хайгуулын үйл ажиллагаа нь эрсдэл өндөр боловч Компанийн Баян Хөндий болон Алтан Нар төсөл нь газрын гадаргад ойр, өндөр агууламж бүхий орд болох боломжтой хүдрийн биет байгаа нь энэхүү эрсдэлийг бууруулах магадлалтай. Компани нь цаашид үргэлжлүүлэн ашигт малтмалын хайгуулын ажлуудыг хийх төлөвлөгөөтэй байгаа нь хөрөнгө оруулагчид, засаг захиргааны байгууллагууд болон орон нутгийн үйл ажиллагаанд үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилготой.

- *Алтны эрэлтийн үзүүлэлт Монгол Улсад сайжрах хандлагатай*

Монгол Банкны алт худалдан авалт 2017 онд түүхэн дээд хэмжээнд хүрсэн. Тушаах алтны хэмжээг нэмэгдүүлэх, алт худалдан авах үнийг дэлхийн зах зээлийн үнэтэй уялдуулан тогтоох үүднээс Монгол банкнаас “Алт” нэртэй хөтөлбөрийг эхлүүлсэн. 2016 оноос 2020 он хүртэл Монгол Улсын Засгийн газар “Алт-2” хөтөлбөрийг 2 үе шатанд хуваан, хэрэгжүүлж эхэлсэн. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд алтны эрэл хайгуулыг нэмэгдүүлж, Монгол Улсын алтны нөөцийг 150 тонн хүртэл нэмэгдүүлэх, алтны олборлолтын хэмжээг жилд 2-3 тонноор өсгөх төлөвлөгөөтэй байна.

Дотоодын эрэлтээс гадна төслийн талбай нь дэлхийн хамгийн том алтны олборлогч болон хоёрдогч том хэрэглэгч улстай ойр байрладаг. Хятад улс нь дэлхийн алтны хэрэглээний гуравны нэгийг эзэлдэг бөгөөд хамгийн том олборлогч улс юм. Олборлолтын өртөг өсч, алтны ордуудын дундаж агууламжийн хэмжээ буурч байгаа тул цаашид урт хугацаанд алтны эрэлт ба үнэлгээ өсөх хандлагатай байна.

2.4.2. Нийтэд санал болгох хувьцааны тоо хэмжээ

Компанийн Төлөөлөн Удирдан Зөвлөлийн 2018 оны 02 дугаар сарын 28 өдрийн тогтоолын дагуу МХБ-д 4,000,000 ширхэг хүртэлх энгийн хувьцаа гаргана. Нийт санал болгох хувьцааны тоо нь олон нийтэд арилжиж, босгох хөрөнгө болох 1.2 сая канад доллартай тэнцэх хэмжээний Энгийн Хувьцаа байна. 2018 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар энгийн хувьцаа 146,400,586 ширхэг байгаа ба Компани МХБ-д нийт энгийн хувьцааны 2.7 хүртэлх %-ийг бүртгүүлнэ.


2.4.3. Хувьцааны үнэ тогтоох тухай

Компанийн ТУЗ-ийн шийдвэрт зааснаар МХБ-ээр дамжуулан олон нийтэд санал болгох хувьцааны үнийг СЗХ-ны шийдвэр гарахаас өмнө Компани тогтооно. Энэхүү үнэ нь

Бүрмисе



2018-03-12



Торонтогийн Хөрөнгийн Биржид арилжаалагдаж буй Компанийн хувьцааны ханшийн 10 хоногийн жигнэсэн дундаж үнээс 10%-ийн хөнгөлөлттэй байна.



Компанийн гаргаж буй үнэт цаасыг 2018 оны 1 сарын 31-нд байгуулсан Андеррайтерийн гэрээгээр (2018 оны 02 сарын 26, 2018 оны 03 сарын 09-нд нэмэлт өөрчлөлт оруулсан) firm commitment нөхцөлөөр санал болгох ба нийтэд худалдагдаагүй хувьцааг худалдан авах үүрэг хүлээсэн болно. Компанийн үнэт цаасыг бүртгэсэн СЗХ-ны шийдвэр гарсан өдрөөс хойш 42 өдрийн дотор 150,000 хүртэлх хувьцааг санал болгох үнээр нэр заан эзэмшүүлэх /СЗХ-ны шийдвэрээр/, үлдэх хувьцааг нийтэд санал болгон арилжаалах ажиллагааг зохион байгуулна.

2.4.4. Анхдагч зах зээлд арилжаалах аргачлал

Компани нь нийт энгийн хувьцааны дунджаар 2.7%-иас бага, 4,000,000 ширхэг хүртэлх энгийн хувьцааг МХБ-ээр дамжуулан ТОГТООСОН ҮНИЙН АРГААР санал болгон арилжаална.

График 2-1 Анхдагч зах зээлд байршуулах



График 2-2 Монгол Улсын зах зээлд байршуулах явц



2018-03-12

МХБ-д хувьцаа арилжаалах зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага

- Компани МХБ болон СЗХ-д үнэт цаасаа бүртгүүлэх хүсэлт гаргана

Хувьцааг арилжих нөхцөл



Басеие

000011133 01

- Хувьцааг МХБ-ийн “Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам”-ын гуравдугаар зүйлд заасны дагуу тогтоосон үнийн аргаар санал болгон арилжина.
- Хувьцааг санал болгох явцад худалдан авах эрэлт давсан нөхцөлд захиалга бүрийн (захиалгын гэрээ) 2,500,000 хүртэлх төгрөгийн худалдан авах захиалгыг бүрэн биелүүлэн үлдэх хувьцааг 2,500,000 төгрөгөөс илүү гарсан захиалгын дүнтэй харьцуулан хувь тэнцүүлэн арилжих аргыг баримтална. Хувьцааны захиалгын тоо (захиалгын гэрээ) хэтэрснээс үүдэн тогтоосон босго дүнгээр захиалгыг биелүүлэх боломжгүй нөхцөл үүссэн тохиолдол бүрд босго үнийн дүнг 50 хүртэлх хувиар бууруулан шинэчлэн тогтооно. Ингэхдээ үнэт цаас гаргагч болон андеррайтер нь МХБ-тэй зөвшилцөнө.
- Үнэт цаас гаргагч нь МХБ-ийн хувьцааны бүртгэлийн III ангилалд бүртгэгдэж байгаа бөгөөд МХБ-ийн “Бүртгэлийн журам”-ын 13.1.2, 13.1.3-т “...III ангиллын үнэт цаасыг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.19-д заасан мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэгчдийн хүрээнд санал болгох, бусад этгээд худалдан авах тохиолдолд тухайн үнэт цаасыг мэргэжлийн хөрөнгө оруулагчдад санал болгосон болохыг ойлгож шийдвэрээ гаргасан тухай үйлчлүүлж буй брокерийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагад бичгээр мэдэгдэн” худалдан авч болохоор зохицуулсан.
Иймд үнэт цаасны компаниуд нь мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэгч биш харилцагчаас хувьцаа худалдан авах захиалга авахдаа МХБ-ийн “Бүртгэлийн журам”-ын 13.1.3-т заасан “тухайн үнэт цаасыг мэргэжлийн хөрөнгө оруулагчдад санал болгосон болохыг ойлгож шийдвэрээ гаргасан тухай” мэдэгдлийг бичгээр авсан байна.
- Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан уг нөхцөл байдал, журмын зохицуулалтыг танилцуулаагүй, бичгээр мэдэгдэл аваагүйгээс харилцагчдад учирсан хохирлыг үнэт цаас гаргагч болон андеррайтер хариуцахгүй.

Хувьцааг олон нийтэд танилцуулах

- Байгууллагын болон маркетингийн стратеги боловсруулж, Үнэт цаасны танилцуулга болон танилцуулгын хураангуйг боломжит хөрөнгө оруулагчдад танилцуулах.
- Roadshow: Үнэт цаасны танилцуулга (roadshow) зохион байгуулах төлөвлөгөө гаргаж, боломжит хөрөнгө оруулагчидтай уулзаж, танилцуулах.
- Санал болгож буй хувьцаатай холбоотой мэдээллийг олон нийтэд түгээх.

ОН САБ ӨЛӨГ
БҮРТГЭВ

2018-03-12

Баярши

УЛААНБААТАР ХУТ
МХБ-ийн гшдүүн
Андеррайтер
Брокер, дилерийн
компани
"БНДДСК"
ҮШКХ
1115205-173



Захиалга хүлээн авах, биелүүлэх

- СЗХ-ны зөвшөөрлийн дагуу МХБ-тэй хамтран захиалга хүлээн авч эхлэх болон хаах хугацааг тогтоох,
- ҮЦК-иудад арилжааны талаарх зааварчилгаа, мэдээлэл өгөх,
- ҮЦК-иуд худалдан авах захиалгыг биржийн программд шивэх,
- Захиалга хаагдсанаар хувьцаа худалдан авах захиалгын дүнг нэгтгэн МХБ-тэй хамтран нийлүүлэх аргачлалыг тогтох. Хувьцаа худалдан авах захиалга нийлүүлэх дүнгээс илүү гараагүй нөхцөлд захиалгыг шууд биелүүлэн үлдэх хувьцааг андеррайтерууд худалдан авах, илүү гарсан нөхцөлд хувь тэнцүүлэх аргыг хэрэглэнэ.
- Сонгосон аргачлалын дагуу хувьцаа худалдан авах захиалгыг СЗХ-ноос зөвшөөрөл авснаар биелүүлнэ.

Үнэт цаас худалдан авах сонирхолтой хөрөнгө оруулагчид:

- МХБ-д бүртгэлтэй ҮЦК-иудаас сонгож, үнэт цаасны данс нээлгэнэ.
- Үнэт цаасны дансанд дараах зааврын дагуу хувьцаа худалдан авахад шаардагдах мөнгө байршуулна.

Хүлээн авагч банк: Арилжаа төлбөр тооцоо банк

Хүлээн авах данс: XXXX (ҮЦК-ийн код) XXXXXXXXX (Харилцагчийн үнэт цаасны дансны дугаар)

Хүлээн авагч: (данс эзэмшигчийн нэр)

Утга: Эрдэнэ Ресурс хувьцаа худалдан авах мөнгө

- Сонгон үйлчлүүлж буй ҮЦК-даа хувьцаа худалдан авах захиалга өгөх, гэрээ байгуулах

2.5. Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт

2.5.1. 2018 оны Техникийн хөтөлбөр болон төсөв

Компанийн алсын хараа нь Монгол Улсад үнэт болон суурь металлын хайгуул, төслийн хөгжүүлэлтээр үйл ажиллагаа эрхлэхэд оршдог.

Компани нь өдгөө “Хөндий” хэмээн нэрлэгдэх болсон алтны бүлэг ордуудыг агуулсан байх магадлалтай геологийн бүсийг нээж хоёр ч хайгуулын төсөл нь эцсийн шатанд орсон. Энэхүү хайгуул, үнэлгээний үр дүнгээс харахад: хэмжээ болон агуулгын хувьд цаашид олборлолт хийх боломж өндөр юм. Хүдрийн биетүүдийн байрлалаас хамааран томоохон хэмжээний алтны бүлэг ордууд байх боломжтой гэж Компани үзэж байна. Үүнд Баян



Б. Сергеев

2018 03 12 17



Хөндий, Алтан Нар болон бусад анхан шатны нээлтүүд болон зэргэлдээ хайгуулын талбай багтана. Энэхүү талбайн хэмжээ болон агуулгыг тодорхойлох нь Компанийн ойрын хугацааны зорилт болоод байна.

Дараагийн үе шатанд төслүүдийн боломжит эрдсийн нөөцийг тогтоох ажил хийгдэнэ. Эрдсийн нөөцийг тогтоосноор хүдрийн биетийн төрөл болон олборлолтын арга барилд тулгуурлан урьдчилсан эдийн засгийн тооцооллыг гаргах боломжтой. Урьдчилсан эдийн засгийн тооцоололд тулгуурлан нарийвчилсан үнэлгээнүүд хийгдэх бөгөөд энэ нь цаашид орд болон боловсруулах үйлдвэрийн байгууламж, олборлолтын үйл ажиллагааг эрхлэх ажлын эхлэл болно. 2018 болон 2019 онуудад нөөц тогтоолт болон эдийн засгийн тооцоололтой хамт ашиглалтын тусгай зөвшөөрөл хүсэх ажлууд хийгдэнэ.

2018 Техникийн Хөтөлбөр

2018 оны техникийн хөтөлбөрт дараах ажлууд тусгагдах төлөвлөгөөтэй байна. Үүнд:

- *Геологи хайгуулын ажил*

Алтны хүдэржилт бүхий Хөндий болон зэсийн хүдэржилтийн хэтийн төлөв бүхий Улаан хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайнуудад геологийн газарзүйн зураглал, геохими, геофизикийн судалгаанууд болон суваг малталтын ажлууд хийгдэнэ. Дээрх судалгааны ажлуудыг өрөмдлөгийн хөтөлбөрөөс урьтаж 2018 оны 1 дүгээр улирлын сүүлээр хийхээр төлөвлөж байна.

- *Хайгуулын өрөмдлөг*

Компани нь 3 үе шатад хуваагдсан 12,000 метрийн өрмийн хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

1-р үе шат: 2 дугаар улирлын эхэнд Баян Хөндий төслийн талбайд 5400 метрийн (дунджаар 30 цоонг) өрөмдлөгийн ажлыг хийж, 2 дугаар улирлын дунд үед дуусгах төлөвлөгөөтэй байна. Энэхүү хөтөлбөрийн гол зорилго нь хүдрийн биетийн загварчлалд ашиглах агуулгын хэмжээ өндөр бүсүүдийн хэмжээг нэмэгдүүлэх, бодит агуулгад нөлөөлөх өндөр агуулгыг турших зэрэг юм. Мөн тэлэх боломжтой талбайд нарийвчилсан өрөмдлөгүүдийг хийнэ.

2-р үе шат: 2 дугаар улирлын дундаас Хөндий бүсэд Алтан Сум дахь өндөр агуулга бүхий талбай, Хойд Хөндий болон Улаан талбайд дунджаар 3000 метр (дунджаар 15 цоонг) өрмийн дээж авна.

2018-03-12

Бсермее





3-р үе шат: Баян Хөндийн бодит нөөцийг тэлж болохуйц эсэхийг тодорхойлох ажлын хүрээнд шинээр тодорхойлсон цэгүүдийг өрөмдөж шалгана.



- *Техникийн судалгаанууд*

Нөөцийн тооцоолол:

2018 оны 1 дүгээр улирлаас эхлэн Нөөцийн тооцооллын судалгаа эхлэнэ. Энэ ажлын хүрээнд: Алтан Нар төслийн “Нээлтийн Бүс” дэх агуулга өндөртэй цөмийг багтааж, мөн нэмэлт 50 өрмийн цооногийн үр дүнг багтаасан нөөцийн дахин тооцооллийг хийнэ. Баян Хөндий төслийн 1-р үе шат дахь өрөмдлөгийн ажлыг дуусгаснаар 2018 оны 2 дугаар улиралд энэхүү төслийн урьдчилсан нөөцийн тооцооллыг хийх боломжтой.

Техникийн загварчлал ба тусгай зөвшөөрөл авахад бэлдэх:

Төслийн эдийн засгийн тооцоолол болон тусгай зөвшөөрөл авах үйл явцыг дэмжих гол судалгаанууд болох: Гидрогеологи, ус, геотехник, байгаль орчин, нийгэм-эдийн засгийн нөлөөлөл болон уурхайн загварын судалгаануудыг 2018 оны турш хийнэ.

Тусгай зөвшөөрөл авах үйл явц:

2018 оны 3 болон 4 дүгээр улиралд Баян Хөндий болон Алтан Нар төслүүдийн нөөцийг Эрдэс Баялгийн Зөвлөлд бүртгүүлэх болон ашиглалтын тусгай зөвшөөрөл авах үйл ажиллагааг эхлүүлэхээр төлөвлөж байна.

Техник эдийн засгийн үндэслэл ба зөвшөөрөл:


2019 онд зөвшөөрөл авах үйл явц болон техник эдийн засгийн үндэслэлийн судалгаанууд дуусч, 2020 онд уулын үйлдвэрийн байгууламжуудын барилгын ажил эхлэнэ.

- *2018 оны төсөв*

Компани 2004 онд ТХБ-д бүртгэгдсэн хугацаанаас хойш өнөөг хүртэл нийт 40 сая орчим Канад долларыг татан төвлөрүүлж, Монголын хайгуулын төслүүддээ зарцуулсан. Компани 2015 оноос Баян Хөндийн төслийг нээн илрүүлснээр хувьцааны ханш чангарч хөрөнгийн захаас хөрөнгө татах чадамж харьцангуй сайжирсан ба цаашид ч Баян Хөндий ба Алтан Нар төслүүдийг хөгжүүлэхэд санхүүжилтийн ихэнх хэсгийг хөрөнгийн зах зээлд хувьцаа борлуулах замаар болон уурхай хөгжүүлэх шатанд өрийн хэрэгслээр дамжуулан татан төвлөрүүлнэ хэмээн төлөвлөж байна.

2018 03 12

2018 оны 2 сарын 28 өдрийн байдлаар компанийн эргэлтийн хөрөнгө нь 2.4 сая канад доллар байна. Өнөөгийн эргэлтийн хөрөнгө нь Компанийн 2 дугаар улиралд төсөвлөсөн зардлуудад хангалттай гэж үзэж байна. 2018 оны 2 болон 3 дугаар улиралд компани



Басунаа



хайгуулын зардлын дийлэнхийг Торонтогийн Хөрөнгийн Бирж дээр мөн тодорхой хэмжээг МХБ дээрээс татан төвлөрүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна.

2018 оны 12 сарын 31-ээр дуусгавар болох техникийн хөтөлбөрийн зарцуулалтыг доорх хүснэгтээс харна уу.

Хүснэгт 2-3 2018 оны төсөв (канад доллар)

	2018
Удирдлагын зардал	
Хөрөнгийн зарцуулалт	6 000
Удирдлагын үйлчилгээ	724 433
Хууль болон аудит	152 900
Томилолтын зардал	140 000
Хурал, чуулга уулзалтууд	259 272
Зохицуулагч байгууллагуудад	250 000
Оффис болон бусад зардлууд	124 645
Монгол дахь удирдлагын зардлууд	446 834
Morfen удирдлагын авлага	(252 799)
Нийт	1 851 285
Хайгуулын зардал	
Өрөмдлөг	1 529 200
Дээжний шинжилгээ	417 242
Нийт цалин	1 464 182
Туслан гүйцэтгэгч	130 982
Техникийн гэрээний үйлчилгээ	1 646 000
Геотехник	30 510
Геофизик	132 624
Хээрийн ангид	395 078
Хээрийн харилцаа холбоо	5 000
Хээрийн ложистик дэмжлэг	151 351
Томилолт	129 775
Тусгай зөвшөөрлийн төлбөр	105 290
Бусад	22 225
Хайгуулын зардлын дүн	6 159 459
Үндсэн хөрөнгө	6 000
Нийт зардал	8 016 744



Хүснэгт 2-4 2018 оны зардал (төслөөр)

Төслүүд	2018
Хөвийн Хар / Зуун Мод	86 360
Алтан Нар	1 389 717
Баян Хөндий	3 673 677
Алтан Сум	585 435
Лидер - Улаан	408 010
Теск	16 261
Нийт	6 159 459

Баярмун



2018-03-12



2.5.2 Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт

Компани нь татан төвлөрүүлэх хөрөнгийг 2018 онд хийх хайгуулын өрөмдлөгийн ажилд зарцуулах төлөвлөгөөтэй байна. МХБ-ээс татан төвлөрүүлэх хөрөнгө болон компанийн эргэлтийн хөрөнгөөс гадна Компани нь 2018 оны төсөвлөсөн зардлыг үнэт цаас гарган санхүүжүүлэх төлөвлөгөөтэй байна.

2.6. Санхүүгийн таамаглал

Энэхүү үнэт цаасны танилцуулгын хүрээнд Санхүүгийн тайлангийн таамаглал, хөрөнгө оруулалтын өгөөж болон мөнгөн гүйлгээний төсөв хийгдээгүй болно. Компани нь хайгуул, хөгжүүлэлтийн үйл ажиллагаа эрхэлдэг тул тогтвортой орлогын эх үүсвэргүй, хайгуулын төслүүд болон судалгааны ажлуудыг үнэт цаас гарган санхүүжүүлдэг. Энэхүү төслүүдийн амжилттай байдал нь Компанийн үнэлгээ болон хувьцаа эзэмшигчдийн үнэ цэнэд нөлөөлдөг. Компани нь олборлолтын үе шат хүртэл хайгуулын үр дүнг судалж, шаардлагатай тусгай зөвшөөрөл болон зөвшөөрлийг авах үйл ажиллагааг эрхлэн хөрөнгө оруулагчдын үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилготой ажиллаж байна.

2018 - 03 12

Басерие





ГУРАВ. ЭРСДЭЛИЙН ХҮЧИН ЗҮЙЛС БА УДИРДЛАГА

Компанийн бизнесийн шинж чанар, хөгжлийн өнөөгийн түвшингээс хамаараад тус Компанийн үнэт цаасанд хөрөнгө оруулалт хийх нь эрсдэлтэй байх магадлалтай. Компанийн үнэт цаасыг худалдан авахдаа дараах хүчин зүйлсийг харгалзан үзэх шаардлагатай.

3.1. Эрсдэлийн хүчин зүйлс

3.1.1. Эрдсийн хайгуул, ашиглалтын салбарын эрсдэл

Компанийн эрдсийн шинж чанар нь хайгуулын үр дүнгээс ихээхэн хамаарна. Хайгуулын салбар нь зардал өндөртэйгөөс гадна туршлага, мэдлэг болон судалгаа тооцооноос үл хамаарах эрсдэл үүсэх магадлалтай салбар юм. Олборлолтын үе шатаас илүүтэйгээр хайгуулын үе шатанд энэхүү эрсдэл өндөр байдаг.


Эрдсийн нөөц, ордуудыг олж илрүүлэх үйл явц нь хэд хэдэн хүчин зүйлээс хамаардаг бөгөөд үүний нэг нь хайгуулын ажилд оролцож буй мэргэжилтнүүдийн техникийн ур чадвар юм. Түүнчлэн, нэгэнт илрүүлсэн эрдсийн ордын ашиглалтын хугацаа нь тухайн ордын хэмжээ, агуулга, дэд бүтцэд ойр байдал, металлын үнэ, төр засгийн зохицуулалт, ялангуяа роялтигийн зохицуулалт, зөвшөөрөгдөх үйлдвэрлэл, эрдэс баялгийн импорт, экспорт, байгаль орчны хамгаалалтын зохицуулалт зэрэг голлох хүчин зүйлүүдээс хамаарна. Мөн уул уурхайн үйл ажиллагааны төрлөөс шалтгаалаад хүдрийн биетийг илрүүлсэн өрөмдлөгийн эхний үе шатаас олборлолт эхлүүлэх хүртэл урт хугацаа ордог. Дээр дурдсан ихэнх хүчин зүйл нь Компанийн хяналтаас давсан хүчин зүйлс юм.

3.1.2. Хөрвөх чадвар, санхүүжилтийн эрсдэл


Компанийн эзэмшиж буй хайгуулын төслүүдийн хайгуул, хөгжүүлэлтийн үйл ажиллагаа нь компанийн хамтын хөрөнгө оруулалт, өрийн санхүүжилт болон үнэт цаасны санхүүжилт татах чадвараас шалтгаална. Хайгуулын компаниуд хэрэгцээтэй байгаа санхүүжилтаа шаардлагатай хугацаанд босгох баталгаа байхгүй.

Үнэт болон суурь металлын зах зээл хэлбэлзэл өндөртэй байдаг тул өрийн санхүүжилт, аль эсвэл хөрөнгийн санхүүжилтийг компанид таатай нөхцөлөөр олох нь зарим тохиолдолд хүндрэлтэй. Мөн компанийн үйл ажиллагаа явуулж буй зах зээл, улс төрийн байдлаас шалтгаалан өрийн санхүүжилт авах нь бэрхшээлтэй тул Компани үйл

Басермеа



2018 -- 03 -- 12



ажиллагаа, хайгуулын төлөвлөгөөг хойшлуулах, тусгай зөвшөөрөл болон буцаан хураалгах зэрэг эрсдлүүд гарах магадлалтай.

3.1.3. Монгол Улсын хууль, эрх зүйн орчны эрсдэл

Монгол Улс 1990-ээд оноос төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцооноос зах зээлийн эдийн засаг бүхий ардчилсан тогтолцоонд шилжсэн. Энэхүү шилжилтийн хүрээнд ихээхэн ахиц дэвшил гарсан хэдий ч хууль, эрх зүйн орчин болон хуулийн үйлчлэлийн хүрээнд эрсдэл байсаар байна. Хууль тогтоомж, дүрэм журмууд батлагдан гарч буй боловч хэрэгжилт дээр хязгаарлалт байсаар байна. Түүнээс гадна төр, төрийн албаны хүнд суртал, авилгын асуудал ихээр байгаа нь хууль эрх зүй, түүний хэрэгжилтэнд тодорхой хэмжээгээр нөлөөлсөөр байна. Уг нөхцөл байдал нь удаанаар боловч аажмаар өөрчлөгдөж байгаа нь эерэг үр дүн юм.

Канад, Монгол Улсын хооронд 2016 оны 9 дүгээр сарын 8-нд Монгол Улсад хөрөнгө оруулалт хийх Канадын хөрөнгө оруулагчдад илүү ил тод, тодорхой зохицуулалтыг бий болгох Канад-Монголын Гадаадын Хөрөнгө Оруулалтыг Дэмжих Гэрээг (ГХОДГ) байгуулсан. Канадын Олон улсын худалдааны сайд Франсуа-Филиппе Шампане 2017 оны 03 дугаар сарын 7-нд Гэрээ хүчин төгөлдөр болсныг албан ёсоор мэдэгдсэн.

Монгол Улсад уул уурхайн хайгуул, ашиглалт, хөгжүүлэлтийн үйл ажиллагаа эрхэлж буй компаниудад засгийн газар болон улс төр, тэдгээрийн хяналтаас үүдэлтэй нөлөөллүүд бий болдог нь эрсдэл юм.

Монгол улс болон Канад улсын хууль эрх зүйн ялгаатай байдлаас үүдэн хувьцаа худалдан авах, үнийн санал гаргах буюу компани нэгдэх, нийлэх, худалдан авах хэлцэл гарсан үед Канад улсын хууль тогтоомжийн дагуу зарласан хувьцааны 90% буюу түүнээс дээш хувийг худалдан авах бол худалдан авч буй этгээд нь жижиг хувьцаа эзэмшигчдийн хувьцааг худалдахыг албадах эрхтэй.

Компани нэгдэх, нийлэх, худалдан авах зарим томоохон хэлцлийг санал хураасан хувьцааны гуравны хоёрын баталсанаар байгуулж болдог ба хэрвээ харилцан хамааралтай этгээдийн хэлцэл бол жижиг хувьцаа эзэмшигчдээс зөвшөөрөл авна.


3.1.4. Тусгай зөвшөөрөл, түрээс, зөвшөөрлийн эрсдэл

Компанийн хайгуул ашиглалтын үйл ажиллагаа явуулах эрх нь хүчин төгөлдөр байгаа боловч энэхүү эрх нь цуцлагдах, өөрчлөгдөхгүй гэсэн баталгаа байхгүй. Мөн гуравдагч талын маргаан, шаардлагаар компанийн эрхүүдэд эрсдэл үүсэх магадлалтай.

Баерин



2018 03 12 Э



Компани хайгуулын тусгай зөвшөөрлөө тухай бүрт сунгуулж, жилийн төлбөрийг төлдөг. Сунгуулах үйл явц нь хэдийгээр өндөр эрсдэлтэй биш боловч зарим тохиолдолд шинэ нөхцөл, болзлууд нэмэгдэх эрсдэл гарч болзошгүй.

Компанийн бизнесийн үйл ажиллагааны зорилго, зорилт ч мөн ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшихтэй холбоотой зардлаас болж хойшилж болно. Мөн Монгол Улсад ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр байнга нэмэгдсээр ирсэн нь нэг төрлийн эрсдэл болж байна. Компани ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг сунгуулах, төлбөр төлөх хугацаа, хайгуулын үр дүн болон холбогдох судалгаанд тулгуурлан зарим хайгуулын тусгай зөвшөөрлөө цуцлах зэрэг асуудалд тогтмол үнэлэлт дүгнэлт хийх шаардлагатай.


3.1.5. Дэд бүтэцтэй холбоотой эрсдэл

Компанийн Монгол дахь хайгуулын талбай нь цахилгаан, ус, байр, хүнс, тээвэр зэрэг үндсэн дэд бүтэцгүй, алслагдмал байршилд байрладаг. Компани ашиглалтын үйл ажиллагаагаа эхлүүлэхээс өмнө шаардлагатай хүний нөөц бүрдүүлж, хайгуулын дэд бүтэц буюу байгууламжуудыг байгуулах шаардлагатай болно. Дотооддоо бэлтгэгдсэн боловсон хүчин дутмаг тул Компани гадны мэргэжилтнүүдийг Монголд авчирч ажиллуулах шаардлага гардаг. Компанийн Монгол дахь хайгуулын талбай байрлаж буй алслагдмал газруудад үйл ажиллагаа явуулахад шаардагдах байгууламжийг бий болгох, бүрдүүлэх шаардлагатай. Тохирох зохицуулалтыг хийж чадаагүйгээс Компанийн хайгуулын хөтөлбөрийн гүйцэтгэл саатаж, Компани тавьсан зорилгодоо хүрэхэд саад учрах эрсдэлтэй. Компанийн Монгол дахь ашигт малтмалын талбайнууд нь алслагдмал оршдогоос олборлолт эхлэхээс өмнө цахилгаан, ус, үйлдвэр, тээврийн дэд бүтцийн эх үүсвэрийг барьж байгуулах шаардлагатай болж байгаа нь Компанийн олборлох үйл ажиллагаанд ч нөлөөлөх магадлалтай. Ийм эх үүсвэр байхгүй байгаа нь олборлолтын боломжит байдалд сөргөөр нөлөөлөх төдийгүй Компанийн хувьд шаардлагатай санхүүжилтийг зохицуулах, хүрэлцэхүйц хангамж, төвийн болон орон нутгийн засаг захиргаанаас шаардлагатай зөвшөөрлүүдийг авах хэрэгцээ үүсэх бөгөөд эдгээрийн алинд нь ч баталгаа гаргах боломжгүй юм.

2018.03.12

3.1.6. Үл даатгагдах эрсдэлүүд

Компани нь даатгалын хураамжийн зардал, эсвэл дотооддоо тогтоосон хязгаараас давсан хэмжээ болон өөр бусад шалтгааны улмаас даатгуулах боломжгүй, мөн даатгуулахгүй байхаар шийдвэрлэснээс аливаа гэнэтийн осол, аюулд өртөх эрсдэл үүсэх боломжтой.



Басриг



Даатгуулаагүйн улмаас үүсэх хариуцлага нь Компанийн санхүүгийн байдалд материаллаг сөрөг нөлөө үзүүлж болно.



3.1.7. Ашиг сонирхлын зөрчил

Компанийн тодорхой захирлууд болон албан тушаалтнууд нь ашигт малтмалын өөр бусад компанийн захирал, албан тушаалтан байх эсвэл тодорхой тооны хувьцаа эзэмшигч байх боломжтой бөгөөд Компанийн гэрээ хэлэлцээр хийсэн, хамтран ажилладаг бусад аж ахуйн нэгжүүдийн хооронд ашиг сонирхлын зөрчил үүсч болзошгүй. Мөн бусад компаниуд ашигт малтмалын орд эзэмших эрхийг олж авахын төлөө Компанитай өрсөлдөх эрсдэл гарч болзошгүй. Аливаа ашиг сонирхлын зөрчил бий болсон тохиолдолд ашиг сонирхлын зөрчилтэй байгаа захирал болон албан тушаалтан ашиг сонирхлын зөрчлөө Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хуралд мэдүүлэх шаардлагатай. Ашиг сонирхлын зөрчилтэй ТУЗ-ийн гишүүн болон дарга нь тухайн шийдвэрийн талаар аливаа санал өгөх эрхгүй байна. Зохих тохиолдолд Компани хэд хэдэн захирал, удирдлагатай холбоотой ашиг сонирхлын зөрчилтэй асуудлыг хараат бус захирлуудаас бүрдсэн тусгай хороогоор хянан шийдвэрлүүлнэ.

3.1.8. Валютын эрсдэл

Компанийн санхүүжилтийн дийлэнх нь Канад доллараар хийгддэг боловч үйл ажиллагааны зардал болон бусад зардлууд Монгол төгрөг болон ам.доллараар хийгддэг.

Гадаад валютын ханшийн хэлбэлзэл нь Компанийн санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй. Түүнээс гадна Компани нь Монголын Хөрөнгийн Бирж болон Торонтогийн Хөрөнгийн Биржид давхар бүртгэгдэж байгаатай холбогдуулан валютын эрсдэл гарах магадлалтай. Үүнд Монгол төгрөг чангарах үед Канад доллараар үнэлэгдсэн Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй Компанийн үнэт цаасны үнэ буурах, эсрэгээр өсөх зэрэг эрсдлүүд үүсэх магадлалтай.


3.1.9. Металлын үнийн хэлбэлзэл, түүнээс үүсэх эрсдэл

Уул уурхайн салбар нь хүчтэй өрсөлдөөнтэй салбар тул ашигт малтмалын өндөр нөөц илрүүлсэн ч түүнийг борлуулах ашигтай зах зээл байна гэх баталгаа байхгүй. Компанийн ашигт малтмалыг ашигтай байдлаар олборлох боломжтой болсон үед металлын үнэ өндөр байна гэх баталгаагүй. Энэхүү хүчин зүйлс нь нээж олборлосон аливаа ашигт малтмалын арилжаалагдах байдалд нөлөөлж болзошгүй юм. Металлын үнэ олон улсын эдийн засаг, улс төрийн хандлага, инфляцийн түвшин, дэлхийн болон бүсийн хэмжээний эрэлт хэрэгцээ, валютын ханшийн хэлбэлзэл, хүүгийн хувь хэмжээ, дэлхийн болон бүс



Багш

2018-03-12



нутгийн хэрэглээний хэв маяг, олборлолт, үйлдвэрлэлийн дэвшилтэт аргаас шалтгаалсан эрсдэлтэй үйл ажиллагаа, нэмэгдсэн үйлдвэрлэл зэрэг олон хүчин зүйлээс хамаарч өгцом хэлбэлзэн, өөрчлөгдөж байдаг.

3.1.10. Байгаль орчны болон зохицуулалтын шаардлагууд

Үйл ажиллагаа явуулж буй улс орны байгаль орчны зохицуулалт Компанийн үйл ажиллагаанд үйлчилнэ. Байгаль орчны хууль тогтоомж нь хатуу стандарт, шаардлага тавьж, хууль сахин биелүүлээгүй тохиолдолд өндөр хэмжээний торгууль, төлбөр ногдуулдаг гадна санал болгож буй төслүүдэд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх, аж ахуйн нэгжүүд, тэдгээрийн захирал, албан тушаалтан, ажилтнуудын хариуцлагыг өндөрсгөсөн заалтууд бий болж байна. Цаашид байгаль орчны хууль тогтоомжид орох аливаа нэмэлт, өөрчлөлт нь Компанийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхгүй гэсэн баталгаа байхгүй.

Компанийн үйл ажиллагаатай холбоотойгоор холбогдох тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл авах шаардлагатай болдог. Энэхүү зөвшөөрлүүдийг аваагүйгээс Компани төлөвлөсөн хайгуул, судалгаа, ашиглалтын үйл ажиллагааг хойшлуулах эсвэл хязгаарлах эрсдэл гардаг.

Уул уурхайн компаниудын үйл ажиллагааг зохицуулах одоогийн хууль тогтоомжуудад орох нэмэлт, өөрчлөлт, зохицуулалт, зөвшөөрлүүд, тэдгээрийн хэрэгжилт нь Компанийн материаллаг байдалд нөлөөлж, хөрөнгийн зардлыг нэмэгдүүлж, улмаар олборлолтын шинэ төсөл эхлүүлэх ажлыг хойшлуулж, саатуулж болзошгүй.

3.1.11. Боловсон хүчний эрсдэл

Чадварлаг боловсон хүчин авч ажиллуулах нь Компанийн амжилтад нэн чухал үүрэгтэй. Уул уурхайн төслийн эзэмшил, хайгуул, олборлолтын чиглэлээр туршлагатай боловсон хүчний тоо хязгаарлагдмал, өрсөлдөөн их байдаг. Компанийн үйл ажиллагаа өргөжин тэлэхийн хэрээр санхүү, захиргаа, олборлолт, маркетинг, олон нийттэй харилцах гол мэргэжилтнүүд, ажилтнууд нэмж авч ажиллуулах шаардлагатай болно. Хэдийгээр Компани чадварлаг, туршлагатай боловсон хүчнийг татаж, авч чадна гэдэгтээ итгэлтэй байгаа ч үүнд баталгаа гаргах боломжгүй юм.

3.1.12. Улс төрийн эрсдэл

Монгол Улсын уул уурхайн салбар болон хөрөнгө оруулалттай холбоотой хууль эрх зүйн нөхцөл байдал, улс төрийн тогтворгүй орчноос үүдэн Компанийн үйл ажиллагаанд эрсдэл

2018-03-127



Басарал



үүсэх магадлалтай. Хууль эрх зүйн өөрчлөлтүүд нь Компанийн хяналтаас гадуурх хүчин зүйл юм. Засгийн газрын тогтоол, дүрэм журмууд, үүнд уул уурхайн салбартай холбоотой үнийн зохицуулалт, экспортын зохицуулалт, орлогын албан татвар, өмч эзэмших эрхийг цуцлах, ажлын байр, газрын ашиглалт, усны ашиглалт, байгаль орчинтой холбоотой зохицуулалт болон уурхайн аюулгүй байдалтай холбоотой асуудлууд нь Компанийн үйл ажиллагаанд нөлөөлөх боломжтой. Одоогоор хууль эрх зүйн орчин нь байнгын өөрчлөлт дунд, хэрэгжилт болон үйлчлэх чадвар хязгаарлалттай байна. Компанийн үйл ажиллагаа нь дээрх нөхцөл байдлаас гадна эдийн засаг болон улс төрийн тогтворгүй байдал, бусад улсын хориг арга хэмжээ, терроризм, цэргийн хүч, бослого болон өндөр инфляци, валютын ханшийн өндөр өөрчлөлт зэргээс шалтгаалан эрсдэл хүлээх магадлалтай.

3.1.13. Уламжлалт эрсдлүүд

Уул уурхайн үйл ажиллагааны хайгуул, олборлолтын шатанд аюулгүй байдлын эрсдэл тулгарах магадлалтай. Үүнд үйлдвэр, тоног төхөөрөмж, байгаль орчинд аюул учирч, улмаар хайгуул, олборлолтын гарц, үр дүнд нөлөөлж болзошгүй геологийн өвөрмөц тогтоц, чулуун нуранги, үер болон бусад осол, нөхцөл байдлууд багтана. Хэдийгээр эрсдэлийг бууруулах урьдчилан сэргийлэлтийн арга хэмжээг авдаг ч энэ нь Компанийн үйл ажиллагаа, материаллаг байдалд нөлөөлж болохуйц эрсдэл юм.

3.1.14. Өрсөлдөөн


Уул уурхайн орд, нөөц эзэмших гэсэн өрсөлдөөн өсөн нэмэгдэж байна. Хүчин чадал сайтай, санхүүгийн болон техникийн нөөц боломж бүхий том хэмжээний, тогтворжсон компаниудтай өрсөлдөх магадлалтай бөгөөд үүний дүнд Компани өөрт хүлээн зөвшөөрөгдөх нөхцөлөөр тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл авах, эрх эзэмших боломжүй болох эрсдэлтэй. Үүнтэй адилаар Компани нэмэлт хайгуулын талбайд тусгай зөвшөөрөл, зөвшөөрлийг авч чадна гэсэн баталгаа байхгүй.

3.1.15. Эзэмшлийн хувь буурах

Үнэт цаасны танилцуулгын хүрээнд гаргаж буй Энгийн хувьцааны нэгжийн үнэ нь Энгийн хувьцааны дансны үнээс өндөр тогтоогдоно.


3.2. Эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө

Компани нь эрсдэлийн бодлогын дагуу эрсдэлийн удирдлагын арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэхээр зорьдог. Энэ нь санхүүгийн болон санхүүгийн бус эрсдэлийн удирдлагын



Баерине

2018-03-12



тогтолцооны хүрээнд хэрэгждэг. Эрсдэлийн удирдлагыг үр дүнтэй байлгах хүрээнд дотоод хяналт, бодлого болон журмуудыг тухай бүрт хянан хэрэгжүүлдэг.



2017 онд Компани нь санхүүгийн тайлагналын дотоод аудит болон эрсдэлийн удирдлагын хэрэгжилтийг хянах хүрээнд олон улсын нягтлан бодох бүртгэлийн компаниар (Коллинс Барроу, Collins Barrow) дэлгэрэнгүй дүгнэлт гаргуулсан. Энэхүү дүгнэлтийн хүрээнд Компанийн санхүүгийн тайлагналын дотоод хяналт болон эрсдэлийн удирдлагад аливаа асуудал болон материаллаг алдагдал байхгүй хэмээн дүгнэсэн.

2018 03 12



Баермаа